



Гар бичмэлийн эрхтэй

Очирхуяг БАТСАЙХАН

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕРЫГ СУДАЛСАН НЬ

Мэргэжлийн индекс: **F04130101**

Бизнесийн удирдлагын ухааны доктор
(Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл

Улаанбаатар хот
2023 он



Гар бичмэлийн эрхтэй

Очирхуяг БАТСАЙХАН

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕРЫГ СУДАЛСАН НЬ

Мэргэжлийн индекс: **F04130101**

Бизнесийн удирдлагын ухааны доктор
(Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл

Эрдэм шинжилгээний удирдагч:

Доктор (Ph.D), проф. Ч. Даваабаяр

Доктор (Ph.D), проф. А. Гэлэгжамц

Албан ёсны шүүмжлэгч:

Доктор (Sc.D), проф. Х.Батцэнгэл

Доктор (Sc.D), проф. Л.Оюун

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	
УДИРТГАЛ	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕРЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС	
1.1. Кластерын орчин үеийн онол, үзэл баримтлал	8
1.1.1. Кластерын үзэл баримтлал	8
1.1.2. Кластерын төрөл, ангилал	13
1.1.3. Кластерын онолын хандлага	19
1.1.4. Бүс нутгийн кластер, түүний хөгжил	27
1.2. Жижиг, дунд үйлдвэрийн кластерын тогтолцоо, түүнийг үнэлэх арга зүй	31
1.2.1. Кластерын загвар	33
1.2.2. Гурвалсан холбоост загвар	41
1.2.3. Кластерын амьдралын мөчлөг	49
1.2.4. Кластерын тогтолцоог үнэлэх арга зүй	55
1.3. Жижиг, дунд үйлдвэрийн кластерыг хөгжүүлсэн олон улсын туршлага	59
1.3.1. Бүгд Найрамдах Хятад Ард улс	62
1.3.2. Оросын Холбооны улс	66
1.3.3. Америкийн Нэгдсэн Улс	68
1.3.4. Европын холбоо	73
1.3.5. Олон улсад жижиг, дунд үйлдвэрийн кластерыг урамшуулах арга	76
Нэгдүгээр бүлгийн дүгнэлт.....	78
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕРЫГ ҮНЭЛЭХ НЬ (Сүхбаатар аймгийн жишээн дээр)	
2.1. Жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа	79
2.1.1. Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал	79
2.1.2. Жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдал	82
2.2. Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоог үнэлэх нь	91
2.2.1. Төрийн удирдлагын байдлын үнэлсэн нь	91
2.2.2. Академик (ШУ, боловсрол) байдлыг үнэлсэн нь	99
2.2.3. Жижиг, дунд үйлдвэр (бизнес)-ийн байдлыг үнэлсэн нь	105
2.2.4. Институци хоорондын хамтын ажиллагаа	110
2.2.5. Салбарын PESTLE шинжилгээ	112
2.2.6. Салбарын SWOT шинжилгээ	116
Хоёрдугаар бүлгийн дүгнэлт.....	118

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН
КЛАСТЕРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ**

3.1. Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоонд тулгамдаж буй асуудал	120
3.2. Жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх загвар, санал, зөвлөмж	126
Гуравдугаар бүлгийн дүгнэлт.....	142
ДҮГНЭЛТ	143
НОМ ЗҮЙ	
ХАВСРАЛТ	
ХУРААНГУЙ	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Монгол

ААН	Аж ахуй нэгж
АН	Ардчилсан нам
АНУ	Америкийн нэгдсэн улс
АС	Асгат
АҮ	Аж үйлдвэр
АҮП	Аж үйлдвэрийн парк
АЭЗ	Азийн эдийн засаг
ББДХ	Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо
БД	Баяндэлгэр
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БУ	Баруун-Урт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГҮТББ	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДББГХ	Дэлхийн бараа бүтээгдэхүүний гинжин хэлхээ
ДГ	Дарьганга
ДДҮЦГХ	Дэлхий даяарх үнэ цэнийн гинжин хэлхээ
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДҮС	Дэлхийн үйлдвэрлэлийн сүлжээ
ЕХ	Европын холбоо
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЖДҮҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МАН	Монгол Ардын нам
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МУ	Монгол улс
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим
МХ	Мөнххаан
На	Наран
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
НӨУЁБ	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
Он	Онгон
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУ	Олон улс
ОУСК	Олон улсын санхүүжилтийн корпорац
ОУААН	Олон Үндэстний аж ахуй нэгж
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах орон
СБ	Сүхбаатар

СХ	Статистикийн хэлтэс
ТБ	Төрийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЦ	Түмэнцогт
ТШ	Түвшинширээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБ	Уулбаян
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ҮТП	Үйлдвэр технологийн парк
Х	Халзан
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ХО	Хөрөнгө оруулалт
ХХААГ	Хүнс, Хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ.	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ШУ	Шинжлэх ухаан
ШУП	Шинжлэх ухааны парк
ШУТ	Шинжлэх ухаан технологи
ЭЗ	Эдийн засаг
ЭЗБ	Эдийн засгийн бүсүүд
ЭЗБ	Эдийн засгийн байгууллага
ЭЗХАХБ	Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага
ЭЦ	Эрдэнэцагаан
ЮНИДО	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Үйлдвэр Хөгжлийн байгууллага

Гадаад

EU	Europe Union
FIAT	Fabbrica Italiana Automobili Torino
GRD	Global research develop
IFC	International Financial corporation
IT	Information technology
OECD	Organization for Economic Cooperation and Development
PESTLE	Political Economic Sociological Technological Legal Environment
R&D	Research and Develop
SME	Small, medium-size enterprises
SWOT	Strengths Weaknesses Opportunities Threats
US	United States
WB	World bank

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Эрдэмтдийн үзэл баримтлалын тодорхойлолт, онолын үндэслэл	9
Хүснэгт 2.	Кластерын тодорхойлолт дахь нийтлэг элементүүдийн давталт	11
Хүснэгт 3.	Кластерын онолын хандлага	19
Хүснэгт 4.	Кластер загварууд	34
Хүснэгт 5.	Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцооны элемент	44
Хүснэгт 6.	Кластер амьдралын мөчлөгийн тодорхойлолт, шинж чанар	53
Хүснэгт 7.	Кластер амьдралын мөчлөгийн үе шатыг тодорхойлох үнэлгээний хэмжүүр	57
Хүснэгт 8.	Кластер амьдралын мөчлөгийн үе шатыг тодорхойлох үнэлгээний шалгуур	58
Хүснэгт 9.	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжийн тоо	83
Хүснэгт 10.	Санхүүжилт авсан салбарын байдал	87
Хүснэгт 11.	Сум хөгжүүлэх сангийн зээлийн санхүүжилт	88
Хүснэгт 12.	2022 онд хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлт	88
Хүснэгт 13.	Холбогдох төрийн бодлогын баримт бичиг	91
Хүснэгт 14.	Холбогдох хууль, тогтоомжийн байдал	93
Хүснэгт 15.	Төрийн удирдлагын байгууллагын үнэлгээг нэгтгэсэн байдал	99
Хүснэгт 16.	Салбарын хууль, тогтоомжийн байдал	99
Хүснэгт 17.	Сүүлийн 5 жилээр суралцагчдын мэргэжлийн байдал	102
Хүснэгт 18.	Шинжлэх ухаан/боловсролын байгууллагын үнэлгээг нэгтгэсэн байдал	105
Хүснэгт 19.	Салбарын хууль, тогтоомжийн байдал	106
Хүснэгт 20.	Бизнес, үйлдвэрийн үнэлгээг нэгтгэсэн байдал	109
Хүснэгт 21.	Салбарын гадаад орчны PESTLE+G шинжилгээ	112
Хүснэгт 22.	ЖДҮ-ийн салбарын нөхцөл байдлын SWOT шинжилгээ	114
Хүснэгт 23.	Жижиг, дунд үйлдвэрийн гурвалсан холбоост загварын элемент	124
Хүснэгт 24.	Стратегийн чиглэл (TOWS матриц)	126

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Кластерын тодорхойлолт дахь нийтлэг шинж, элемент	10
Зураг 2.	Кластер төрөл, ангилал	14
Зураг 3.	Кластерын онолын үндэслэл, хүрээ	24
Зураг 4.	Кластерын харилцан ажиллагааны хөгжлийн түвшин	30
Зураг 5.	Гурвалсан холбоост загвар	43
Зураг 6.	Кластер амьдралын мөчлөгийн үе шат	51
Зураг 7.	Хятадын үйлдвэрийн кластер	66
Зураг 8.	АНУ-ын зарим кластерууд	72
Зураг 9.	Сүхбаатар аймгийн эдийн засгийн орон зай	79
Зураг 10.	ДНБ, аймгаар (сая.төгрөг)	81
Зураг 11.	Нэг хүнд ногдох ДНБ (мянган төгрөгөөр)	81
Зураг 12.	ДНБ-д салбарын эзлэх хувь (сая.төг)	82
Зураг 13.	Жижиг, дунд үйлдвэрийн ажлын байр	84
Зураг 14.	Үйл ажиллагаа явуулж буй хугацааны байдал	84
Зураг 15.	Жижиг, дунд үйлдвэрийн боловсруулах үйлдвэрийн байдал	85
Зураг 16.	Жижиг, дунд үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүний байдал	85
Зураг 17.	ЖДҮ дэмжих зээлийн санхүүжилтийн байдал	86
Зураг 18.	Ажлын байрны тоо	86
Зураг 19.	Санхүүжилт авсан байдал	87
Зураг 20.	Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн байдал	89
Зураг 21.	Судалгаанд оролцогчдын салбар, үйл ажиллагааны чиглэл	89
Зураг 22.	Үйлдвэрийн салбарт шинэчлэл шаардлагатай эсэх талаар	89
Зураг 23.	Үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай санхүүжилтийн судалгаа ..	90
Зураг 24.	Экспортод бүтээгдэхүүнээ гаргахад тулгарч байгаа асуудлууд	90
Зураг 25.	Хууль, тогтоомжийн хэрэгжилт, биелэлтийн байдал	95
Зураг 26.	Хөдөлмөрийн зах зээлийн байдал	96
Зураг 27.	МУ-ын 2022 оны нэгдсэн төсөв	97
Зураг 28.	Сүхбаатар аймгийн орон нутгийн худалдан авалт	98
Зураг 29.	Сүүлийн 5 жилээр суралцагчдын тоо (хүйсээр)	101
Зураг 30.	2022-2023 онд суралцагчдын тоо (мэргэжлээр)	101
Зураг 31.	Сүүлийн 5 жилийн байдлаар төгсөгчдийн тоо	103
Зураг 32.	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт	103
Зураг 33.	Сүүлийн 5 жилээр багшийн тоо	104
Зураг 34.	Сүхбаатар аймгийн ЖДҮ	107
Зураг 35.	Жижиг, дунд үйлдвэрийн хуулийн этгээдийн төрөл	108
Зураг 36.	Салбарын гадаад орчны үнэлгээ	113
Зураг 37.	ЖДҮ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал (хувиар)	118
Зураг 38.	Жижиг, дунд үйлдвэрийн гурвалсан холбоост загварын өргөтгөсөн хувилбар	124

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

Аливаа улс орны эдийн засгийн тогтолцооны хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг нь жижиг, дунд үйлдвэр байдаг. Орчин үеийн эдийн засагт харилцан уялдаатай үйлдвэрүүдийн орон зайн төвлөрөл, түүнд чиглэсэн төрийн тусгай бодлого, дэмжлэг, үйл ажиллагаа нь жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн зохион байгуулалтын хамгийн үр дүнтэй хэлбэрийн нэг болж байна.

Дэлхийн туршлагаас харахад аж үйлдвэржсэн улс орон, бүс нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, дотоодын үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний үндэс нь тэдний аж үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлсэнд оршиж байна. Жижиг, дунд үйлдвэрийн кластерыг бүрдүүлэх, хөгжүүлэх нь экспортын чиг баримжааг нэмэгдүүлэх, үндэсний эдийн засгийн импортын хамаарлыг бууруулах, үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүдийг эрчимтэй хөгжүүлэх урьдчилсан нөхцөл болдог. Түүнчлэн жижиг, дунд үйлдвэрийн кластерыг хөгжүүлэх механизм нь бүс нутгийн болон улс орны эдийн засгийн урт хугацааны зорилгыг хангах чиглэлд аж ахуйн нэгж, шинжлэх ухаан, боловсрол, төрийн институтийн бүтцийг зорилготойгоор нэгтгэх, таатай орчноор тодорхойлогддог.

Эрдэмтдийн бүтээлд жижиг, дунд үйлдвэрийн кластер нь аливаа салбар дахь үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн газар зүйн байрлалын төвлөрөл хэлбэрээр хөгжсөн байх бөгөөд хөгжингүй улс орнуудын туршлагаас харахад бүс, орон нутагт үйлдвэрийн кластер хэлбэрээр хөгжүүлэхдээ дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, шинэ үйлдвэрлэл, технологи, менежмент нэвтрүүлэх, мэдлэг урсалт болон түгээлт, зарим тохиолдолд байгаль, хүрээлэн байгаа орчны шаардлагаар үйлдвэрүүдийг том хотуудаас орон нутагт шилжүүлэн, бүсчилсэн хөгжил, дэд бүтэц, ажил эрхлэлт, нийгмийн асуудлыг давхар шийдвэрлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрийн кластерыг хөгжүүлсэн байна.

Үүнээс үзэхэд, үйлдвэрийн кластерыг зах зээлийн жамаар буюу уламжлалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, дэмжлэгийн бодлогоор буюу оролцоо (функциональ)-оор үүсгэж хөгжүүлэх хандлага түгээмэл байгаа байдлыг харгалзан хөгжингүй орнуудын төр, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшил, судалгааны байгууллага болон бусад субъектийн хамтын ажиллагааны хүрээнд жижиг, дунд

үйлдвэрийн кластер хөгжлийн стратеги, бодлогын баримт бичгүүдийг батлуулан хөгжүүлсэн туршлагаас судлах хэрэгцээ байна.

Монгол улсын жижиг, дунд үйлдвэрлэлийн хууль, тогтоомж, хөгжлийн бодлого, үзэл баримтлал зэрэг эрх зүйн баримт бичгүүд олон батлагдсан боловч хэрэгжүүлж үр дүнгээ өгч байгаа байдал нь хангалттай хэмжээнд төдийлөн харагдахгүй байгаа юм. Тэгвэл үйлдвэрлэлийг чөлөөт зах зээлийн эдийн засгийн зарчмын дагуу хууль, тогтоомж, төсөл, хөтөлбөрүүдэд хязгаарлагдахгүйгээр чөлөөт сэтгэлгээгээр шинжлэх ухаан, инновац дээр тулгуурласан, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, жижиг, дунд үйлдвэрийг бүсчлэн, төвлөрүүлж, кластераар хөгжүүлж болно. Үүнд, ялангуяа орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх асуудал, онол, практик аль ч талаасаа шийдлээ хүлээж байгааг дурдах нь зүйтэй.

Иймд Монгол улс бүс, орон нутгийн эдийн засгийн байдлаа сэргээхийн тулд жижиг, дунд үйлдвэр дээрээ тулгуурлан кластераар хөгжих нь гадаад, дотоодын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлд шинэ технологи, инновац нэвтрүүлэх, мэдлэг урсалт явагдах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд нэн чухал гэж үзэж энэхүү сэдвийг сонгон авсан болно.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдлыг Сүхбаатар аймгийн жишээн дээр судалж, түүнийг кластераар хөгжүүлэх загвар, санал, зөвлөмжийг боловсруулахад чиглэсэн болно.

Судалгааны ажлын зорилт

Дээрх зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Орчин үеийн удирдахуйн ухаан, бизнесийн удирдлагын чиглэлээр кластерын орчин үеийн онол, үзэл баримтлалыг судлах;
- Жижиг, дунд үйлдвэрийн кластерын тогтолцоо, түүнийг судлах арга зүйг тодорхойлох;
- Жижиг, дунд үйлдвэрийг кластер хөгжлийн олон улсын туршлагыг судлах;
- Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийн нөхцөл байдлын тойм судалгаа, кластерын тогтолцоонд үнэлгээ өгөх;
- Жижиг, дунд үйлдвэрийн кластерын тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн загвар, санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны ажлын материал

Marshall A. 1890, Porter M. 1990, Krugman 1991, Enright M.J. 1992, Baptista, Swann, 1998, Feser E.J., Bergman E.M. 2000, Malmberg, Maskell, Карлино, 2001, Etkowitz 2002, Sölvell 2003, Т.В.Цихан 2003, Andersson T., Моросини, 2004, Schwaag-Serger S., Sörvik J., Wise Hansson E. 2004, Шаститко А.Е. 2009, Fleisher B., Hu D., McGuire W., Zhang X. 2009, M. P. Menzel D. Fornahl 2010, Б.С.Анатольевна 2016, Sergey Sosnovskikh 2017, К.И.Васильевна 2017, Saglar B. Boldyreva, Atabek K. Alimov, Rustem T. Adilchaev, Danara V. Idzhilova, Natalya E. Chadlaeva 2020, Р.А.Станиславовна 2022 нар кластерын онол, инновац, кластерын загвар хөгжил, бүс нутгийн кластерын хөгжил, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, зохион байгуулалт, төлөвлөлтийг боловсронгуй болгох, бүтцийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрийн салбарын хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлого, хэтийн төлөвийг тодорхойлох, үнэлэх аргачлалыг судалсан нэг сэдэвт бүтээлүүд;

Сүүлийн жилүүдэд Монгол улс болоод орон нутагт жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиглэлээр бодлогын баримт бичгүүд боловсруулагдаж нэлээдгүй судалгаа авагдсан байдаг бөгөөд Хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө (ХААИС, ШУТИС-ийн хамтарсан судалгааны баг, 2008), Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, “Мал аж ахуйн гаралтай түүхий эд (мах, сүү, арьс шир, ноос ноолуур болон бусад)-ийг боловсруулах бүс нутгийн хэмжээний аж үйлдвэрийн цогцолборуудыг байгуулж хөгжүүлэх оновчтой байршлыг тогтоох нь” сэдэвт техник эдийн засгийн урьдчилсан судалгаа (ЭЗХЯ, 2012), “Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” (Түүвэр судалгааны үр дүн, Монгол банк, 2018), “Ковид-19” Цар тахлын дараах бизнесийн орчин: сорилт ба боломж” (МҮХАҮТ, Эдийн засгийн шинжээчдийн клуб, 2020), “Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн Үндэсний хэмжээний санал асуулгын судалгааны тайлан” (Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, 2020) “Цар тахал-Бичил бизнес эрлэгчдэд үзүүлж буй нөлөө-2020” (ХБНГУ-ын Фридрих Эбертийн сан), “Монголын бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөний үнэлгээ” (Азийн сан, Хараат бус Судалгааны Хүрээлэн, 2021), “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санал” (НҮБ-ын Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх стратегийн төсөл, 2022) зэрэг баримт бичгүүд;

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль (2006), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996), Өрсөлдөөний тухай хууль (2010), Инновацын тухай хууль (2012), Технологи дамжуулах тухай (1998), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай (2006), Дээд боловсролын тухай (2022), Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль (2015), Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (2019), Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль (2022), Хөрөнгө оруулалтын тухай (2013), Татварын ерөнхий хууль (2019), Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай (2019), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай (2020) зэрэг эрх зүйн баримт бичгүүд;

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020), Гурван тулгуурт хөгжлийн бодлого (2018), Шинэ сэргэлтийн бодлого (2020), Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020), Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (2023-2037), Сүхбаатар аймгийн хөгжлийн зорилт 2020-2028 хөгжлийн бодлогын баримт бичиг (2019), Сүхбаатар аймагт 2021-2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, тэргүүлэх чиглэл (2021), Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2020), Сүхбаатар аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичгүүд, Олон улсын байгууллагуудаас эрхлэн гаргасан ном, гарын авлага, тайлан, статистик мэдээ, судалгааны өгөгдлийг практик хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

Судалгааны ажлын арга

Энэхүү судалгааны ажилд баримтын судалгаа, агуулгын шинжилгээ, эх сурвалжийн харьцуулалтын арга, логик тайлбарын арга, асуулга судалгаа, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, экспертийн үнэлгээний арга болон математик статистик, SWOT, PESTLE шинжилгээ, TOWS матриц зэрэг тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигласан.

Судалгааны шинэлэг тал

Энэхүү ажлын шинэлэг тал нь сонгодог агломерацийн онол, газар зүйн эдийн засаг буюу шинэ эдийн засгийн газар зүй, чөлөөт тусгай сургууль, бүс нутгийн инновацын тогтолцоо, өрсөлдөх чадвар, динамик гадаад байдал, системийн онолын хандлага болон кластерын тогтолцооны 10 загварыг эш үндэс болгон

дэлхийн хөгжингүй улс орнуудын үйлдвэрийн кластер хөгжүүлсэн туршлага, Монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн кластерын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, түүнийг хөгжүүлэх боломжийг судалж байгаагаараа шинэлэг болох талтай.

Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол

Энэхүү судалгааны ажил нь жижиг, дунд үйлдвэрийн кластерыг тогтолцооных нь хувьд орчин үеийн олон шинжлэх ухааны зааг уулзвар дээр судалж, гурвалсан холбоост загварыг өргөтгөж, шинжлэх ухааны эргэлтэд оруулахад тустай гэж үзэж байна.

Судалгааны материалын үр дүнг төр засаг, орон нутгийн холбогдох байгууллага болоод хувийн хэвшил, төрийн бус байгууллага, холбоод, агентлаг, их дээд сургуулиуд, судлаачид, хувь хүн ашиглах боломжтой хэрэглэгдэхүүн болж байгаа нь ач холбогдолтой юм.

Судалгааны ажлыг хэлэлцүүлсэн байдал

Судалгааны ажлыг Монгол Улсын Эрдмийн Их сургуулийн бизнесийн удирдлагын профессорын багийн Их семинараар 3 удаа, профессорын багийн өргөтгөсөн Их семинараар 1 удаа тус тус хэлэлцүүлж, эрдэм шинжилгээний хурал семинарт 2 илтгэл тавьж, эрдэм шинжилгээний өгүүлэл 4, ном товхимол 6 гарын авлага хэвлэн нийтлүүлсэн болно.

Судалгааны ажлын бүтэц

Энэхүү судалгааны ажил нь 3 үндсэн бүлэг, 7 зүйл, дүгнэлт, ном зүй, хавсралт, abstract зэргээс бүрдсэн.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕРЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС

1.1. Кластерын орчин үеийн онол, үзэл баримтлал

Дэлхийн эдийн засгийн хөгжлийн тулгуур нь жижиг, дунд үйлдвэрлэл бөгөөд түүнийг бодлогоор хөгжүүлэх нь улс орны эдийн засгийн нэн тэргүүний зорилтуудын нэг юм. Жижиг, дунд үйлдвэрүүдийг төвлөрүүлж хөгжүүлэх нь үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалт, шинэ мэдлэг, технологи, ажлын байр нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахын зэрэгцээ нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх болсон.

Улс орнуудын үйлдвэрийн хөгжлийн эмпирик судалгаанаас харахад жижиг, дунд үйлдвэрийн “кластер” хөгжлийн асуудал урган гарч ирэх бөгөөд “кластер”-ын тухай ойлголтыг судлан тодорхойлох хэрэгцээ байна. Иймд Кембриджийн толь бичигт “Кластер” гэдэг үгийг “ижил төстэй зүйлс буюу хүмүүс хоорондоо ойролцоо байр суурь эзлэх буюу болж буй хэсэг бүлэг” хэмээн тодорхойлсон байна.

1.1.1. Кластерын үзэл баримтлал

Кластер “cluster” гэсэн ойлголт эдийн засгийн онол, үзэл баримтлал, практикт 1890 онд А.Маршал “Эдийн засгийн үндэс” бүтээлдээ “Аж үйлдвэрийн дүүргүүд” хэмээн ижилсүүлэх хандлагад тулгуурлан бүсийн кластерыг тодорхойлсон байдаг бол эдийн засгийн өрсөлдөх чадварыг кластерын хандлагаар цэгцтэй үзэл баримтлалыг анх Америкийн Харвардын их сургуулийн профессор Майкл Портер дэвшүүлсэн бөгөөд 1990 онд хэвлүүлсэн “Улс орнуудын өрсөлдөөний давуу тал” номондоо улсын болон бүс нутгийн өрсөлдөх чадварыг дэлхийн эдийн засгийн хөгжилтэй уялдуулан авч үзэж кластерын онолын үндэс суурийг тавьсан гэж үзэж болно. Тэрээр 1998 онд хэвлүүлсэн “Өрсөлдөөн” номондоо *“Кластер нь газар зүйн байршилдаа тулгуурлан хэлхээ холбоо тогтоон бөөгнөрч нэгдсэн компаниуд, тэдгээрт бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгч тухайн салбарын бусад компани, түүнчлэн тэдгээр компанийн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд тодорхой салбарт өрсөлдөөн байдгийн зэрэгцээ мөн хамтран ажиллаж байдаг байгууллагуудаас бүрддэг”* гэсэн тодорхойлолтыг өгсөн байдаг (Porter, 1990). М.Портер нь кластерын тухай онолын гол төлөөлөгч бөгөөд “кластер буюу аж үйлдвэрийн бүлэг” гэсэн хорь гаруй тодорхойлолтын зохиогч юм. Түүний тодорхойлолтоор “кластер буюу аж үйлдвэрийн бүлэг нь газар зүйн хувьд хөрш

зэргэлдээ компани болон тодорхой салбарт үйл ажиллагаа явуулдаг, бие биеэ нөхөн сэргээдэг онцлогтой, газар зүйн хувьд ойр зэргэлдээ компаниуд болон холбогдох байгууллагуудын бүлэг юм" (Porter, 2006) хэмээн үзсэн.

Кластерын тухай ойлголтыг түүхэн цаг хугацаануудад эрдэмтэн, судлаачдын дэвшүүлсэн тодорхойлолтыг дараах Хүснэгт 1-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 1. Эрдэмтдийн үзэл баримтлалын тодорхойлолт, онолын үндэслэл

Он	Эрдэмтэн	Дэвшүүлсэн үзэл баримтлал	Шинж	Онолын үндэслэл
1890	Marshall.A	Агломерацийн давуу тал нь орон нутгийн эдийн засгийн гурван багцаас үүдэлтэй бөгөөд энэ нь тусгай ур чадвартай ажилчдад зориулсан зах зээлийн тусгай оролт, үйлчилгээний хүртээмж, технологийн урсалт юм.	-тусгай ур чадвартай ажилчдад зориулсан зах зээлийн тусгай оролт -Үйлчилгээний хүртээмж, технологийн урсалт	Агломерацийн онол
1990	Porter. M	Кластер нь газар зүйн байршилдаа тулгуурлан хэлхээ холбоо тогтоон бөөгнөрч нэгдсэн компаниуд, тэдгээрт бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгч тухайн салбарын бусад компани, түүнчлэн тэдгээр компанийн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд тодорхой салбарт өрсөлдөөн байдгийн зэрэгцээ мөн хамтран ажиллаж байдаг бусад байгууллагуудаас бүрддэг	-Холбоо тогтоон нэгдсэн компаниуд -Тодорхой салбарт өрсөлдөөн -Хамтран ажиллаж байдаг байгууллагуудаас бүрддэг	Кластерын онол
1890, 1991	Marshall, Krugman,	-Санхүү, цаг хугацаа -Мэргэшсэн ажиллах хүчний томоохон нөөц ажиллах хүчээс бүрдэнэ -Мэдээллийг илүү хялбар, хурдан дамжуулах гэх мэт....	-Мэргэшсэн ажиллах хүчний томоохон нөөц	Кластерын онол
1992	Enright M. J.	Бүс нутгийн оролцогч фирмүүд хоорондоо ойрхон байдаг аж үйлдвэрийн кластер юм.	-Бүс нутгийн бөөгнөрөл	Агломерацийн онол
2004	Григорьев, Kryukov	Кластер нь "өрсөлдөөний өсөлтөд хувь нэмрээ оруулдаг, инновацийн "локомотив", дотоодын зах зээлийн өсөлтийн цэгүүд болон олон улсын тэлэлтийн үндэс болдог нягт холбоотой салбарын фирмүүдийн нийгэмлэгүүд" юм	-Дотоодын зах зээлийн өсөлтийн цэгүүд -Олон улсын тэлэлтийн үндэс	Кластерын онол
2007	Клейнер Г. Б., Качалов Р. М., Нагрудная Н. Б.	Кластер нь үйлдвэрлэлийн салбарт нутаг дэвсгэрийн ойр, үйл ажиллагааны хамаарал, түүний борлуулалт буюу нөөц баялгийг ашиглахтай холбогдсон байгууллага (компани, аж ахуйн нэгж, дэд бүтцийн	-Нутаг дэвсгэрийн ойр, үйл ажиллагааны хамаарал, түүний борлуулалт буюу нөөц баялгийг ашиглахтай	Агломерацийн онол Кластерын онол


		байгууламж, судалгааны институт, их сургууль г.м)-ийн бүлэг	холбогдсон байгууллага	
--	--	---	------------------------	--

(Эх сурвалж: Горилогчийн нэгтгэл)

Кластер нь бизнесийн холбогдох чиглэлд хамаарах байгууллагууд, хамтын ажиллагаатай аж ахуй нэгжүүдийн орон зайн төвлөрөл гэж үзэж болох юм. Тэдгээр нь хооронд хүчтэй чухал холбоос үүсэх бөгөөд бие биеэ нөхөж нэгтгэж байдаг. Кластер нь нэр, томъёоны үүднээсээ бөөгнөрүүлэн, төвлөрүүлэн хөгжих үйл явц бөгөөд бизнес эрхлэгчид болоод үйлдвэрийн том, жижиг, аж ахуй нэгжүүд нэг дор байрласнаар харилцан туршлага солилцож хамтран ажиллахад хоорондын харилцаа холбоо, хамтын болоод багийн ажиллагаанд чухал гэдэг нь харагдаж байна.

Эрдэмтэн, судлаачдын томъёолсон кластерын талаарх үзэл, тодорхойлолтуудын элементийн нэгдлээс түүний мэдлэг, ойлголтын талаарх нийтлэг шинжийг Зураг 1-т харуулав.

Зураг 1. Кластерын тодорхойлолт дахь нийтлэг шинж, элемент



(Эх сурвалж: Clemente Hernandez, Raul Montalvo, "Entrepreneurial Clusters in China and Mexico – implications for Competitiveness, 2012)

Эдийн засгийн орон зайн онолын үүднээс кластерын үүсэл, үйл ажиллагааны чиг хандлагыг судлах үндэс болж, бүс нутагт бизнес эрхлэх үйл ажиллагааг хөгжүүлэх нь тэдгээрийн үндсэн загваруудыг илүү гүнзгий тодорхойлж, үйл ажиллагааны талаар хангалттай үнэлэлт, урьдчилан тооцоо хийх боломжийг бидэнд олгодог. Үүнээс гадна, кластерыг бий болгох нь тухайн улсын нутаг дэвсгэрийн эдийн засгийн чадавхи, нөөц, хүн ам, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн хөдөлгөөнийг хурдасгахад бодитой хувь нэмэр оруулдаг. Ийнхүү нэг талаас агломераци, кластерын хөгжил нь үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн эрчимтэй өсөлтийг өдөөдөг.

Хүснэгт 2. Кластерын тодорхойлолт дахь нийтлэг элементүүдийн давтамж

№	Кластер элементүүд	Давтамж				
		1	2	3	4	5
1	Мэдлэг, технологийн урсгалт (инновац)	+	+	+	+	+
2	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн сүлжээ	+	+	+		
3	Хямд хөдөлмөр	+				
4	Тээврийн зардал хэмнэлт	+	+			
5	Эрсдэл бууралт	+				
6	Ажил үүргийн уялдаа холбоо	+	+	+	+	+
7	Салбарын өрсөлдөөн	+	+			
8	Хамтын ажиллагаатай байгууллагууд	+	+	+	+	+
9	Туршлага дамжуулах	+	+			
10	Мэргэшсэн ажиллах хүчний нөөц	+	+			
11	Ашиг орлого	+	+	+		
12	Бүс нутаг (орон зай)-ийн бөөгнөрөл /агломераци/	+	+	+	+	+
13	Байгууллагын албан болон албан бус харилцаа	+	+			
14	Зах зээлийн өсөлтийн цэгүүд	+				
15	Олон улсын тэлэлт	+				
16	Нийгмийн нийгэмлэг	+				
17	Эдийн засгийн төлөөлөгчид	+				

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Кластерын үзэл баримтлалын тодорхойлолтод мэдлэг, технологийн урсгал, инновац, ажил үүргийн уялдаа холбоо, бүс нутгийн орон зайн бөөгнөрөл, хамтын ажиллагаатай байгууллагууд гэсэн элементүүд нийтлэг байна (Хүснэгт 2).

Дээрх кластерын тодорхойлолт, үзэл баримтлалд тулгуурлан кластерын ялгаатай талыг дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

Нэгдүгээрт, аж үйлдвэрийн кластер нь "нийгмийн сүлжээ" болон ердийн агломерацийн загваруудаас ялгаатай нь аж ахуйн нэгжүүд хоорондын эрчимтэй мэдлэгийн харилцан үйлчлэлийг багтаадаг бөгөөд энэ нь ихэнхдээ аж ахуйн нэгж доторх харилцаанаас илүү ойр байдаг. Тодорхой газар зүйн бүсэд нэгэн зэрэг хамтран ажиллах, өрсөлдөх чадвар нь өндөр хөгжсөн нийгмийн бүтцийг бий болгохыг шаарддаг бөгөөд энэ нь мэдлэг, харилцааны солилцоог хослуулахад дөхөм болж, эдийн засгийн субъектүүдийн нийтлэг шинж чанарыг дэмждэг.

Хоёрдугаарт, аж үйлдвэрийн кластерт эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой тусгай ур чадвар буюу мэдлэг бүхий эдийн засгийн субъект – хуулийн этгээд, хувь хүмүүсийн аль аль нь багтана. Эдгээр эдийн засгийн субъектүүд нь их дээд сургууль, судалгааны төв, аж үйлдвэрийн холбоо, технологийн институт зэрэг байгууллагуудыг үүсгэн байгуулдаг бөгөөд энэ нь харилцан эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих, технологийн мэдлэгийг аж үйлдвэрийн кластерын гишүүдийн дунд түгээхэд түлхэц болдог.

Гуравдугаарт, кластер нь аж ахуйн нэгжийн орон зайн төвлөрлийн тодорхой хэлбэр бөгөөд үүний хамтын үйл ажиллагаа нь тодорхой агломерацийн гадаад байдал, өөрөөр хэлбэл гадаад үр дагавар гарч ирэхийг шаарддаг. Энэхүү харилцан үйлчлэлийг хангахын тулд кластерыг хооронд нь холбож, янз бүрийн бүтцийн оролцогчдийн нийгмийн нэгдэл, үндсэн мэдлэгийг нэгтгэн соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны хил хязгаарыг даван гүйцэтгэдэг "нийгмийн цавуу" гэж нэрлэгддэг.

Дөрөвдүгээрт, аж үйлдвэрийн кластер нь зах зээлд худалдан авагчдад өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох явдал гэдгийг онцолж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд аж үйлдвэрийн кластерууд нь дараах шинж чанартай байх ёстой: удирдлага, бүтцийн элементүүд, харилцаа холбоо, мэдлэг шилжүүлэх үйл явц юм. Кластерт нэгдсэн аж ахуйн нэгжийн өрсөлдөөний гол хүчин зүйл нь гадаад, дотоод, нийгмийн хүчин зүйлс юм.

Кластер нь зөвхөн бизнесийн нэг шугамд үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс бүрдэж эсвэл бүрэн нэмүү өртөг, үнэ цэнийн сүлжээнд багтаадаг оролцогчдын тоо болон тэдний зохион байгуулалтын хэмжээнд харилцан адилгүй байдаг. Эрдэмтдийн бүтээлээс кластерын судалгаанд үзэл баримтлалын үндсэн 4 чиглэл байгааг харж болно Маршалл, Кругман, Малмберг, Солвелл, Зандер (Marshall.A, 1890, Кругман, 1991, Malmberg, Solvell, Zander, 1996). Үүнд:

- Хязгаарлагдмал бүс нутагт төвлөрөх;
- Үйл ажиллагааны чиглэл, нэмүү өртгийн сүлжээгээр нэгтэх;
- Урт хугацааны үнэ цэнийг бүтээх;
- Шинэ мэдлэг, инновацыг дээдлэх.

Иймд аж ахуйн нэгжүүдийн инновацын бүтээмж (Baptista and Swann, 1998) нь мэдлэгийн хувьд нэгэн төрлийн байдлаар тодорхойлогдох бус бусад аж ахуйн нэгжүүдтэй ойр байх, ижил чиглэлээр ажилладаг, нэмүү өртгийн сүлжээнд түншүүд, компаниуд болон тэдгээрийн үйлчлүүлэгчдийн хооронд эсвэл аж ахуйн нэгж, судалгааны байгууллагуудын хооронд шууд болон албан бус мэдээлэл дамжуулах зэргээс шалтгаалан инновацын үйл явц, үргэлжлэх хугацааг тодорхойлдог Малмберг, Солвелл, Зандер (Malmberg, Solvell, Zander, 1996). Үйлдвэрийг кластераар хөгжүүлэх нь орон нутагт эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зэрэг олон таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Үйлдвэрийн кластерт оролцогч аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдлэгийн интеграцийн түвшин өндөр байх тусам тэдний дэлхийн түвшний өрсөлдөх түвшин чадвар өндөр дээшилдэг байна.

1.1.2. Кластерын төрөл, ангилал

Кластер судлалын эрдэмтдийн үзэл баримтлалын тодорхойлолтоос хамааран, түүнийг төрөл, ангилалд авч үзэж болно. Тухайлбал, кластерыг нэмүү өртгийн сүлжээ эсвэл ажиллах хүчнээс нь хамааруулан ангилж болно. Зарим эрдэмтэд (Кетелс, 2003) кластерыг санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, газарзүйн байршил, нэмүү өртгийн сүлжээний тодорхой үе шатанд мэргэшсэн байдал, хөгжлийн үе шатаар нь ангилдаг. Газарзүйн янз бүрийн байршилд өөр өөр үүрэг гүйцэтгэдэг. Жишээлбэл, Нью-Йоркийн санхүүгийн кластер, Холливудын медиа кластер, Мэдээллийн технологийн Цахиурын хөндийн кластер, Детройт болон Германы өмнөд хэсэгт байрлах автомашин үйлдвэрийн кластер гэх мэт... Тэдний нэмүү өртгийн сүлжээний тодорхой үе шатанд мэргэшсэн байдал нь Португалийн богино хэмжээний үйлдвэрлэл, Хятад дахь үйлдвэрлэл, Итали дахь гутлын загвар зэрэг жишээнүүдийг авч үзэж болно. Бид хөгжлийн үе шатыг гадаад бизнесийн орчны чанар, байгаль орчны хамтын ажиллагааны ахиц дэвшлийг багтаасан гэж ойлгож байна.

Кластерын хэмжээсийг үйлдвэрлэлийн холболт, газарзүйн өргөтгөл, амьдралын мөчлөг, оролцогчдын хоорондын уялдаа холбоогоор тодорхойлж болно (Кортрайт, 2006). Үйлдвэрүүдийн холболтууд нь худалдан авагч ба нийлүүлэгчийн харилцаа, өртгийн сүлжээгээр тодорхойлогддог. Нийлүүлэгч болон худалдан авагчдын ойролцоо нягт сүлжээтэй бол давуу тал болно. Газарзүйн цар хүрээ нь хот, бүс нутгийн болон жижиг кластерыг заадаг. Тиймээс кластер ангиллыг элементүүдийн хамаарлын байдлыг зургаар харуулав (Зураг 2).

Зураг 2. Кластер төрөл, ангилал



(Эх сурвалж: Clemente Hernandez, Raul Montalvo, "Entrepreneurial Clusters in China and Mexico – implications for Competitiveness, 2014)

1. Хөгжлийн үе шат буюу хувьслаар

Хөгжлийн үе шатаар нь ангилбал кластер нь *боломжит кластер, нуугдмал кластер эсвэл ажлын кластер* байж болно (Isbasoiu, 2007). Боломжит кластерын хувьд сайн боломжууд байдаг бөгөөд зарим гол элементүүд бэлэн болсон байдаг.

Нуугдмал кластер нь аж ахуйн нэгжүүдийн тоо ихтэй боловч итгэлцэл дутмаг, хамтын ажиллагаа бага, гүйлгээний зардал өндөр зэргээс шалтгаалан харилцан үйлчлэлийн түвшин бага байдаг бүс нутагт байдаг. Ажлын кластерт аж үйлдвэрийн дүүрэг сайн хөгжсөн байдаг. Хөгжлийн үе шатаар кластер нь *амьд үлдэх кластер, дэвшилтэт масс үйлдвэрийн кластер эсвэл үндэстэн дамнасан корпорациудын кластер* байж болно Алтенбург ба Мейер-Штамер, Шмитц, Надви (Altenburg and Meyer-Stamer, 1999, Schmitz and Nadvi, 1999). Амьд үлдэх кластеруудын өрсөлдөх чадвар хязгаарлагдмал. Тэд бизнес эрхлэгчдийн өрсөлдөөн, динамикаас үүдэлтэй макро эдийн засгийн таагүй нөхцөл байдлаас үүдэлтэй байдаг. Үндэстэн дамнасан аж ахуй нэгжүүдийн кластерууд нь бүс нутгийн эдийн засгийг татахын тулд техникийн дэвшилтэт гадаадын аж ахуй нэгжүүдээс бүрддэг, тодорхой газар нутагт

байрладаг. Харин дотоодын аж ахуй нэгж, байгууллагуудтай хязгаарлагдмал харилцаатай байдаг. Масс үйлдвэрлэлийн дэвшилтэт кластерт аж ахуй нэгжүүд дотоодын зах зээлд зориулж үйлдвэрлэдэг боловч дэлхийн өрсөлдөөний дарамттай улам бүр тулгарч байдаг.

Кластер ангиллыг хөгжлийн үе шатаар нь *анхдагч, төлөвшсөн кластер* байж болно (Шмитц, Надви, 1999). *Анхан шатны кластер нь аж үйлдвэрийн хөгжлийн эхний шатанд байгаа бөгөөд ихэвчлэн ядуу, буурай газар нутагт байрладаг бөгөөд энгийн технологи, хөдөлмөрийн ур чадвартай орон нутгийн зах зээлд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Төлөвшсөн кластер нь технологи, ур чадварын хувьд илүү дэвшилтэт аж ахуй нэгжүүдээс бүрддэг. Тэд дэлхийн зах зээлд зориулж үйлдвэрлэдэг бөгөөд дэлхийн дарамтад өртөмтгий байдаг* (Isbasoiu, 2007). Кластерын амьдралын мөчлөгийн дагуу кластерууд шинээр гарч ирж буй, өсөн нэмэгдэж байгаа, тогтвортой, боловсорч гүйцсэн, буурч байгаа эсвэл төсөөлөлтэй байж болно. Шинээр гарч ирж буй кластерууд нь ихэвчлэн хурдацтай өсөлттэй, аж ахуй нэгж, бүтээгдэхүүнүүд байнга өөрчлөгддөг олон шинэ аж ахуй нэгжүүд аж ахуй нэгжүүд аж ахуй нэгжүүдээс бүрддэг. Тогтвортой кластерууд өсөлт удаашралтай, өөрчлөлт багатай хэд хэдэн том аж ахуй нэгжийг оролцуулдаг. Буурч буй кластерт ажил эрхлэлтийн түвшин зогсонги байдалтай, олон хаалт, өөрчлөлт багатай байдаг. Төсөөллийн кластерын амьдралын мөчлөг нь бизнес эрхлэгчид салбарын кластер үүсгэхийг оролдох үед үүсдэг. Оролцогчид өөрсдийгөө кластерын нэг хэсэг гэдгээ мэддэг эсвэл мэдэхгүй байж болно.

2. Аж ахуй нэгж хоорондын харилцаа, үйлдвэрийн холболтоор

Аж ахуй нэгжүүд болон аж үйлдвэрийн байгууллагуудын хоорондын харилцааны хувьд кластер нь орчин үеийн буюу маршал, төв болон сүлжээ, орон зайн платформ, төр төвтэй худалдах, худалдан авах харилцааны кластер байж болно (Markusen, 1996). Маршалын аж үйлдвэрийн дүүргүүд нь хоорондоо өрсөлдөж, жижиг гүйлгээ хийдэг боловч санаатайгаар хамтран ажилладаггүй бараг тэнцүү аж ахуй нэгжүүдийн бүлгүүд юм. Төв болон сүлжээний (түгээх болон холболтын төвүүд) дүүргүүдэд дотоодын ханган нийлүүлэгчдийн томоохон зах зээлийг бүрдүүлдэг, ерөнхийдөө тэдний харилцааны нөхцөлийг бүрдүүлдэг нэг том аж ахуй нэгж давамгайлдаг. Орон зайн платформын дүүргүүд нь ихэвчлэн илүү том, автарк шинж чанартай, хямд хөдөлмөр эрхэлдэг, эсвэл зах зээлд ойртож байдаг

салбар байгууламжуудын цуглуулга юм. Цэргийн үйл ажиллагаа эсвэл засгийн газрын судалгааны лаборатори зэрэг засгийн газрын зардлаар оршин тогтнох өртэй дүүргүүдийг муж улсын зангуутай дүүрэг гэнэ. (Кортрайт, 2006, Гордон, МакКэнн, 2000) Аж үйлдвэрийн цогцолборын загварт аж ахуй нэгжүүдийн хоорондын тодорхой, тогтвортой харилцааны багц байдаг бөгөөд тэдгээр нь орон зайн зан үйлд тодорхой хэмжээгээр илэрдэг. Нийгмийн сүлжээний загварт итгэлцэлд суурилсан зан үйл, шилжилтийн хувийн харилцаа байдаг.

3. Шинжилгээний түвшин буюу газарзүйн өргөтгөлөөр

Шинжилгээний түвшингээр кластер нь үндэсний түвшин, бүс буюу аж үйлдвэр эсвэл компанийн түвшинд байж болно (Roelandt, 1999). Үндэсний түвшин (эсвэл макро түвшин) нь бүхэл бүтэн аж үйлдвэрийн бүлгүүдийн сүлжээг хэлдэг. Аж үйлдвэрийн түвшинд (мезо) аж үйлдвэр хоорондын болон дотоод сүлжээнүүд нь ижил төстэй эцсийн бүтээгдэхүүн бүхий үйлдвэрлэлийн гинжин хэлхээний өөр өөр үе шатанд суурилдаг. Компанийн түвшинд (микро) мэргэшсэн ханган нийлүүлэгчид төв бизнесийн эргэн тойронд байдаг бөгөөд компаниудын нэгдэл байдаг.

4. Хөгжлийн үе шатууд буюу нийцэл

Хөгжлийн үе шатаас хамааран кластерууд нь удаан бий болох эсвэл стратегийн бүтээл гэж ангилагдана (Кетелс, 2003). Үндсэн түүхий эд нь ойрхон байдаг тул аяндаа бий болсон бүтээлийг нэгтгэхэд олон жил шаардагдана. Энэ нь хүрээлэнгүүдийн хөрөнгө оруулалт татдаг компани, их дээд сургуулиуд гэж хэлдэг. Нөгөөтээгүүр, стратегийн хувьд кластер байгуулах нь Засгийн газар, бизнес, санхүүгийн хандивлагчид гэсэн гурван талт холбоог хурдан хөгжүүлдэг.

5. Нэмүү өртгийн сүлжээнд нэгтгэх замаар

Нэгдмэл байдлын дагуу кластерууд нь босоо болон хэвтээ байж болно (Isbasoiu, 2007). *Босоо интеграци* гэдэг нь худалдагч-худалдан авагчийн харилцаагаар нэгдсэн салбаруудыг хэлнэ. Нийтлэг зах зээл, технологи, ажиллах хүчний ур чадвар, эх үүсвэрийг хуваалцдаг салбарууд байгаа тохиолдолд *хэвтээ интеграци* үүсдэг. Өртгийн сүлжээнээс хамааран кластеруудыг технологийн кластер (технологийн хөгжил) эсвэл үйл ажиллагааны кластер (үйлдвэрлэлийн менежер) гэж ангилж болно (Amano, 2006).

6. Мэдлэгийн түвшингээр

Мэдлэгт тулгуурласан кластер нь технологийн кластер эсвэл мэдлэгт суурилсан түүхэн кластер байж болно (Isbasoiu, 2007). Технологийн кластер нь өндөр технологид чиглэсэн бөгөөд мэдлэгийн эдийн засагт сайн зохицсон. Түүхэн мэдлэгийн кластерууд нь олон жилийн турш мэдлэг (үйл ажиллагааны туршлага) давуу байдлаа хадгалсан уламжлалт үйл ажиллагаанд суурилдаг.

7. Бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Үйлдвэрээс үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр бид автомашин, санхүүгийн үйлчилгээ, аялал жуулчлал болон бусад олон салбарыг жишээ болгон авч болно.

8. Эрэлт, зах зээлийн өргөтгөлөөр

Кластерыг хөгжлийн үе шатаар нь худалдаанд суурилсан кластер эсвэл мэдлэгт суурилсан кластер гэж ангилж болно Жонстон (Johnston, 2003). Худалдаанд тулгуурласан кластерт кластеруудын бизнесийн боломжууд нь хэвтээ эсвэл гало /гэрлийн тойрог/ хэлбэртэй байна. Бизнесийн хэвтээ боломжууд нь ижил эцсийн бүтээгдэхүүний зах зээлд байдаг бөгөөд судалгаа, хөгжүүлэлт, хамтын маркетинг, худалдан авалт зэрэг өрсөлдөөний өмнөх үйл ажиллагаанд хамтран ажилладаг. Гало боломжууд нь олон ханган нийлүүлэгчдийг татдаг хүчирхэг, эрэлт хэрэгцээтэй худалдан авагчдыг хамардаг. Мэдлэгт суурилсан кластерт суралцах боломж төрийн болон хувийн эх сурвалжаас ирдэг. Хувийн эх сурвалжууд олон фирмүүдийн мэдлэгийг сонирхож байна. Олон нийтийн эх сурвалжууд төрийн салбарын талаархи байгууллагын мэдлэгийг сонирхдог. Худалдаа, мэдлэгт тулгуурласан кластер аль алинд нь (а) орон нутгийн/бүс нутгийн, (б) олон улсын эсвэл (в) виртуал байж болох тул энэ ангиллыг өргөжүүлсэн. Үйлдвэрлэлийн чанар, технологи, зах зээл, хүний нөөцийн чадавх, засгийн газар, хувийн сектор болон холбогдох үйлдвэрүүдээс кластер хөгжүүлэх холбоост талуудтай холбогдох байдлыг үнэлэх кластер (diamond model)-ийн нөхцөл байдалд үндэслэн кластерыг идэвхгүй (dormant), идэвхтэй кластер (develop) болон динамик кластер (давуу тал) гэж 3 ангилж болно. Зарим шинж чанар (JICA Report 2004) нь дараах байдалтай байна:

а. Идэвхгүй кластер нь дараах шинж чанартай:

- Бараа бүтээгдэхүүн хөгждөггүй (одоо байгаа бараа бүтээгдэхүүнийг хадгалах магадлалтай);

- Технологи хөгждөггүй (одоо байгаа технологийг ашиглах, ихэвчлэн уламжлалт, тоног төхөөрөмж, машин механизмд хөрөнгө оруулалт хийдэггүй);
 - Орон нутгийн зах зээл (зах зээлийг өргөжүүлэх хүсэл эрмэлзэлгүй, аль хэдийн оршин тогтнож байгаа зах зээлийн хувьд, энэ нь чанаргүй үнээр өрсөлдөхөд хүргэсэн) болон брокер/дилер хоёрын хоорондох харилцаа сул;
 - Ур чадварын түвшний гэмт хэрэгтнүүд статик (удамшлын ур чадвар);
 - Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн итгэлцлийн түвшин бага (нийгмийн капитал бага, бие биеэ мэдээллийн зах зээл, техник, үйлдвэрлэл гэх мэтийг нуун дарагдуулахыг дэмжих);
 - Мэдээлэл нь маш хязгаарлагдмал зах зээл (зөвхөн шууд худалдан авагчид хандах боломжтой тодорхой хувь хүн эсвэл бүлэг);
- b. Идэвхтэй кластер нь дараах шинж чанартай:
- Бараа бүтээгдэхүүнийг зах зээлийн эрэлт хэрэгцээний дагуу хөгжүүлэх (чанар);
 - Зах зээл дэх бүтээгдэхүүний чанарыг хангах технологийг хөгжүүлэх;
 - Маркетинг худалдан авалтыг илүү идэвхтэй хайх;
 - Хөрөнгийн зах зээлийн мэдээлэл бий болгох;
 - Үйлдвэрлэл, зах зээлийн хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх (тухайлбал, түүхий эдийг хамтад нь худалдан авах борлуулалтын албатай г.м);
- c. Динамик кластер нь дараах шинж чанартай:
- Кластерын бат бөх хоорондын мэргэшсэн байдал үүсэх (жишээ нь, тусгай метал металлургын үйлдвэр, хэлбэр, зүсэлтийн үйлдвэрлэл);
 - Кластер зах зээл /хэрэглэгчийг авдаг шинэ бүтээгдэхүүн бий болгож чадсан;
 - Бараа бүтээгдэхүүний дагуу боловсруулсан технологийн шинэчлэл;
 - Бараа бүтээгдэхүүн хөгжүүлэлт, технологийн хөгжил, холбогдох салбарын аль алиных нь хувьд холбогдох салбартай түншлэлийн харилцааг хөгжүүлэх гэх мэт байна.

Кластеруудын ангиллыг хөгжлийн үе шат, үйлдвэрлэлийн холболт, газарзүйн өргөтгөл, зохицол, нэмүү өртгийн сүлжээнд нэгтгэх, мэдлэгийн түвшин, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, эрэлт зах зээлийн өргөтгөлөөр Зураг 2-т нэгтгэн харуулав.

1.1.3. Кластерын онолын хандлага

Орчин үед кластерын онолын хандлага нь бүс нутгийн хөгжлийг тайлбарлах чиглэлд судлаачид аж үйлдвэрийн эдийн засгийн арга барилд тулгуурлаж байна. Аж ахуй нэгжүүд нь цаг хугацааны явцад төрөлжсөн байдал, инновацыг бий болгоход тустай нийгмийн итгэлцэл, харилцан ойлголцлын хүчтэй холбоог хөгжүүлж, хадгалан үлдээдэг газарзүйн хувьд нутагшсан үйлдвэрүүдийн бөөгнөрлөөр тодорхойлогддог (Bagnasco, 1977).

Өөрөөр хэлбэл аж үйлдвэрийн дүүрэг, орон нутгийн үйлдвэрлэлийн систем, бүс нутаг зэрэг ойлголтуудыг харилцан солилцож, хялбаршуулахын төлөө кластер гэж нэрлэх нь түгээмэл байна. Хэдийгээр дээрх ойлголтууд нь бага зэрэг өөр боловч кластерыг тодотгож эсвэл онцолдог ч тэдгээрийн гол онолын блокууд болох аггломерацийн эдийн засаг, эндогени хөгжлийн онол, инновацын системүүдтэй давхцаж (Moulaert Sekia, 2003) хөгжиж байдаг (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Кластерын онолын хандлага

Онол	Агуулга	Эрдэмтэн
Сонгодог Аггломерацийн онол	<ul style="list-style-type: none"> • Гадаад эдийн засгийн хэмжээ • Хотжилт ба орон нутгийн эдийн засаг <ul style="list-style-type: none"> ○ Хөдөлмөрийн зах зээлийн нэгтгэл ○ Оролт хуваалцах ○ Технологийн урсалт ○ Олон талт байдал • Агломераци, аж үйлдвэрийн байршил • Ажил хоорондын холбоо, харилцан хамаарал <ul style="list-style-type: none"> - Аж үйлдвэрийн цогцолборын судалгаа - Өсөлтийн туйл/төвийн бодлого 	Marshall (1890), Weber (1929), Ohlin (1933), Hoover (1937)
Системийн ерөнхий онол	<ul style="list-style-type: none"> • Бүтэц, үүргийн задлан шинжилгээ <ul style="list-style-type: none"> - Харилцан холбоонд орших - Задлан шинжлэх - Салган хуваарилах - Элементүүдийн нэгдэл <ul style="list-style-type: none"> ○ Стандартчилах ○ Цэгцлэх ○ Мэдлэг, төсөөллийг системчлэх 	T. Parsons (1930) Ludwig von Bertalanffy (1968)
Эдийн засгийн газар зүйн онол	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгийн гадаад хүчин зүйл • Агломерацийн эдийн засаг ба хямрал • Агломераци ба бүс нутгийн орлого, баялгийн хуваарилалт • Эргэлт нэмэгдэж, төгс бус өрсөлдөөн 	Krugman (1991), Venables (1996), Fujita and Thisse (2002)
Уян хатан тусгай шинжийн онол	<ul style="list-style-type: none"> • Хэмнэлтийн эдийн засгаас аж үйлдвэрийн байгууллагын уян хатан хэлбэр • Худалдаагүй харилцан хамаарал <ul style="list-style-type: none"> ○ Нийгэм, соёл, байгууллагын бүтцэд эдийн засгийг шингээх • Аж ахуйн нэгж байгууллага, бизнесийн соёл 	Brusco (1982), Piore and Sable (1984), Scott (1988), Storper (1995)

Бүс нутгийн инновацын систем	<ul style="list-style-type: none"> • Шинэ мэдлэг эдийн засаг • Мэдлэг, хамтын суралцахуй <ul style="list-style-type: none"> ○ Чимээгүй ба кодчилох мэдлэг ○ Мэдлэг бүтээх, хуваалцах, орон нутгийн хэмжээнд хэвшсэн загварууд, суралцах, шинийг санаачлах 	Lundval (1992), Cooke and Morgan (1998), Malmberg and Maskell (2002)
Өрсөлдөөний онол	<ul style="list-style-type: none"> • Кластер, бүс нутгийн өрсөлдөх давуу тал <ul style="list-style-type: none"> ○ Хамтын ажиллагаа, өрсөлдөөн ○ Байгууллагуудтай хамтран ажиллах ○ Бүс нутгийн нөөц, дэд бүтэц 	Porter (1990) Drescher & Maurer, 1999
Орон зайн гадаад байдлын онол	<ul style="list-style-type: none"> • Мэдлэг урсалт ба эндогени өсөлтийн онол • Санаа бодол, боловсрол, судалгаа, институт <ul style="list-style-type: none"> ○ Тусгай зөвшөөрөл олголт ба олон янз байдал, монопол, өрсөлдөөн, газар зүйн ойр байдал 	Romer (1986), Lucas (1988), Glaeser <i>et al.</i> (1992), Henderson <i>et al.</i> (1995)

(Эх сурвалж: *Randall W Jackson, Gashawbeza W. Bekele, Theoretical Perspectives on Industry Clusters, 2006*)

Кластер хөгжлийн онолын хандлага, өрсөлдөөний давуу тал нь кластерт оролцдог компаниудаар хязгаарлагддаггүй бөгөөд энэ нь төвлөрч байрладаг бүс нутгийн эдийн засагт бүхэлд нь ашиг тустай байна. Иймд кластерын онолын хадлагыг дараах байдлаар тоймлон авч үзье.

Сонгодог агломерацийн онол:

Хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны орон зайн төвлөрлийг харуулдаг агломерацийн тухай ойлголт нь урт хугацааны туршид эрдэмтдийн судалгааны сонирхлыг татаж А.Маршалын эдийн засгийн зарчмууд бүтээл хүртэл анх хэвлэгдсэн байдаг. А.Маршалын хэлснээр агломерацийн давуу тал нь орон нутгийн эдийн засгийн гурван багцаас үүдэлтэй бөгөөд энэ нь тусгай ур чадвартай ажилчдад зориулсан *зах зээлийн тусгай оролт, үйлчилгээний хүртээмж, технологийн урсалт* юм. А.Маршалын анх онцлон тэмдэглэсэн орон нутгийн энэхүү 3 давуу тал нь аж үйлдвэрийн бөөгнөрөл, агломерацийн талаарх хэлэлцүүлгийн гол цөм нь болсоор байна. А.Маршал, Б.Охлин, Ж.Ховер нарын бүтээл дээр тулгуурлан эдийн засгийн үйл ажиллагааны орон зайн бусад бөөгнөрөл бүхий фирмүүдэд агломерацийн эдийн засгийн хувьд ямар ашиг тусыг олж болохыг дэс дараатай тодорхойлсон байдаг (Marshall.A 1890, Ohlin.B 1933, Hoover.J 1937, 1948).

Агломерацийн эхэн үеийн онолчид эдийн засгийн ашиг тусыг хэрхэн хүртдэг орон зайн загварт хэрхэн нөлөөлдөг тухай асуудлыг хөндсөн байна. Агломерацийн эдийн засаг нь орон зай дахь эдийн засгийн үйл ажиллагааны байршлын судалгаанд гол байр суурь эзэлдэг. Тэдгээр нь *хол тээврийн болон үйлдвэрийн зардлыг багасгах, хямд хөдөлмөр эрхлэх, эрсдэлийг багасгахыг оролддог* үйлдвэрүүдийн

байршлын шийдвэрт гол хүчин зүйл гэж үздэг Дикен ба Ллойд (Dicken and Lloyd 1990). Аж үйлдвэрийн байршил, хот байгуулалтад нутагшуулах, хотжилтын эдийн засгийн чухал үүрэг ихээхэн яригдаж байгаа ч эдийн засгийн давуу тал нь үйлдвэрүүдийн байршлын сонголт эсвэл бөөгнөрөл оршин тогтнох талаар хангалттай тайлбар өгөхгүй байж магадгүй юм. Учир нь зарим тохиолдолд бөөгнөрөл нь уур амьсгал, байр зүйн хувьд тохиромжтой, түүхий эдэд ойрхон, байгалийн болон хиймэл тээврийн замд нэвтрэх боломжтой байршил зэрэг "байгалийн давуу талууд"-аас үүдэлтэй байж болно Дикен, Ллойд, Глэзер,Гордон, МакКэнн (Dicken ,Lloyd 1990, Glaeser 1992, Gordon, McCann 2000). Өмнөх үеийн сонгодог бөөгнөрлийн онолчид аж ахуй нэгжүүдийн орон зайн төвлөрөлд анхаарлаа хандуулдаг бол хожим нь аж үйлдвэрийн бөөгнөрөл, бөөгнөрөл дээр хийсэн ажил нь үйлдвэрлэл, үйлчилгээ, маркетингийн холбоо зэрэг янз бүрийн төрлийн хэлхээ холбоонд анхаарлаа хандуулдаг байна. Мирдал, Хиршман (Myrdal 1957, Hirschman 1958)

Бүс нутгийн нөөцийн потенциалын нийт ашиглалтын хамгийн их үнэ хүрэхэд нөөц дахин хуваарилалт хурдасдаг энэ нь тэдний төвлөрлийн эрчим хүчний өсөлтөд нөлөөлдөг бөгөөд хариуд нь орон нутгийн буюу агломерацийн нөлөөллийг бий болгоход хүргэдэг. Эрдэмтэн С.П.Земцов үүнийг хүлээн зөвшөөрч, агломерацийн үр нөлөөг бий болгох нь бүс нутгийн нийгэм, эдийн засаг, инновацын үйл явцад эерэг нөлөө үзүүлдэг гэж нотлов. В.М.Разумовский болон түүний хамтран зүтгэгчид инновацын кластеруудыг зохион байгуулах нь хамтын ажиллагаа, мэргэшлийн хөгжил дээр тулгуурлан, мэдлэг ихтэй үйлдвэрлэл, мэдээлэл, харилцаа холбооны технологийг эрчимтэй ашиглахтай зэрэгцэн нэгэн зэрэг хамтардаг бөгөөд энэ нь үр дүнтэй холбооснуудыг харилцан ашигтай түвшинд болон бүс нутгийн нөхцөлд хэрэгжүүлэхэд хүргэдэг гэдгийг хүлээн зөвшөөрч байгааг анхаарах нь зүйтэй юм.

Системийн ерөнхий онол:

Энэхүү онолыг 1930-аад оны үед байгалийн шинжлэх ухааны төлөөлөгчид боловсруулсан байдаг бөгөөд нийгмийн шинжлэх ухаанд харьцангуй хожуу хэрэглэж эхэлсэн юм. Энэ онолын хадлагыг нийгмийн шинжлэх ухаанд нэвтрүүлэхэд физиологич У.Конен биологич Л.Берталанфи, нийгмийн судлаач, эдийн засагч Т.Парсонс, Ж.Хоманс, Р.Мертон нар томоохон хувь нэмэр оруулжээ.

Үүнд үр дүнд тэд нийгмийг судлах арга зүйн чухал хандлага болсон бүтэц-үүргийн задлан шинжилгээний аргыг боловсруулсан юм.

Системийн задлан шинжилгээний үүднээс авч үзвэл хүмүүсийн аливаа нэгдлийг нэлээд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй харьцангуй тогтмол шинжтэй нийтлэг зүйл гэж үзэж болно. Энэ нь хоорондоо харилцан холбоонд оршдог, задлан шинжилж, салган хуваарилж болдог элементүүдийн нэгдлээс бүрддэг онцлогтой юм. Ийм системүүд нэг нь нөгөөгөөс ялгардаг хил хязгаартай байдгийн хамт тодорхой тэнцвэрт байдлыг хадгалдаг шинжтэй байдаг.

Аливаа систем гурван гол хэмжигдэхүүнийг өөртөө агуулдаг. *Нэгдүгээрт*, Энэ бол тухайн бүтцэд бодитой оршиж буй зүйл, *хоёрдугаарт*, Үйлдэл, төлөв эсвэл ажиллагаа, *гуравдугаарт*, төлөвшил эсвэл хувьсал байдаг. Иймд кластер бол нэг төрлийн систем буюу тогтолцоо юм.

Эдийн засгийн газар зүйн онол:

XX зууны сүүлчээр эдийн засгийн орон зайн үйл ажиллагаа, түүний байрлал эрдэмтэд, эдийн засагчдын судалгааны судлагдахуун болж тодорхой байршилд үйлдвэрлэгчдийн бөөгнөрөл давуу талыг бий болгож, гадаад зах зээлийн орон зайд төвлөрөл бий болсноор эдийн засгийн эргэлт нэмэгдэж төгс бус өрсөлдөөн бий болно гэж үздэг.

Уян хатан тусгай шинжийн онол:

Уян хатан байдлын (Pollert 1991)-ийн тухай онол нь өөрчлөгдөж буй хэлбэр, механизм (институцууд, сүлжээ, журам, хэм хэмжээ) нийгмийн харилцаа болж капиталын өргөтгөсөн үржвэрийг баталгаажуулах, мөн капитализмын төрөлхийн эдийн засгийн зөрчилдөөн, зугтах аргагүй бэрхшээл, хямралын хандлагыг харгалзан үздэг энэ өргөтгөсөн нийгмийн үржүүлгийг хагас дутуу гэж үзэх болсон. Нийгмийн үйлдвэрлэлийн үр дагаврын талаар бага тайлбар хийсэн ч илүү уламжлалт нийгмийн итгэл найдвар, харилцан хамтын ажиллагааны шинж чанар доройтож байгаа үед уян хатан тусгай аж үйлдвэрийн дүүргүүдэд амьд үлдэх нь хэчнээн хэцүү болохыг харуулж байна Пиоре, Сабел (Piore and Sabel 1984).

Энэ нь эдийн засаг, улс төр, нийгмийн амьдралын олон өөр салбарт илүү уян хатан байдлыг урамшуулан дэмжиж, одоогийн хямралаас зугтах эрэл хайгуулыг үргэлжлүүлэхэд хүргэдэг онол юм. Бүтээмж, инновац нь уян хатан машин механизм, уян хатан хөдөлмөрийг ашиглах цар хүрээний хамтын үр ашиг, эдийн засгийн

байдлаас хамаардаг. Жижиг фирмүүдийн хоршоо, корпорац нь эхний хувьсалд гол үүрэг гүйцэтгэдэг бол том фирмүүд хоёр, гурав дахь хувьсагч дахь хагас бие даасан дотоодын бизнесийн нэгж, хамтран ажилладаг гадаад ханган нийлүүлэгчдийн нэгдэлд санхүү, маркетинг, судалгааны үйлчилгээ үзүүлдэг. Уян хатан шиж чанар нь мэдлэгийг түгээж, инновацыг бий болгож мэдлэгийн хамтын сүлжээ, бүтээмжийг бий болгодог.

Бүс нутгийн инновацын систем:

Эдийн засагт бүс нутгийн гүйцэтгэлийг дүгнэх чухал хэрэгсэл бол 1990-ээд оны эхээр Күүк (Cooke, 1992, 1998, 2001) гарч ирсэн бүс нутгийн инновацын систем (RIS)-ийн үзэл баримтлал юм. Chris Freeman үндэсний инновацын системийн үзэл баримтлалыг анх ашигласнаас хойш хэдхэн жилийн дараа – анх Bengt-Åke Lundvall-ийн боловсруулсан Японы хөгжиж буй эдийн засгийн судалгаан дээрээ шинийг санаачилж, орон нутгийн хэмжээнд инновацын шинэ загваруудыг бий болгосон Фриман (Freeman, 1987). Инновацын системийн арга барилын онцлог нь институтийн хүрээнд үндэслэгдсэн янз бүрийн оролцогчдын сүлжээгээр дамжуулан инновацыг хэрэгжүүлдэг. Энэхүү динамик, нарийн харилцан үйлчлэл нь инновацын түгээмэл шошгологдсон системүүдийг бүрдүүлдэг Эдквист (Edquist, 1997). Өөрөөр хэлбэл системүүд нь харилцан үйлчлэлийн сүлжээ гэж ойлгогддог Кауфман, Тодтлинг (Kaufmann and Tödtling, 2001). Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нутаг дэвсгэрийг тэдний явах цэг (үндэстний болон бүс нутгийн) эсвэл тодорхой салбар, технологи Фагерберг (Fagerberg et al.) болгон авч үзэх зэрэг олон янзын арга барил бий болсон. Бүс нутгууд нь үндэсний болон орон нутгийн (кластер эсвэл фирмүүдийн) хоорондох мезо-түвшний эдийн засгийн зохицуулалт, удирдлагын чухал үндэс суурь гэж үздэг. Бүс нутаг нь шинийг санаачлагчдын бүс нутгийн сүлжээ, орон нутгийн бөөгнөрөл, судалгааны байгууллагуудын үржил шимийн үр дагавраар дамжуулан инновацыг бий болгох түвшин улам бүр нэмэгдэж байна Лундвалл, Боррас (Lundvall and Borrás, 1997, 39).

Өрсөлдөөний онол:

Өрсөлдөх чадвар гэдэг нэр томъёог эргэн тойрныхоо нөхцөл байдал өөрчлөгдөж байгаагийн хариуд дасан зохицох, өөрчлөх чадвартай гэж тайлбарлах боломжтой. Энэ нь ерөнхийдөө зах зээлийн эдийн засгийн асуудлуудтай холбоотой

боловч гурван өөр хуваагдлаас бүрддэг гэж үзэж болно. Эдгээр нь компаниудын өрсөлдөх чадвар (микро эдийн засгийн түвшин), аж үйлдвэрийн өрсөлдөх чадвар (mezzo- economic level), үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадвар (макро эдийн засгийн түвшин) юм Дрешер, Маурер (Drescher & Maurer, 1999).

Өрсөлдөх чадвар нь тухайн аж ахуйн нэгжийг хөгжил, түүнийг тойрсон улс төр-эдийн засгийн орчин зэрэг нь өрсөлдөөний гадаад, дотоод аль алиных нь хэрэгцээ шаардлагыг илтгэсэн үйл ажиллагаа юм гэж тайлбарладаг. Байгууллагын санхүүгийн хүчин чадлаараа үйл ажиллагаа явуулах, хариу үйлдэл үзүүлэх чадвар байдаг. Иймээс өрсөлдөх чадварыг олон талт үзэл баримтлал гэж үзэх хэрэгтэй. Өрсөлдөх чадвар нь ихэвчлэн том компаниуд болон эдийн засгийн салбарын хамтын ажиллагааны урт хугацааны гүйцэтгэлтэй холбоотой байдаг.

Кластерын хамгийн өргөн хүрээтэй, зохион байгуулалттай аргуудын нэг нь Бергман, Фесер нарын 1999 онд хэвлүүлсэн "Аж үйлдвэрийн болон бүс нутгийн кластерууд" бүтээл юм Бергман, Фезер (Bergman and Feser, 2020). Зохиогчид кластерын онолыг дэмжих, хангах таван гол онолын үзэл баримтлалыг тодорхойлсон байдаг (Зураг 3).

Зураг 3. Кластерын онолын үндэслэл, хүрээ



(Эх сурвалж: Edward M. Bergman, Edward J. Feser, *Industrial and Regional Clusters: Concepts and Comparative Applications*, 2020)

Гадаад эдийн засаг:

Төвлөрлийн ашиг тусыг ойлгох хоёр үндсэн үзэл баримтлалын арга энэхүү бичвэрт давамгайлдаг. Аж үйлдвэрийг нутагшуулах онол, үр ашгийг бөөгнөрлийн эдийн засаг гэж нэрлэдэг ба Маршаллын үзэл баримтлал нь гадаад цар хүрээтэй эдийн засаг тэдгээрийн аж үйлдвэр дэх оролцооны дүн шинжилгээ юм. (Steiner, 1998).

Аж үйлдвэрийг нутагшуулах онолын үр өгөөжид дараах зүйлс орно. Зах зээлийн эрчим хүчний зуучлалын хэлцэл, тоног төхөөрөмжийг оновчтой ашиглах, нийтлэг дэд бүтэц, эрсдэл, тодорхойгүй байдлыг бууруулах, илүү их мэдлэг юм. Маршалл масштабын гадаад эдийн засгийг нийт салбарын үйлдвэрлэлийн хэмжээ эсвэл өсөлтөөс шалтгаалж аж ахуй нэгжид хуримтлагдсан зардлын хэмнэлт гэж тодорхойлсон. Гадаад эдийн засаг нь үйлдвэрлэлийн хэмжээний өсөлтөөс ашиг нэмэгдүүлэх эх үүсвэр болдог. Эдгээр гадаад эдийн засаг нь үндсэндээ орон зайн гадаад нөлөөлөл (эдийн засгийн нэгж хоорондын ойрын сөрөг нөлөө) юм. Энд суралцах, инновац хийх, мэргэжил дээшлүүлэх, тодорхой мэдлэг, ур чадвар гол үүрэг гүйцэтгэдэг.

Ажлын шинэлэг орчин:

Шинэлэг ажлын орчин – энэ онол нь сургалтын эдийн засаг ба инновацын орчин гэсэн хоёр ойлголтыг тодорхойлдог.

Эдийн засгийг судлахын давуу талыг мэдлэг, мэдээлэл солилцох, харилцан суралцах зэрэгтэй холбон үзэж болно. "Далд" мэдлэг, ур чадварт байгууллага, аж ахуй нэгж, хүмүүс онцгой анхаарал хандуулдаг Роеландт, Ден Хертог (Roelandt, Den Hertog, 1999).

Инновацын орчин нь аж ахуйн нэгжүүдийн хоорондын хэлцэл, холбоо, түншлэлийн онцлог шинж чанараар тодорхойлогддог. Гэхдээ хоёр талын харилцаанаас илүү хамтын инновацын орчныг хадгалахад илүү их анхаардаг. Гроен (Groen, 2012).

Хамтын ажиллагаа:

Хамтын ажиллагаа нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүд томоохон аж ахуйн нэгжүүдийг ашигладаг гадаад эдийн засгийг эсэргүүцэх арга зам юм. Гадаад зах зээлийн судалгаа, хамтарсан экспортыг дэмжих, үзэсгэлэн худалдаа, дэд бүтцэд төрөлжсөн хөрөнгө оруулалт зэрэг нь өрсөлдөөнт үйлдвэрлэгчид хамтран ажиллах ердийн салбар юм. Нөгөөтээгүүр, тэд маркетинг, үйлдвэрлэл, борлуулалт, шинэ

бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйл явцыг сайжруулах чиглэлээр өрсөлдөх боломжтой байдаг Шкуркин, Рязанцев, Гусаков, Андронова, Болгова (Shkurkin, Ryazantsev, Gusakov, Andronova, Bolgova, 2016).

Энэ нь жижиг фирмүүдийн бөөгнөрөл дэх эдийн засгийн үндсэн чиг хандлагыг тодорхойлох төдийгүй эдгээр динамик бүс нутгийн аж ахуй нэгжүүд хоорондын харилцааг зохицуулдаг нийгэм, соёлын зан үйлийн кодыг тодорхойлдог тусдаа аж үйлдвэрийн бүс нутгийн социологийн онолын судалгаанд маш чухал юм Ле Херон, Харрингтон (Le Heron, Harrington, 2005).

Аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөн:

Уламжлалт неоклассик үзлийг дасан зохицож, өрсөлдөх чадвартай салбарын бүтэц, ижил тоглоомын талбарт өрсөлдөж буй компаниудын тоо нь технологи, зардлыг багасгах, инновацыг сайжруулахад байнгын дарамт шахалт үзүүлдэг гэж үздэг (Портер. М 1998). Гэвч аж үйлдвэрийн төвлөрлийн энгийн индекс нь тухайн салбар эсвэл бүс нутаг дахь өрсөлдөөний түвшинг хангалттай харуулахгүй. Илүү чухал зүйл бол тухайн салбарын өрсөлдөх чадвар юм. Газарзүйн хувьд тусдаа бүс нутагт төвлөрсөн өрсөлдөгч компаниудын дунд өрсөлдөөн хүчтэй байх магадлалтай. Бүс нутгийн аж ахуй нэгжүүд, хэрэглэгчдийн төлөө төдийгүй хөдөлмөр, хөрөнгө, олон нийт, улс төрийн дэмжлэгийн төлөө тэмцэж байна. Салбарын бүтэц нь ялангуяа суралцах, инновац, бизнес эрхлэхэд нөлөөлж Нью-Йорк зэрэг газруудад төрөлжсөн, баян, жижиг аж ахуй нэгжүүд давуу тал олгодог болохыг харуулж байна.

Орон зайн хамаарал:

1980-аад оны үеийн бүс нутгийн өсөлтийн гол үзэл баримтлал болох бүс нутгийн өсөлтийн неоклассик онол нь зах зээлийн байгалийн механизм нь бүс нутаг хоорондын эдийн засгийн тэгш бус байдлыг аажмаар арилгах, гаднын нөлөөнд ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй гэж үздэг (Боговиз, Рагулина, Кутукова, 2016). Өсөлтийн шинэ онол нь тухайн бүс нутаг эсвэл улс оронд бий болсон харьцангуй давуу тал, магадгүй аз тохиол, байгалийн баялгийн хуваарилалт эсвэл бусад зан үйлийн бус үзэгдлүүдийн эдийн засгийн цар хүрээний үр дүнд нэмэгдсэн гэж үздэг. Орон зайн хамаарал гэдэг нь технологийн үр ашиггүй, муу эсвэл оновчтой бус байсан ч хувилбаруудыг давамгайлах, өөрийгөө бэхжүүлэх чадваргүй гэсэн ерөнхий байр суурийг илэрхийлдэг.

Тиймээс бүс нутагт эдийн засгийн хөгжлийн онол, практикийн талаарх орчин үеийн мэтгэлцээн, эрдэм шинжилгээний олон салбар, бодлогын хүрээнд ер бусын ашиг сонирхлыг бий болгосоор байна. Дэлхий нийтийн өрсөлдөөн бүс нутгийн болон үндэсний эдийн засагт илүү их нөлөө үзүүлдэг тул кластерын үзэл баримтлал нь бүс нутгийн болон орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих талаар бодлого боловсруулагчдын санаа зоволт анхаарлын төвд байнга байсаар байгаа юм.

Үүний үр дүнд дэлхий дахинд олон улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүс нутгийг хөгжүүлэх, жижиг, дунд бизнесийн уялдааг бэхжүүлэх, экспортын чадавхыг нэмэгдүүлж хөгжлийг хурдасгах нэг гол арга хэрэгсэл бол кластер юм. Кластерууд болон тэдгээрийн үйл ажиллагааг ойлгоход бизнест чиглэсэн хандлагыг хэрэгжүүлэх, бизнесүүд хэрхэн хамтран ажилладаг, хамгийн чухал нь яагаад хамтран ажилладаг талаар илүү сайн онолын ойлголттой болох явдал байдаг.

1.1.4. Бүс нутгийн кластер, түүний хөгжил

Дэлхийн эдийн засаг даяаршлын үйл явцын өөрчлөлтийн нөлөөнд байнга өртөж байдаг тул одоо байгаа өөрчлөлтөд тохирсон үйлдвэрлэл, эдийн засгийн харилцан үйлчлэлийг зохион байгуулах арга замыг эрэлхийлэх нь үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар дотоод болон гадаад зах зээлд биет болон биет бус нөөцийг зохистой ашиглах, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Кластерын үзэгдлийн ийм олон талт байдал нь бүс нутгийн шинэлэг хөгжлийн нөхцөлд эдийн засгийн нэгжүүдийн орон зайн хуваарилалтын онцлогийг шинжлэхэд салбар хоорондын хандлагыг ашиглах шаардлагатай болдог. Бүс нутгийн кластер нь туйлын гетероген орон зайд эдийн засгийн өсөлтийн бүсүүд болох орон зайн хөгжлийн үндсэн хэлбэрүүдийн нэг гэж үзэж болно.

Бүс нутгийн кластер нь орон нутгийн энтрепренершипийн босоо болон хөндлөн интеграцийн холбооснуудын орон зайн эдийн засгийн тогтолцоонд бий болох үндэс юм. Үүний үр дүн нь үндэсний болон дэлхийн түвшинд өрсөлдөхүйц бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх явдал юм. Энэ нь эдийн засгийн бүтцийг сайжруулж, түүний тогтвортой байдлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлдэг. Ийм кластерууд ихэнхдээ экспортод чиглэсэн, дэлхийн эдийн засгийн систем дэх бүс нутаг, улс орны өрсөлдөх чадварыг тодорхойлдог. Бүс нутгийн өрсөлдөх чадвар, хөгжил нь компаниудын үр ашигтай чадавхыг тодорхойлж, бүс нутгийн түвшинд ашиг, орлого, ажил эрхлэлт (Budd and Hirmisf, 2004), бусад их сургууль – аж үйлдвэр – засгийн

газар (улс, бүс нутгийн эсвэл орон нутгийн) болон бизнесийн хамгийн сайн үр дүнг тодорхойлох орон нутгийн тодорхой үйл ажиллагаануудын хоорондын харилцаа байдаг Смит & Багчи-Сем (Smith & Bagchi-Sem, 2010). Бүс нутгийн хөгжлийн үйл явцыг жолоодох чадвартай инновац, зохион байгуулалтын нөхцөлийг нэмэгдүүлэх ерөнхий зорилгын хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага хамтран ажилладаг Езковиц (Ezkowitz, 2008).

Бүс нутгийн кластер нь ижил төстэй болон түүнтэй холбоотой эдийн засгийн үйл ажиллагааны орон зайн агломераци юм. Орон нутгийн орчин нь мэдлэгийг тоглоход тохиромжтой янз бүрийн хэлбэрийг өдөөх үндэс болдог сурах, дасан зохицох арга юм. Ийм бөөгнөрөл нь ихэвчлэн жижиг, дунд бизнесүүдээс бүрддэг бөгөөд тэдний амжилтын төв элемент нь нийгмийн капиталын хүчин чадал, газар зүйн ойр дотно байдалд төвлөрдөг.

Бүс нутаг дахь кластерууд нь өнөөдөр тухайн улсын эдийн засгийн хөгжлийг манлайлагчид болж байна. (Жаков Де Маны, 1995) Бүс нутгийн кластер нь:

1. Бүсчилсэн хэлбэрээр аж үйлдвэрийг төвлөрүүлэх
2. Сектор, секторын бүлэглэлийг хөгжүүлэх
3. Үйлдвэрийн уялдаа холбоог үүсгэх гэсэн 3 төрөл байна.

Бүс нутгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийн кластеруудыг бүрдүүлэх, үйл ажиллагаа явуулах аргачлалыг боловсруулахдаа өөрийн зохион байгуулалтын менежментийн загварын мэдээлэл, арга зүйн баазын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Бүс нутгийн кластер судлалд байнга гардаг кластер эрдэмтэд дараах асуудалд голчлон анхаарал хандуулсан байдаг. Үүнд:

1. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) болон олон үндэстний аж ахуйн нэгж (ОУААН). Улс орон, бүс нутаг нь ГШХО болон ОУААН-г (Jordaan 2008) татахын тулд хөдөлмөрийн арвин их нөөц, шилдэг дэд бүтэц зэрэг "үндэс суурь"-ийг хангах хэрэгтэй. Нөгөө талаас ГШХО болон ОУААН нь хөгжиж буй орнуудын хөгжлийг түргэсгэдэг хүчнүүд юм (Ямамото 2008, Чэн 2010).
2. Олон улсын худалдаа. Кластер үндэстэн дамнасан фүүсүүд дэлхийн зах зээлд (Belso-Martinez 2006) хэрхэн илүү өрсөлдөх, экспортлох талаар мөн кластерын давуу талыг хэрхэн үр ашигтайгаар ашиглах талаар бодож үзэх ёстой. Родригес-Поз (Rodriguez-Pose 2013) Орон нутгийн захирагч, төлөвлөгчид олон улсын худалдаа болон кластерууд үнэхээр орон нутгийн экспортын чадварыг

нэмэгдүүлдэг эсэх (Malmberg 2000) орон нутгийн бөөгнөрөлд хэрхэн нөлөөлдгийг сонирхож болох юм. (Naaranta 1998, Holmes and Stevens, 2014)

3. Дэлхий даяарх үнэ цэнийн гинжин хэлхээ (ДДҮЦГХ), дэлхийн бараа бүтээгдэхүүний гинжин хэлхээ (ДББГХ), дэлхийн үйлдвэрлэлийн сүлжээ (ДҮС) байгуулах. Энэ гурван ойлголт нь хоорондоо бага зэрэг ялгаатай (Henderson 2002). Ийм төрлийн судалгаа нь дэлхийн янз бүрийн газарт фирмүүд болон аж үйлдвэрүүдийн дунд баригдсан дэлхий дахины гинжин хэлхээ, сүлжээг судалсан. (Hess, Сое 2006, Стуржон 2008, Ёнг 2009, Хервас-Оливер, Бойс-Доменех 2013, Yeung, Сое 2015). Хэдийгээр ДДҮЦГХ, ДББГХ, ДҮС нь фирмүүд болон аж үйлдвэрүүдийг дэлхий дахины талаас нь ойлгоход бидэнд тусалдаг ч тэд газарзүйг судалгааны гол цөм биш харин нөхцөл байдал болгон тогтоодог.
4. Үзэсгэлэн худалдаа нь “бараа бүтээгдэхүүн, шийдэл бүхий хувь хүн, аж ахуй нэгжийн түр зуурын бизнес цугларалт” юм. (Li 2014) Кластерын компани бүр (аль бөөгнөрөлд байгаагаас үл хамааран) бизнесийн капиталтай холбоо тогтоох илүү их боломж байдаг.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах нь кластер биш харин бөөн компани боловч хөрөнгө оруулагчид боломжит бусад нөхцөлийг өгөхдөө кластер бус фирмүүдээс илүү кластер фирмүүдэд хөрөнгө оруулахыг илүүд үздэг гэдгийг онцолсон байдаг Мартин, Санли (Martin, Sanli 2003).

Үүний нэг жишээ нь Цахиурын хөндий: (АНУ-ын IT кластер) Хөрөнгө оруулагчид Тайвань Hsinchu IT кластер дахь фирмүүдтэй хэрхэн харилцаа тогтоосон явдал юм Саксениан, Хусо, Саксен, Сабел (Saxenian and Hsu, 2001, Sachsen and Sabel, 2008). 1980-аад онд венчур капиталын салбар бий болж эхлэхэд Олон Тайванчууд Америкаас буцаж ирээд Тайваньд бизнес эрхлэх болсон. Ийм нэгэн хүн бол Стэнфордын их сургуулийг төгссөн Макроникс Интернэшнлийг үндэслэгч Тайваны Миен Ву юм. Миен Ву АНУ-д 10 гаруй жил ажилласныхаа дараа Тайвань руу буцахаар шийдэж Hsinchu шинжлэх ухаанд суурилсан аж үйлдвэрийн паркад бизнесээ босгожээ. Аажмаар өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулагчид болон бизнес эрхлэгчид Тайваны Hsinchu IT кластерт төвлөрч 1996 он гэхэд тэнд 2500 гаруй инженер, эрдэмтэд ажиллаж байна Саксен, Хусо (Saxen, Hsu, 2001).

Хоёр дахь жишээ бол Хятадын Гуанжоу дахь бөөгнөрөл: Японы Тоёота компани Нагоя автокластер болон Гуанжоугийн авто кластерт хөрөнгө оруулалт хийж тэнд үйлдвэр байгуулсан байна. Нагоя Тоёота өөрийн судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнгээ Гуанжоугийн үйлдвэрт илгээсэн бөгөөд зарим хэсгүүдийг Нагоя руу илгээсэн байна.

Энэ жишээнд үнэ цэнийн гинжин хэлхээний үйл ажиллагаа Нагоя болон Гуанжоу фирмүүдийн хооронд судалгаа, хөгжүүлэлт, худалдан авалт, нийлүүлэлт 2 газар явагддаг. Тэд фирмүүдийн зан төлөвт тулгуурласан кластеруудын хоорондын харилцааг чухалчилсан бөгөөд макро түвшинд хөрөнгө оруулалтыг судлах онолын болон практик ач холбогдолтой хөндлөнгийн харилцан үйлчлэлийн мэдлэгийг ахиулж байна.

Тиймээс энэхүү жишээ эрдэмтдийн судалгаанаас харахад бүс нутгийн кластер хөгжлийн дараагийн үе шат нь инновацын кластер юм. Дэлхий нийтэд үйлдвэрийн кластер хөгжлийн 2 дахь үе шат нь инновацын кластер гэдгийг судлаачдын эмпирик судалгааны үр дүн ном бүтээлүүд харуулна.

Кластерт инновацын системийг жижиг, дунд бизнесийн Европын сүлжээний тайланд тусгаснаар бүс нутгийн кластерын харилцан ажиллагааны хөгжлийн 3 түвшинд авч үзсэн байна. Үүнд: Бүс нутгийн кластер, бүс нутгийн инновацын сүлжээ, бүс нутгийн инновацын систем юм (Зураг 4).

Зураг 4. Кластерын харилцан ажиллагааны хөгжлийн түвшин



(Эх сурвалж: compiled by S. B. Boldyreva based on research results)

Инновацийн тогтолцоог бий болгохын тулд анхан шатны түвшинд бүс нутгийн кластер оролцогчид илүү зохион байгуулалттай, албан ёсны хамтын ажиллагаатай, шинэлэг төслүүдэд оролцох боломжтой бүс нутгийн инновацын сүлжээг бүрдүүлдэг. Жишээ нь, нийлүүлэгчид нь зөвхөн үйлчлүүлэгчдэд зориулсан эд анги, моделиудыг үйлдвэрлэдэг төдийгүй тэдэнтэй хамтран шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хамтран оролцдог.

Бүс нутгийн инновацын систем нь их, дээд сургууль, коллеж боловсролын байгууллага, түүнчлэн технологи дамжуулах агентлагууд, бизнесийн холбоо, санхүүгийн байгууллагуудыг бий болгох, түгээх зорилготой фирм, байгууллагуудын инновацын үйл ажиллагаанд хамтран ажиллах боломжийг олгодог.

Үүний үр дүнд тухайн бүс нутагт тодорхой төрлийн ашиглалтын орон зайн үзүүлэлтүүдийн үнэ цэнэ тухайн улсын дундаж үзүүлэлтээс хэтэрвэл тодорхой нутаг дэвсгэрт бүс нутгийн кластер буюу түүний элементийг (хэрэв кластер нь өөр хоорондоо харилцан хамааралтай) бий болгохыг дэмжсэн шууд бус нотолгоо гэж хэлж болно. Учир нь бизнесийн ийм сүлжээ бүс нутгийн нөөцийн чадавхыг үр дүнтэй, ухаалаг ашиглах механизм болж ажилладаг юм. Тэгвэл бүс нутагт аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд аливаа нэгэн орон зайн хамааралтай холбоотой кластер органик холбоос байх нь тодорхой юм. Холбоосны хүчин зүйл, элементүүдээр авч үзэхийн тулд судалгааны байдлаас харахад харилцан хамаарлыг кластер загвараар судлан тодорхойлсон байдаг.

1.2. Жижиг, дунд үйлдвэрийн кластерын тогтолцоо, түүнийг үнэлэх арга зүй

Дэлхийн эрдэмтэн судлаачид жижиг, дунд үйлдвэрийн кластер хөгжлийг нэлээдгүй судалсан байх бөгөөд тогтолцоо нь тодорхой загвар, бүтэцтэй өөр хоорондын уялдаа холбоотой, элементүүдийн нэгдсэн цогцоор тодорхойлогдоно. Кластерын тогтолцоо нь төрөл, загвар, бүтэц, бүрэлдэхүүн элементүүдээс бүрдэнэ. Судлаачид кластерыг эдийн засгийн хөгжлийн чухал элемент гэж үздэг Мальмберг, Маскелл, Мартин, Санли (Porter.M 1998, Malmberg, Маскелл 2002, Martin, Sanli 2003). М.Портер (1998) кластерыг дараах байдлаар тодорхойлсон: “Кластер гэдэг нь тодорхой нэг салбарт харилцан уялдаатай компани, байгууллагуудын газарзүйн төвлөрөл юм”. Хэдийгээр энэ тодорхойлолт нь маш ерөнхий боловч кластерын чухал элементүүдийг агуулдаг.

Нэгдүгээрт, Кластер нь зөвхөн компаниудаас гадна институтээс бүрддэг. Институциудад кластерын байгууллага зэрэг ашиг тустай холбоод төдийгүй инновацийн сүлжээ, хүний капиталын үндэс болсон судалгаа, боловсролын байгууламжууд орно. Тиймээс тус тусын хөгжил нь хоорондоо нягт уялдаатай байдаг тул бие биеэсээ салж болохгүй (Kenney, Von Burg 1999, Maskell 2001).

Хоёрдугаарт, Тодорхойлолтод зөвхөн тодорхой компани, байгууллагууд хамаарна. Тиймээс кластерууд нь гаднах хил хязгаартай байдаг. Зөвхөн "тодорхой салбарт" байдаг, тодорхой технологийн ойр орчноо харуулдаг, эсвэл нийтлэг сэдэв дээр ажилладаг эсвэл янз бүрийн солилцооны үйл явц, харилцан уялдаа холбоо, харилцан нөхөх байдлын үндэс болсон компаниуд, байгууллагууд л кластерт багтдаг. Бусад чиглэлээр ажилладаг компани, байгууллагууд ижил байршилтай байсан ч энэ "тусгай талбар"-аас гадуур байдаг. Тиймээс кластер нь тухайн бүс нутгийн бусад компани эсвэл кластеруудаас сэдэвчилсэн хил хязгаараар ялгаатай бүс нутгийн үйлдвэрийн системийн нэг хэсэг юм. Сэдвийн хил хязгаар нь нэг байршилд хөгжлийн логикийн өөрчлөлтийг хязгаарлаж чаддаг. Жишээ нь, Бостоны шинээр бий болж буй биотехнологийн үйлдвэрлэлийн орчныг харуулсан Бателт (Batelt, 2001) тайлбар нь тухайн бүс нутаг дахь мини компьютерын үйлдвэрлэлийн талаарх (Saxenian 1994) зургаас эрс ялгаатай байна. Иймээс сэдэвчилсэн хил нь кластерыг орон зайн хүрээн дэх үйлдвэрлэл, инновацийн системийн бусад хэсгүүдээс ялгаж өгдөг. Кластерын сэдэвчилсэн хил хязгаараас гадна компаниуд болон тэдгээрийн институтийн орчин нь "газарзүйн хувьд төвлөрсөн" тул орон зайн хил хязгаар байдаг. Орон зайн хил нь кластерыг үйлдвэрийн орчноос нь тусгаарладаг бөгөөд энэ нь өөр газар байрладаг ижил сэдэвчилсэн чиглэлээр ажилладаг компани, байгууллагуудаас бүрддэг. Орон нутгийн орон зайн хамаарал (Martin ба Sanli, 2006), гүйлгээний зардал МакКэнн, Шеппард (McCann and Sheppard, 2003), кластер доторх танин мэдэхүйн бага зай, танин мэдэхүйн том зай (Maskell, 2001) нь тухайн салбарыг газарзүйн хувьд тусгаарладаг бүс нутгийн шинж чанарыг бий болгодог Ригби, Эсслецбихлер (Rigby and Essletzbichler, 2006).

Гуравдугаарт М.Портер (1998)-ийн гурав дахь бөгөөд сүүлийн тодорхойлолт нь сэдэвчилсэн болон орон зайн хил хязгаар доторх компани, байгууллагууд хоорондоо "холбоотой" гэдгийг харуулж байна. Эдгээр харилцан холболтууд нь бараа, үйлчилгээний зах зээлийн солилцоо, хөдөлмөрийн зах зээлийн хөдөлгөөн,

зан төлөвийг дуурайх, олон нийтийн сүлжээ, нүүр тулан харилцах, хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл, технологийн ойр байдал, түүнчлэн технологийн үйл ажиллагааны хэвтээ ба босоо нэмэлт зэрэг худалдаалагдсан болон арилжаагүй харилцан хамаарлыг хэлнэ. Эдгээр харилцан холболтууд нь кластер эдийн засгийн аль салбаруудаас бүрдэх, ямар газарзүйн өргөтгөлтэй болохыг тодорхойлдог (Портер, 2003). Гэсэн хэдий ч харилцаа, солилцооны үйл явц нь нэг кластер дотор жигд тархдаггүй Жулиани (Giuliani, 2007). Тодорхой сэдвүүдийн эргэн тойронд өндөр нягтаршилтай харилцан уялдаа холбоо нь үйл ажиллагааны гол цэгүүдийг бүрдүүлдэг Кан Ву, Жиншиан Тан, Ин Лонг (Kang Wu, Jingxian Tang, Ying Long, 2019). Хийсвэрлэлийн түвшнээс хамааран кластер нь нэг фокусын эргэн тойронд үүсэх эсвэл хэд хэдэн фокусын цэгүүдээс бүрдэх ба тэдгээр нь эргээд ялгаатай дэд кластеруудыг үүсгэж болно. Жишээлбэл, Цахиурын хөндий дэх хадгалах хэрэгсэл, програм хангамж, хагас дамжуулагч кластерууд нь том компьютерын кластерын гол цэгүүд (дэд кластерууд) юм. Харилцан холболтууд нь сэдэвчилсэн төдийгүй орон зайн шинж чанартай байдаг. Өвөрмөц үйл ажиллагаа ихтэй газрууд нь ихэвчлэн залуу кластерууд дахь бизнес инкубаторууд байдаг ба кластерт нэгдсэн компаниуд, зангуу компаниуд эсвэл хуучин компаниудад төвлөрсөн компаниудын дундын байгууламжууд байдаг Фельдман, Флеминг, Франкен (Feldman, 2003, Fleming and Frenken, 2007). Эдгээр нь бодит солилцооны үйл явц, харилцан үйлчлэлийн орон зайн нөхцөл байдлыг хангадаг. Аж ахуй нэгжүүд кластерын газарзүйн төвд ойр байх хэрэгцээ нь тэдний байнгын нүүр тулан харилцах хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэмэгддэг. Энэ нь нэг хотын хороололд төвлөрдөг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, соёлын салбар зэрэг бүтээлч үйлдвэрлэлийн хувьд илт харагддаг Скотт (Scott, 2002). Тиймээс кластер өөрөө сэдэвчилсэн болон орон зайн төвлөрсөн цэгийн эргэн тойронд байгаа компани, байгууллагуудын эгзэгтэй массаас бүрддэг.





1.2.1. Кластерын загвар







Кластерын загварыг ихэвчлэн кластер эсвэл сегментийг бий болгоход ашигладаг бөгөөд дараа нь дараагийн шинжилгээнд орц болгон ашигладаг. Үүний нийтлэг жишээ бол зах зээлд оролцогчдын зах зээлээ нэг төрлийн дэд бүлгүүдэд хуваахад ашигладаг зах зээлийн сегментүүд юм. Сегмент бүр нь түүнд чиглэсэн маркетингийн хүчин чармайлтын амжилтад нөлөөлдөг тусгай шинж чанартай байдаг.

Маркетингийн стратегийг оновчтой болгохын тулд дата олборлолтыг ашиглаж байгаа бол тохирох сегментүүдийг тодорхойлж, тухайн сегментийн мэдээллийг урьдчилан таамаглах загвартаа ашиглах замаар сайжруулж болно. Кластерын загварыг аж ауй нэгж хоорондын харилцааны үүднээс ойлгохын тулд судлаачид ханган нийлүүлэгчийн гинжин хэлхээний харилцаа, шууд харилцааг харгалзан өөр загваруудыг тодорхойлсон байдаг.

Хот суурин газар болон бөөгнөрлийн онцлог шинж чанарууд дээр үндэслэн кластеруудыг дүрсэлсэн хэв шинжийг тодорхойлсон байдаг бөгөөд энэ нь кластерууд болон загваруудын хоорондын үзэл баримтлалын ялгааг харуулсан байна Малмберг, Солвелл, Зандер (Malmberg, Solvell, Zander, 1996) (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Кластер загварууд

№	Кластер загварын төрөл	Эрдэмтэн	Загвар	Элемент
1	Эдийн засгийн бөөгнөрлийн кластер загвар	Porter 1998, Krugman 1991		<ul style="list-style-type: none"> ✓ Судалгаа, шинжилгээний институци ✓ Инновац ✓ Эдийн засгийн нөлөөллийн хүчин зүйлүүд ✓ Салбар бүрийн фермүүд
2	Орчин үеийн кластер загвар	Markusen 1996		<ul style="list-style-type: none"> ✓ Кластер гишүүдийн үүрэг ✓ Хамтран ажиллагч аж ахуй нэгжүүд ✓ Худалдааны эрэлт, нийлүүлэлтийн суваг, сүлжээ ✓ Аж ахуй нэгж, иргэд ✓ Хөгжил тодорхойлох бусад хүчин зүйлүүд
3	Төвлөрсөн кластер загвар	Markusen 1996		<ul style="list-style-type: none"> ✓ Үндэстэн дамнасан корпорацууд ✓ Цөөн тооны давамгайлсан аж ахуй нэгжүүд ✓ Кластер аж ахуй нэгжүүдийн дийлэнх түүхий эд нийлүүлэх үйл явц ✓ Зөвхөн том компаниудтай худалдаа хийх процесс ✓ Төв үйлдвэрүүд доторх харилцаа, динамик
4	Төр төвтэй кластер загвар	Markusen 1996, Fallah 2011,		<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн байгууллага, агентлагууд ✓ Нэг тоглогч бүхий давамгайлсан том компани ✓ Жижиг, дунд кластер үйлдвэрүүд ✓ Ашгийн бус байгууллагууд

5	Даймонд загвар	Porter.M 1990		<ul style="list-style-type: none"> ✓ Микро эдийн засгийн түвшний кластер хөдөлгүүр ✓ Компанийн стратеги ✓ Бизнес эрхлэх соёл ✓ Тусгай үйлчилгээ бүтээгдэхүүнээр хангах ✓ Шинэ технологи, инновац ✓ Бусад дэмжигч байгууллагууд, иргэд
6	Таталцлын загвар /гравитаци/	Bergstrand 1985		<ul style="list-style-type: none"> ✓ Орон зай, газар нутгийн байршил ✓ Жижиг, дунд үйлдвэрийн төвлөрөл ✓ Гадаад, дотоод худалдаа ✓ Худалдааны эрэлт, нийлүүлэлт
7	Гурвалсан холбоост загвар	Etzkowitz 2002		<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн байгууллагын хүчин зүйл ✓ Жижиг, дунд үйлдвэрийн байгууллагууд ✓ Бизнес, инкубатор, тинк танк байгууллагууд ✓ Эдийн засгийн хүчин зүйлс ✓ Хүний нөөц ✓ Худалдааны сүлжээ байгууллагууд ✓ Дэмжигч байгууллагууд
8	Кластерын санаачилгын гүйцэтгэлийн загвар	Sölvell 2003		<ul style="list-style-type: none"> ✓ Төр, хувийн хэвшлийн түншлэл судалгаа ба судалгааны сүлжээ хөгжүүлэлт ✓ Лобби ба улс төрийн салбартай харилцах ✓ Арилжааны хамтын ажиллагаа ✓ Инновац, шинэ технологийг хөгжүүлэх
9	Кластер хүчин зүйлийн загвар	Sölvell, 2003		<ul style="list-style-type: none"> ✓ Төр, хувийн хэвшлийн институци ✓ Их, дээд сургууль ✓ Судалгаа шинжилгээний байгууллагууд /инкубатор, тинк танк/ ✓ Мэргэшсэн боловсон хүчний нөөц ✓ Эдийн засгийн хүчин зүйл ✓ Технологийн шинэчлэл, инновац ✓ Дэмжигч болон ТББ-ууд, медиа суваг
10	Кластер юүлүүр загвар	Sölvell, 2008		<ul style="list-style-type: none"> ✓ Дэлхийн болон улс орны эдийн засгийн хүчин зүйлүүд ✓ Кластер доторх эдийн засгийн харилцааны хүчин зүйл

(Эх сурвалж: Горилогчийн нэгтгэсэнээр)

1. *Эдийн засгийн бөөгнөрлийн загвар*: Ижил чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс бүрддэг бөгөөд инновац нь өрсөлдөөн, аж ахуй нэгжүүдийн хөгжлийг дэмжих чухал хүч болдог (Porter 1998, Krugman 1991).
2. *Орчин үеийн загвар*: Судлаач Маркусен (Markusen 1996) кластерын янз бүрийн гишүүдийн үүрэг, тэдгээрийн хоорондын харилцан үйлчлэлд үндэслэн кластерын загваруудыг тодорхойлсон. Маркусен орчин үеийн кластерын загварууд нь Маршалын загвартай харьцуулсан нэг төрлийн бие биетэйгээ хамтран ажилладаг жижиг аж ахуй нэгжүүдээс бүрдсэн, шууд өрсөлдөөнд эсвэл ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгчийн харилцаатай байдаг. Энэ загварт аж ахуй нэгжүүдийн аль нь ч кластерыг шууд хянах хэмжээ, хүч чадалгүй бөгөөд зөвхөн нийтлэг зах зээл, кластерын динамик нь түүний хэлбэр, хөгжлийг тодорхойлдог.
3. *Төвлөрсөн кластер*: Бөөгнөрлийн цөмийг төлөөлдөг цөөн тооны давамгайлсан аж ахуй нэгжүүд байдаг бөгөөд тэдгээртэй шууд холбоотой олон тооны жижиг аж ахуй нэгжүүдээр хүрээлэгдсэн байдаг. Кластерын аж ахуй нэгжүүдийн ихэнх нь түүхий эд, гадаад үйлчилгээ нийлүүлэгчдийг төлөөлдөг эсвэл төвийн үйлдвэрийн үйл явцын тодорхой үе шатанд мэргэшсэн байдаг. Жижиг аж ахуй нэгжүүд том компаниудтай шууд худалдаа хийдэг бөгөөд үйлчлүүлэгчийнхээ стратегиас хамаарсан ялгавартай байдаг. Төвлөрсөн үйлдвэрүүд нь кластер доторх харилцаа холбоо, түүний динамикийг тодорхойлдог.
4. *Төр төвтэй кластер загвар*: Маркусен, Фаллах (Markusen 1996, Fallah 2011) Тухайн бүс нутагт давамгайлж буй олон нийтийн, төрийн болон ашгийн бус байгууллага болон кластерын гишүүдийн хоорондын эдийн засгийн харилцааг тойрон тодорхойлогддог. Жишээ нь: АНУ-ын олон хувилбарт цэргийн томоохон бааз байдаг энэ байгууллага нь төр, хувийн хэвшлийн гэрээгээр ашиг хүртдэг олон тооны жижиг аж ахуй нэгжүүдээр хүрээлэгдсэн байдаг. Төрийн төвлөрсөн төрлийг хувийн хэвшлийн хяналтад байдаггүй нэг гол тоглогч байдаг зангилаа ба төвлөрсөн кластертай зүйрлэж болно.
5. *Даймонд загвар*: Энэхүү загвар нь бүх хүчин зүйлийн хоорондын харилцан хамаарлаар тодорхойлогддог бөгөөд Портерын төсөөллөөр микро эдийн засгийн түвшинд кластерыг хөдөлгөдөг хөдөлгүүр юм.

- *Хүчин зүйлийн нөхцөл* (тухайн нутаг дэвсгэрийн анхны нөөц) одоо байгаа эдийн засгийн орчин анхны эх үүсвэр нь үргэлж материаллаг биш, харин шинэ бизнес эхлүүлэхэд туслах хэд хэдэн нөхцөл байдал- Эдийн засгийн орчин нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн тоо, шинэ бизнес эрхлэх чадвар, тухайн бүс нутгийн бизнес эрхлэх соёлоор тодорхойлогддог,
- *Компанийн стратеги, өрсөлдөөний орчин* нь тэдний хувьсалд нөлөөлдөг, учир нь тэд тусгай үйлчилгээ, бүтээгдэхүүнээр хангах, өндөр шаардлагад нийцүүлэн чанар, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх-компаниуд улам бүр өрсөлдөөний орчинтой тулгарах шаардлагатай болж үр дүнтэй шийдэл нь хувьсан өөрчлөгдөж, инновац хийх, төрөл бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх явдал юм. Энэ хүчин зүйл нь нэг кластер дахь фирмүүдийн стратегиудын дунд байгууллагын зохион байгуулалтыг удирдах нөхцөл, өрсөлдөөний талуудыг хэлнэ. Хэрэв кластер компаниуд тасралтгүй тоймлож, шинэчилж, хөрөнгө оруулалт хийхийг сонговол өрсөлдөөнтэй хэвээр үлдэх болно. (Zhang 2006) аж ахуй нэгжүүдийн стратеги, өрсөлдөөн аль аль нь инновацийн системийн динамик дээр тулгуурлан бүс нутгийн өрсөлдөх чадварт нөлөөлдөг.
- *Зах зээлийн нөхцөл байдал* нь санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг илэрхийлдэг. Портерын даймонд дахь хүчин зүйлүүд нь кластерын хувьсалд нөлөөлж байгаа боловч тэдгээр нь хоорондоо холбоотой, бие биедээ нөлөөлдөг, хэрэгцээ, үйлчлүүлэгчгүй бол тухайн бүс нутгийн нөөц баялгийг олж харах бизнес эрхлэгчдийн санаачилга гарахгүй, кластерын өрсөлдөөний орчноос шалтгаалж анхны зах зээл нэмэгдэж болно,
- *Холбогдох болон туслах салбарууд* нь кластер бүхий аж ахуй нэгжүүдийг хөгжүүлэх, өрсөлдөх давуу талаа хадгалах боломжийг олгодог хүчин зүйлсийг тодорхойлдог. Компаниуд болон тэдгээрийн ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа нь инновацыг бий болгодог Зан (Zhang 2006). Инновацийн хувьд үйлдвэрийн процесст шаардлагатай шинэ технологиор хангаж чадах их сургууль, судалгааны төвүүд чухал хүчин зүйл болдог.

Кластерын хөгжлийн өөр нэг чухал хүчин зүйл бол инновац, тасралтгүй мэдээлэл солилцох явдал юм.

- Технологийн хамтын ажиллагаа, худалдан авалтад үндэслэсэн шууд шилжүүлэг,
- Дамжуулан шууд бус шилжүүлэг ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн буюу өрсөлдөөний ажиглалт ба шинжилгээ,
- Шууд бус дамжуулалтаар хуваагдах замаар судалгааны үр дүнд бий болсон санаа, технологид суурилсан шинэ бизнесийг дэмжих.

Эдгээр 4 багц хүчин зүйлийн хоорондын харилцаа хэдий чинээ хөгжиж, эрчимтэй байна төдий хэмжээгээр фирмүүдийн бүтээмж их байна.

6. *Таталцлын загвар*: Хүний үйл явцын үр дүнд бий болдог орон зай дээгүүрх аливаа хөдөлгөөний харилцан үйлчлэлийн ерөнхий хэлбэрийг харуулдаг. Таталцлын загварууд нь харилцан үйлчлэлийн загваруудын хамгийн өргөн хэрэглэгддэг төрөл юм. Тэдгээр нь орон зайн харилцан үйлчлэлийн загварыг задлан шинжилж, урьдчилан тооцоолоход ашигладаг математикийн томъёоноос бүрддэг. Концепц болох таталцлын загвар нь орчин үеийн шинжлэх ухааны газар зүйн хувьд үндсэн ач холбогдолтой юм. Энэ нь туйлын байрлалаас илүү харьцангуй санааг тодорхой ажил хэрэг болгодог.

7. *Гурвалсан холбоост загвар*: Мэдлэгийг капиталжуулах, шилжүүлэх нь боловсрол /оюун ухаан/, төр захиргаа, бизнес гэсэн кластерын хөгжлийн гурван чухал хүчин зүйлийн хоорондын хамаарлаар тодорхойлогддог.

Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн дотор бүрэлдэхүүн хэсэг бүрийн нэг нь нөгөөгөөсөө хамааралгүй боловч инновац, мэдлэгийг дамжуулах тал дээр давхацдаг төр-академик-үйлдвэрийн төрлийн харилцаа байдаг. (Etzkowitz, 2002) Мөн бүрэлдэхүүн хэсэг бүр ижил үүрэг гүйцэтгэдэг бөгөөд инновацийн үүсгүүр болох тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Энэ загварын хүчин зүйл бүр нь нөгөө гурваас хамааралгүй, тэдгээрийн хооронд тодорхой хамааралгүй загвараас эсвэл боловсрол, судалгаа нь төрөөс удирддаг төрийн томоохон тогтолцооны нэг хэсэг болох загваруудаас ялгаатай.

Гурвалсан холбоост загвар нь гурван хүчин зүйлийн нягт хамтын ажиллагаанд суурилдаг. Үүнд:

- Их дээд сургууль, судалгааны төвүүд нь технологи, мэдлэг, инновацыг нэвтрүүлэх зорилгоор хувийн хэвшлийн санхүүжилттэй төслүүдэд оролцох,

хувийн компаниудын санхүүгийн дэмжлэг, салангид технологи ашиглан шинэ бизнес бий болгож болно,

- Бизнесийн орчинд дээд боловсролыг судалгааны төсөлд хамруулж, хувийн бизнесийг дэмжих,
- Төрийн байгууллагууд нь хувийн компаниудад янз бүрийн үйлчилгээг аутсорсинг хийх замаар эдийн засгийн кластеруудыг бий болгоход тусалдаг. Технологийн паркуудыг хөгжүүлэхэд чиглэсэн бүс нутгийн хөгжлийн санаачилга, төслүүд нь кластерт хүргэж болзошгүй ирээдүйн бөөгнөрлүүдийн эхлэлийн цэг болж чаддаг.

8. *Кластерын санаачилгын гүйцэтгэлийн загвар: (КСГЗ) Зельвелль (Sölvell, 2003)*

Кластеруудыг дэмжих эсвэл шинээр бий болгоход хүргэж болох кластерын санаачилгыг хөгжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан тайлбарлахад хэрэглэгддэг. Хэдийгээр кластерын санаачилга нь кластераас болон шууд бусаар кластер руу чиглэсэн компаниудыг дэмжих төслүүдийг төлөөлдөг ч энэхүү шинжилгээнд чухал ач холбогдолтой гэж үздэг Зельвелль (Sölvell, 2003). Энэ загварт хамааралтай буюу шалтгаан-үр дагаврын хамаарал бүхий дөрвөн хүчин зүйл байдаг. Кластерын санаачилгын гүйцэтгэл, амжилтад нөлөөлж буй хүчин зүйлүүд нь:

- Нийгэм, улс төр, эдийн засгийн орчинд кластерууд нь үндэсний болон бүс нутгийн хөгжлийн хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрөгдсөн тул олон санаачилгыг төрийн хөрөнгөөр санхүүжүүлдэг төрийн төслүүд эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр эхлүүлдэг. Бүс нутгийг тодорхойлсон нийгэм, соёл, эдийн засгийн нөхцөл байдал нь ийм санаачилгыг эхлүүлэх боломжийг олгодог,
- Санаачилгын зорилгыг зургаан ерөнхий ангилалд хувааж болно. (Sölvell 2003): Судалгаа ба судалгааны сүлжээ хөгжүүлэлт, хувийн лобби ба улс төрийн салбартай харилцах, арилжааны хамтын ажиллагаа, боловсролын дэд бүтцийг хөгжүүлэх, инновац, шинэ технологийг хөгжүүлэх, хөгжил болон одоо байгаа кластерын өргөтгөл,
- Хөгжлийн үйл явц нь кластерын санаачилгын амьдралын мөчлөгийн үе шатуудыг тодорхойлдог санаачилгыг эхлүүлэх, төлөвлөх, санаачилгыг удирдах, санхүүжүүлэх, кластерын гишүүдийн удирдлага, аж ахуй нэгжүүдийг

татах бодлого, санаачилгыг дэмжих засаг захиргааны нэгжийг бий болгох, дотоод нөөцийг нэгтгэх, санаачилгыг цаашид бие даасан байдлаар хөгжүүлэх боломжийг олгох үйл явц юм.

Кластер санаачилгын гүйцэтгэлийн загварт үндэслэн кластерын санаачилгын гүйцэтгэлийг дараах байдлаар үнэлдэг. Үүнд:

- Үйлдвэр, судалгаа хоорондын холбоосны тоо, нарийн төвөгтэй байдал,
- Олон улсын цар хүрээтэй өрсөлдөх чадварын түвшин нэмэгдүүлэх,
- Шинэ технологийг хөгжүүлэх замаар хүрсэн инновац,
- Зах зээлд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар шинэ бизнесүүдийг татах кластер хөгжүүлэлт,
- Зорилгодоо хүрэх түвшин гэх мэт...

Кластерийн санаачилгын гүйцэтгэлийн загвар тодорхойлсон өөр нэг загвар нь кластерын хөгжилд нөлөөлж болох шийдвэр, үйлдлүүд дээр тулгуурлан бүтээгдсэн байдал юм.

9. *Кластер хүчин зүйлийн загвар.* (Sölvell, 2003) Үүнд:

- Засгийн газар болон орон нутгийн бүтцээрээ бүсчилсэн хөгжлийн төслүүдийг эхлүүлж, шинэ хөрөнгө оруулагчдыг татах, санхүүгийн хөшүүрэг өгөх, кластерын санаачилга, бүс нутгийн хөгжлийг удирдах бүтэц, агентлагуудыг тодорхойлж болно,
- Банк, хөрөнгө оруулалтын компани эсвэл бусад санхүүгийн сүлжээгээр төлөөлдөг санхүүгийн систем нь шинэ бизнесийг бий болгох эсвэл одоо байгаа бизнесийг өргөжүүлэх бизнес эрхлэгчдийн санаачилгыг дэмжихэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх,
- Их дээд сургуулийн төв, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс бүрдсэн боловсрол, судалгааны тогтолцоо нь мэргэжил, мэргэшсэн боловсон хүчний нөөцөөр хангах замаар инновацын үйл явцыг бий болгох буюу дэмжих. Технологи эсвэл мэдлэгийн дамжуулалт нь кластерын хөгжилд чухал хүчин зүйл болдог. Жишээ нь: Цахиурын хөндийн кластерын амжилтын түүхэнд мэдээллийн технологийн инновац, судалгааны хурдасгуур байна.
- Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ), төрийн болон хувийн хэвшлийн компаниуд, үндэстэн дамнасан корпорацууд нь кластерын цөмийг төлөөлдөг. Эдгээр

элементүүдийн хувьсал ба тэдгээрийн хооронд үүссэн харилцаа нь кластерын хөгжлийн загварыг бүрдүүлдэг. Үйлдвэрийн үйл явцын хэмжээ, нарийн төвөгтэй байдал, мэргэшлээс үл хамааран кластерын нарийн төвөгтэй байдал, хэмжээ нь түүнийг бүрдүүлдэг аж ахуй нэгжүүдийн тоогоор тодорхойлогддог,

- Дэмжих, хамтран ажиллах байгууллагуудыг төрийн бус байгууллага (ТББ), худалдаа аж үйлдвэрийн танхим, холбоод, төрийн байгууллагууд төлөөлдөг бөгөөд тэдгээр нь одоо байгаа кластерын хөгжлийг дэмжих, дэмжих зорилготой кластерын санаачилгыг эхлүүлэх,
- Медиа сувгууд нь кластерын санаачилгыг сурталчлах эсвэл кластерыг төлөөлөх брэндийг бий болгох-(Цахиурын хөндийн брэнд ийм жишээний нэг бөгөөд амжилт нь Шведэд шилэн кабелийн хөндий, Английн Мото спортын хөндий, Бельги дэх Фландерсийн мультимедиа хөндий, Германы Рейн-Майн бүс дэх Материалын хөндий зэрэг бусад кластерууд бий болсон. (Sölvell 2003).

10. Кластер юүлүүр загвар: Кластер нь эдийн засгийн бүх түвшинд нөлөөлдөг эдийн засгийн үзэгдэл юм (Sölvell, 2008).

- Бүс болон орон нутгийн микро эдийн засгийн хөгжлийн бодлого (М.Портерын даймонд тодорхойлсон хүчин зүйлүүд нь микро эдийн засгийн түвшинд голчлон байдаг)
- Дэлхийн болон улс орны эдийн засгийн орчны макро эдийн засаг,
- Кластер доторх эдийн засгийн харилцаагаар аж ахуй нэгжүүдийн түвшинд гэх мэт загварууд байдаг.

1.2.2. Гурвалсан холбоост загвар

Бид сэдвийг боловсруулахдаа дээрх 10 загвараас шинжлэх ухааны үндэс, арга зүй, практик ач холбогдол талаас гурвалсан холбоост загварын иш үндэс болгосон. Иймд, "Гурвалсан холбоос" гэсэн ойлголт нь кластерын онол үүсэх урьдчилсан нөхцөл байсан бөгөөд инновацыг бий болгох механизмыг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Олон улс орнуудын үндэсний инновацын тогтолцооны онцлогийг судалдаг дэлхийн тэргүүлэх мэргэжилтнүүдийн хамгийн үр дүнтэй загвар нь "гурвалсан холбоо" (Triple Helix) (Төр, үйлдвэр ба шинжлэх ухаан)


гэж үздэг бөгөөд инновац нь шинэлэг бүтээгдэхүүн бий болгох үе шат бүрд тодорхой байгууллагуудын идэвхтэй харилцан үйлчлэлийн үр дүн юм.

Гурвалсан холбоос нь гуравдагч элемент болох их сургуулиудыг нэмсэн төр-бизнесийн уламжлалт загвар дээр суурилдаг. Гурвалсан спираль онолын үндсэн санаа нь орчин үеийн, мэдлэгт чиглэсэн нийгэмд тэргүүлэх байр суурь нь шинэ мэдлэгийг бий болгодог байгууллагуудад хамаардаг. 1990-ээд оны дундуур биологи, нийгмийн шинжлэх ухааны "нийлэгжилт", нийгэм, биологийн мэдлэгийг нэгтгэсний үр дүнд их дээд сургууль, засгийн газар, бизнесүүд бий болсон (Etzkowitz, Leydesdorff, 2000).

Гурвалсан холбоосны тухай онолыг анх Эцковиц, Лейдерсдорф (Etzkowitz, Leydersdorff) нар инновацад суурилсан бодлого боловсруулах арга зүй хэмээн нэрийдэж байжээ. Энэ онол нь гурван талт уялдаа холбоог бий болгох нь оюун ухаан, бизнес, төр засгийн ач холбогдлыг онцолдог. Энэхүү онолын зорилго нь мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжил юм. Мэдлэгийн эргэлт нь мэдлэгийн эдийн засгийн эсвэл капиталтай (мэдлэгийн капитал) боломжтой шинэ нээлтүүд рүү хөтөлдөг. Гурвалсан холбоост гол тоглогчдын хувьд эргэлддэг, мэдлэгийн орон зайг бий болгохын тулд үргэлж хөдлөх ёстой. Их сургууль, аж үйлдвэрийн салбарын хүрээнд үргэлжилж буй харилцан үйлчлэлээс үүдэлтэй орчин үеийн харилцаа нь үндсэн судалгаа, аж үйлдвэрийн болон дээд боловсролын байгууллагуудын хоорондын түншлэлийн төслүүд, мөн санхүүгийн олон эх үүсвэрийг бий болгох судалгаа, хөгжлийн хөтөлбөрүүдийг хамтран зохион байгуулах замаар нийтлэг ашиг сонирхлоос үл хамааран гурав дахь гибрид урсгалыг бий болгож байна (Etzkowitz 2008). Гурвалсан холбоост /Triple Helix/ загвар нь мэдлэгт суурилсан нийгмийн гол цөм болсон шинэчлэлд шаардагдах нөхцөлийг сайжруулах түлхүүр нь төр-шинжлэх ухаан – үйлдвэр хоорондын харилцаанд төвлөрнө. Үйлдвэр нь гурвуулаа геликсийн эрч хүч болж, үйлдвэрлэлийн үүргийг гүйцэтгэж байхад засгийн газар шинэ мэдлэг, технологийг бий болгох үүргийг хуваарилсан их сургуулиудтай харилцах, тогтвортой харилцааг баталгаажуулах чадвартай гэрээт харилцаанд хяналт тавих үүрэг хүлээдэг. Энэ нь мэдлэгт суурилсан эдийн засаг үйлдвэрлэлийн үндсэн зарчмыг илэрхийлдэг. Бүс нутгийн өрсөлдөх чадвар, хөгжлийн тулгуур болсон динамикийг дүрслэх, тодруулахад туслах зорилгоор гурвалсан холбоост /Triple Helix Triangulation/ загвар нь орон нутгийн инновац, бизнес эрхлэлтийг

хөгжлийн хөшүүрэг болгон төвлөрүүлж буй гурвын геликст байгаа динамикийг ашиглаж буй шинэ загварыг харуулж байна. Бүс нутаг нь сүлжээний менежмент дээр тулгуурлан дэлхий даяар өрсөлдөх чадвартай бөгөөд тогтвортой байдлын гурван тулгуурт байгаль орчин, эдийн засаг, нийгмийн байдалд үндэслэсэн (Зураг 5. байдаг.

Зураг 5. Гурвалсан холбоост загвар



(Эх сурвалж: Luis Farinha, João J. Ferreira, *Triangulation of the triple helix: A Conceptual framework*)

Гурвалсан холбоост загвар (Triple Helix Triangulation) нь янз бүрийн зохиогчдын (Etzkowitz 2003) дурдсан гурван институтийн хүрээний (шинжлэх ухаан – үйлдвэр – төр) хоорондын интерактив харилцааны эргэн тойронд бүтэц Эцковиц Лейдерсдорф, Эцковиц, Жиса, Хуахай, Лейдер, Лейдерсдорф, Мейер, Смит, Багчи-Сем (Etzkowitz Leydersdorff, 2000, Etzkowitz, Дзиса, 2008, Huahai 2011, Leyder, Leydersdorff, Мейер, 2006; Smith, Bagchi-Sem, 2010) нь өөрөө тогтвортой харилцааны түлхүүр гол байгууллагууд юм. Гурвалсан холбоост загвар нь эмпирик дээр суурилсан судалгааг зохион бүтээж, хэрэгжүүлэхийн тулд явах цэг нь болдог. Энэ нь өөр хүрээнд болж буй харилцан үйлчлэлтэй харьцуулахад гарч буй асуултуудад хариулт өгөхөд өртөмтгий байдаг. Бүс нутгийн өрсөлдөх чадвар, хөгжлийн төлөөх кластерын динамик болон энтрепренершипийн хоорондын эерэг харилцааны таамаглал дээр тулгуурладаг бөгөөд энэ нь зохих судалгааны арга зүй (тоо хэмжээ эсвэл чанар)- гээр эмпирик баталгаажуулалт хэрэгтэй байдаг.

Гурвалсан холбоост хооронд үүсдэг орон зайн харилцан үйлчлэлийг дараах байдлаар задлан шинжилж болно:

1. Орон зайн шинжлэх ухаан: Энд янз бүрийн салбарын хувь хүмүүс мэдээлэл, санаа, бодлоо солилцоход анхаарлаа төвлөрүүлж оролцож эхэлсэн. Илтгэл, ойлголтууд цэцэглэн хөгжиж байнга бэхжиж байдаг.
2. Орон зайн зөвшилцөл: Энд тодорхой санаачилга, төслүүдэд хүргэх, шинэ компани байгуулах амлалтын хэлбэрүүд эхэлж байна. Мэдээлэл түгээснээр хүчирхэгжсэн нь найдвартай, төвийг сахисан учраас санал нэгтэй байхыг дэмжигчид байх нь тухайн хүмүүст итгэх итгэлийг бий болгодог.
3. Орон зайн инновац: Энд инновацыг албан ёсоор бий болгож, мэдлэгийн капитал болгон хувиргасан. Жишээлбэл, бизнесийг бодитой болгох, шинэ бүтээгдэхүүн бодит байдал бий болох, санхүүгийн байгууллагуудын оролцоо (жишээлбэл, Үрийн капитал /Seed capital/, Хувийн хөрөнгө оруулагчид /Angel Capital/, Хэтийн төлөвийн бизнест хөрөнгө оруулагч /Venture Capital/) болон төр засгийн дэмжлэгийг урамшуулал хэлбэрээр олгох, оюуны өмчийн эрх зөрчигдөхтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Гурвалсан холбоост үүсдэг орон зайг харилцан үйлчлэлээр дээрх байдлаар задлан шинжлэхээс гадна жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоо нь бүтэц, элементүүдээс бүрдэх бөгөөд бүтцийг нь зураг 5-р загварчилж харуулсан бол элементүүдийн нэгтгэсэн байдлыг хүснэгтээр харуулав (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцооны элемент

	Бүрэлдэхүүн хэсэг	Элемент
1	ТӨР	<ul style="list-style-type: none"> • Төрийн бодлого • Эрх зүйн зохицуулалт • Төрийн дэмжлэг • Төрийн байгууллагын тогтолцоо, бүтэц
2	АКАДЕМИК	<ul style="list-style-type: none"> • ШУ-ны байгууллага • Технологи дамжуулалт • Дээд боловсролын сургалтын байгууллага • Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага
3	ҮЙЛДВЭР	<ul style="list-style-type: none"> • Өрсөлдөөн, инновац • ЖДҮ, Аж ахуй нэгж байгууллага • Санхүү, хөрөнгө оруулалт • Хамтын ажиллагаа

4	Институци хоорондын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Төр-ШУ, боловсрол • ШУ, боловсрол-Үйлдвэр • Үйлдвэр-Төр • Инновац, хөрөнгө оруулалтын капитал
---	--	--

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Гурвалсан холбоост институцын гүйцэтгэх үүрэг

1. Төр

Бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгийн оролцоо, ялангуяа бүс нутгийн автономит байдал, ардчилал, сайн засаглалын зарчмуудыг илүү сайн удирдах шаардлагатай. Гурвалсан холбоос нь шинэчлэлийн гол төлөвлөгөө болдог бөгөөд үр дүнд хүрвэл бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх эерэг нөхцөл болдог. Бүтээлч эдийн засгийн бүтээн байгуулалтын хөгжил нь байршил, бүтээлч сэтгэлгээ (ардчилалтай ижил утгатай) хүчтэй нөлөөлдөг гэж мэргэжилтнүүд үздэг.

Сайн засаглалын зарчмууд байхад; оролцоо, хууль дээдлэх, ил тод байх, хариу үйлдэл үзүүлэх, тэгш байдал (шударга байдал), стратегийн алсын хараа, үр дүн, мэргэжлийн хариуцлагатай, хяналт зэрэг нь бүтээлч үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж чадах зарчим юм. Төр засаг хүмүүсийн хүсэл тэмүүллийг мэдэрч, үнэлж байх ёстой байдаг. Оюун ухаант хүн бүтээхдээ зөвхөн богино хугацаанд гүйцэтгэх боломжгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Оюун ухааныг хөгжүүлэх, баяжуулах үйл явцыг сурах үйл явц байдаг гэсэн үг юм. Бат бөх тулгуурт суурилсан хөгжилгүйгээр эцсийн үр дүнг богино хугацаанд хэрэгжүүлэх нь эдийн засгийн сул бүтэц, тогтворгүй байдлыг бий болгоно. Засгийн газрыг төлөөлж оролцогчид төрийн албыг тэнцүү хэмжээнд ил тод, тэгш хүртээмжтэй, сэтгэлгээтэй харилцах чадвартай байх чухал юм.

Бүтээлч үйлдвэрийг хөгжүүлэхэд төр засгийн гол үүрэг нь:

Хөгжингүй орнуудын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төрийн байгууллагын бүтцийн судалгаанаас харахад АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Жижиг бизнесийн захиргаа” (Small Business Administration) хэмээх байгууллага нь зохион байгуулалтын хувьд үр ашигтай хувилбар болох нь тодорхой байна. Уг байгууллага нь жижиг, дунд үйлдвэрийг АНУ-ын тогтвортой хөгжлийн баталгаа болоод зогсохгүй, жижиг, дунд үйлдвэрийн хүчин чадлыг тодорхойлж, Европын Холбооны улсууд, Англи, Япон болоод бусад орнуудын жижиг, дунд үйлдвэрийн дэмжлэгийн тогтолцоог нутагшуулан ажиллаж байна.

Төрөөс ЖДҮ-ийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү байгууллага нь Засгийн газрын ямар нэг байгууллагад бус зөвхөн Ерөнхийлөгчид шууд харьяалагдан ажиллаж ирсэн байна. Тус байгууллагыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Сенатаар батлагдсан Зөвлөл удирддаг байна. (Ч.Даваабаяр, 2016) Өнөөгийн байдлаар Жижиг бизнесийн захиргаа нь жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих Дэлхийн хамгийн том мэргэшсэн төрийн байгууллага болжээ. 2002 онд жилийн төсөв 18 тэрбум доллар байхад жижиг, дунд үйлдвэрлэлд зориулж янз бүрийн эх сурвалжаас 400 тэрбум долларын төсөв бүрдүүлсний дотор 46 тэрбум долларыг улсын захиалгаас бүрдүүлсэн байдлаас харахад Жижиг бизнесийн

захиргааны үйл ажиллагааг тодорхойлж болно. Жижиг бизнесийн захиргаа нь бүс нутаг хотуудад 108 төлөөлөгчийн газартай бөгөөд бүх мужид 4.2 мянган ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Жижиг, дунд үйлдвэрийг төрөөс жижиг бизнесийн захиргааны салбарууд эсвэл бүрэн эрхт итгэмжлэгдсэн компани, хамтрагч байгууллага, фирмүүдээр мөн түүнчлэн зөвлөгөө өгөх төв, бизнес төвүүдээр дамжуулан дэмжиж ирсэн байна. Энэхүү байгууллага нь АНУ-д холбооны төвөөс бүрэн болон бүрэн бусаар санхүүждэг бүрэн эрхт компани, бизнес төв, зөвлөгөө өгөх төв, салбар, төлөөлөгчийн салбар газруудыг хамруулан ажиллаж байна.

Төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих нэг үндсэн чиглэл нь төрийн захиалгын боловсронгуй тогтолцоогоор дамжуулан зээлийн батлан даалт гаргах, санхүүгийн нөөцийг нь хангах үүднээс хөрөнгө оруулалтын зээл олгох ажлыг хувийн компаниудыг түшиглэн зохион байгуулах явдал юм. 2000 оны байдлаар 300 орчим фирмүүдийн кластер олон салбарыг хамарсан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр нь нийлээд тус улсын нийт ажиллах хүчний 57 орчим хувийг ажиллуулдаг бол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 61 орчим хувийг үйлдвэрлэдэг гэсэн тооцоо байна. (Rosenfeld in OECD 1996)

АНУ-д хамгийн амжилттай кластерууд нь байгалийн гаралтай буюу зах зээлийн жамаар үүссэн кластерууд юм. Тиймээс эдгээр байгалийн тогтцыг дэмжиж, хөгжүүлэхийн тулд орон нутгийн удирдлагууд юу хийж чадах, юу хийх ёстойг үргэлж анхаарч байдаг. Цаг хугацаа өнгөрөхөд Холбооны Засгийн газрын кластерын сэдэвт хандах хандлага өөрчлөгдөж, кластерын бодлогын тусгай арга хэмжээг нэвтрүүлсэн байна.

АНУ-д хийсэн сүүлийн үеийн судалгаанууд нь өндөр технологийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх ажлыг хурдасгах механизм болох инновацын кластеруудыг хөгжүүлэхэд Холбооны засгийн газраас илүү анхаарал хандуулахыг уриалж байна. Энэ нь төсвийн хөрөнгийг зарцуулах үр ашгийг нэмэгдүүлэх ёстой гэж судлаачид үзэж байна. Одоогийн байдлаар нэрт эдийн засагч М.Портерын хэлснээр АНУ-ын холбооны хөтөлбөрүүд нь "ихэвчлэн хуваагдмал, давхардсан, үр ашиггүй" байна гэж хэлсэн байдаг. Одоо үед эрчим хүч, худалдаа, батлан хамгаалах, хөдөө аж ахуй, хөдөлмөр, боловсролын яамдаас кластер хөгжүүлэх шинэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвхөн боловсруулж байгаа нэг арга бол тодорхой салбарын кластеруудыг бий болгох, дэмжих хэд хэдэн хэлтсийн хүчин

чармайлтыг нэгтгэх явдал юм. Жижиг бизнесийн удирдлага, Стандарт, технологийн үндэсний хүрээлэн, Эдийн засгийн хөгжлийн газар, Үндэсний шинжлэх ухааны сан, Боловсролын хөгжлийн төв зэрэг байгууллагууд АНУ-ын Эрчим хүчний яамны санаачилгад нэгдэн "эрчим хүчний инновацын төв"-ийг байгуулсан байдаг. Эрчим хүчний инновацын төв нь нарны эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтэц, цөмийн эрчим хүчний салбар дахь бүс нутгийн инновацын кластеруудыг хөгжүүлж байгаа юм. Өөр нэг ижил төстэй санаачилга 2009 онд эхэлсэн бөгөөд Жижиг бизнесийн удирдлага нь Мичиган, Виржиниа, Хавай мужуудад роботын кластер байгуулахаар Батлан хамгаалах яамтай хамтран ажиллаж байна. АНУ-ын Үндэсний Шинжлэх Ухааны сан нь сурган хүмүүжүүлэгч, оюутнуудад өөрсдийн инновацыг арилжаанд оруулах, аж үйлдвэртэй холбоо тогтоох, гарааны бизнесийг бий болгоход тусалдаг бүс нутгийн инновацын кластеруудыг дэмжих Үндэсний Шинжлэх Ухааны Сангийн Инновацын Экосистемийг дэмжих зорилгоор 12 сая долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

АНУ-д үйлдвэрийг кластераар хөгжүүлэхээс гадна үйлдвэр технологийн парк байгуулсан туршлагаас дурдвал муж тус бүрд олон тооны аж үйлдвэрийн паркууд ажиллаж бараг бүх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн байна.

Америкийн "ИОВА" ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК нь 147 гаруй корпорацитай бөгөөд түүний үйлдвэрлэл, цех, тасаг технологийн бизнесийн төвд нийт 4300 байнгын ажиллагсад ажиллаж байна. Тус Парк нь Ховкий Их сургуулийн дэмжлэгтэйгээр шинээр бизнес эхлэх болон бизнесийнхээ цар хүрээг өргөжүүлэхээр зорьж буй паркт харьяалагдах компанийн ажиллагсад зориулан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Иова паркт үйл ажиллагаагаа эрхлэх аж ахуй нэгжид Засгийн газраас дараах хэд хэдэн санхүүгийн урамшуулал үзүүлдэг байна. Үүнд:


- Газрын урамшуулал
- Татварын урамшуулал
- Зарим зээл тусламжийн урамшуулал
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт
- Эхний жилийн орлогын албан татварт 75 хувийн хөнгөлөлт
- Үл хөдлөх хөрөнгийн татвараас 5 жил чөлөөлөлт

- Гадаад улсад борлуулалт хийсэн бол борлуулалтын орлогод улсын орлогын татвар төлөхгүй
- Иовад борлуулсан орлогоос татвар ноогдох орлогыг тооцохдоо компанийн орлогын татварт 50 хувийн чөлөөлөлт эдэлнэ. (“Сүхбаатар хөгжил” УТП, ТЭЗҮ)

Иова УТП-ын гол давуу тал буюу маркетинг нь төр засгаас үзүүлж буй дэмжлэгээс гадна нэгж компаниудын хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэж гарааны компаниудыг дэмждэгээрээ давуу талтай байдаг.

АНУ-д бүс нутгийн эдийн засаг бол өрсөлдөх чадварын тулгуур хэсэг бөгөөд улс орны өндөр үнэ цэнтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх чадвар нь инновацын төв болох салбаруудын бүс нутгийн кластеруудыг бий болгож, бэхжүүлэхээс хамаарна. Кластерууд нь технологи, мэдээлэл, мэргэшсэн авьяас чадвар, өрсөлдөгч компаниуд, эрдэм шинжилгээний байгууллага болон бусад байгууллагуудыг нэгтгэснээр бүтээмжийг нэмэгдүүлж, инновацыг идэвхжүүлдэг (Зураг 8).

Зураг 8. АНУ-ын зарим кластерууд



(Эх сурвалж: <https://hbr.org/1998/11/clusters-and-the-new-economics-of-competition>)

АНУ-ын үйлдвэрийн кластерын мэдээллийн нэгтгэсэн байдлыг судалгааны ажлын хавсралтын хүснэгт ..-с харна уу.

Ойролцоох кластерууд түүнийг дагасан нягт уялдаа холбоо зах зээлийн талаар илүү сайн ойлголттой болох, илүү нарийвчилсан судалгааны хөтөлбөрүүд, илүү том мэргэшсэн авьяастнуудыг нэгтгэх, шинэ мэдлэгийг илүү хурдан нэвтрүүлэх боломжийг олгодог. Тухайн байршил дахь холбогдох салбаруудын эдийн засгийн үйл ажиллагаа эгзэгтэй хэмжээнд хүрдэг кластерууд бас байдаг. Чухам энэ үед орон нутгийн уялдаа холбоо нь компаниудын гүйцэтгэлд чухал нөлөө үзүүлж, холбогдох салбар дахь аж ахуй нэгжүүд болон бусад байгууллагуудын орон нутгийн хамтын ажиллагааны чухал боломжууд гарч ирдэг. Зах зээлийн үйл явцад кластерууд аяндаа бий болж, томрох тусам компаниудад бүтээмжийн үр ашгийг өгдөг. Тэд шинэ байршил хайж буй компаниудын сонирхлыг татахуйц болж, тэнд байрладаг компаниудын гүйцэтгэлээр өсдөг. Кластерт багтсан компаниуд бүс нутгийн мэргэшсэн ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид, байгууллагуудад хандах боломжтой болохоос гадна чадварлаг ажилтнуудын нөөц, тэдний хэрэгцээнд зориулагдсан хамтын дэд бүтцээс ашиг тус хүртэх боломжтой байдаг. (М.Портер 1998)

1.3.4. Европын холбоо

Европын Холбооноос эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай тунхаглалыг 1997 онд гаргасан байдаг. Энэ тунхаглалд кластеруудад тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоог шинэчлэх нь Европын орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны нэн тэргүүний зорилтуудын нэг мөн гэж тодорхойлсон юм. Европын кластерын санамж бичиг (The European Cluster Memorandum)-ийг 2007 онд гарган хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү санамж бичигт Европын холбооны орнуудад илүү хүчтэй, илүү боловсронгуй кластеруудыг байгуулж хөгжүүлэх, энэ чиглэлээр Засгийн газрууд улам идэвх санаачилгатай ажиллах, Дэлхийн түвшний кластеруудыг байгуулж хөгжүүлэх зэрэг томоохон зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Гетерборг 2003 онд танилцуулсан Кластерын санаачилгын ногоон ном (Micheal E.Porter, The Cluster Initiative Green book) Европын Холбооны орнуудад кластеруудыг байгуулан хөгжүүлэх гол удирдамж, чухал гарын авлага болсоор байна (Л.Цэдэндамба, 2011).

Европын кластерын холбоо нь 2006 оны 09 дүгээр сард байгуулагдсан нээлттэй платформ бөгөөд кластерын бодлого боловсруулах, кластерын хөтөлбөрийг удирдах, санхүүжүүлэх үүрэгтэй үндэсний болон бүс нутгийн төрийн

байгууллагуудын хооронд ЕХ-ны түвшинд улс төрийн яриа хэлэлцээг дэмжих зорилготой байгууллага бөгөөд байгууллагын зорилго нь нөөцийг нэгтгэх, илүү үр дүнтэй кластерын бодлого боловсруулах, үндэсний хэмжээнд чиг үүргийн давхардал, давхардлаас зайлсхийх явдал юм. 2008 оны 01 дүгээр сараас эхлэн кластерын бодлого боловсруулагч болон аль ч кластер санхүүгийн байгууллага тус холбооны бусад түншүүдтэй туршлага хуваалцах хүсэлтэй, хамтарсан үйл ажиллагаа явуулах сонирхолтой Европын кластерын холбоонд нэгдэх боломжтой болсон байна.

Europe INNOVA нь 2007 онд Европын Комиссын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, инновацыг дэмжих үндсэн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн санаачилга бөгөөд байгууллагын гол зорилго нь аж ахуйн нэгжүүдийн инновацыг бий болгох үйл явцыг хялбаршуулах зорилгоор инновацын дэмжлэг үзүүлэх шинэ хэрэгслийг боловсруулах, турших, сурталчлах инновацын лабораторийг бий болгох зорилготой байгуулагджээ Лундберг (Lundberg, 2016).

Тус байгууллага нь холбооны түвшинд кластерын бодлогод ихээхэн ач холбогдол өгч ирсэн бөгөөд кластеруудыг дэмжих арга хэмжээг илүү нарийвчлан судалсан байдаг. 1999 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас янз бүрийн улс орнуудын кластерын хөгжлийн талаар томоохон хэмжээний судалгаа хийсэн байдаг. Кластерууд нь ихэвчлэн доороос дээш бий болдог нь тогтоогдсон, өөрөөр хэлбэл орон нутгийн санаачилга юм. Тэдний гадаад төрх нь зах зээлийн эрэлтээс үүдэлтэй бөгөөд судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэн кластерын төрийн бодлого ямар байх ёстой вэ гэсэн гурван үндсэн дүгнэлтийг гаргасан байна:

1. Кластер нь төрийн оролцоогүй харин зах зээлийн хүчний үр дүн үүсэх,
2. Төрийн бодлого нь үйлдвэрлэл, компаниудад татаас өгөхөд чиглэгдэх бус,
3. Төрийн бодлого нь шууд хөндлөнгийн оролцооноос зайлсхийж, голчлон шууд бус байдлаар ажиллах хэрэгтэй гэж үзсэн байна. Хамгийн сүүлд 2012 онд 13 агро кластерт хийсэн судалгаагаар кластеруудыг доороос нь эхлүүлдэг, төрийн дэмжлэгийн бодлого нь идэвхтэй оролцоотой биш харин дэмжсэн байх ёстой гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Компани, их дээд сургууль болон бусад бүтцийг өөрөө зохион байгуулах нь нэлээд ховор бөгөөд муж, бүс нутгийн түвшинд кластер байгуулах нь илүү түгээмэл байдаг гэж дүгнэсэн байна. Зарим судалгаанаас

харахад одоогоор Европын Кластер ажиглалтын төвийн тооцоолсноор Европын 216 бүс нутагт 1205 кластер байгууллага байна (The European Cluster Observatory 2015).

Европын кластерын ажиглалтын төвөөс 2012 онд хийсэн өөр нэг өргөн хүрээтэй судалгаанд кластер байгуулах асуудлаар санал гаргасан байдаг бөгөөд энэ баримт бичигт кластерыг санаачлагч нь бараг адилхан төр, бизнесийн аль аль нь байж болно гэж үзсэн байна. Энэхүү судалгаа нь кластерын хөгжлийн хэд хэдэн сонирхолтой хандлагыг илрүүлсэн. Кластерын судалгааны гадаад үр дүнг нэгтгэн дүгнэх нь кластерын санаачилгад оролцохын ашиг тус, кластерыг амжилттай хөгжүүлэх хүчин зүйлсийг системчлэх, кластер ба технологийн платформ хоорондын харилцааны боломжит шинж чанарыг үнэлэх боломжийг олгодог. Кластерын давуу талууд нь:

- Янз бүрийн эх сурвалжид хандах,
- Харилцаа холбоо, түүний дотор хэвтээ,
- Судалгаа, хөгжүүлэлт аутсорсингийн янз бүрийн хэлбэрүүд,
- Бизнес эрхлэх соёлын өөрчлөлт - итгэлцлийн өсөлт;

-Бүтээгдэхүүн, технологийг бий болгох дэлхийн сүлжээ, сүлжээнд нэвтрэх боломжийг хөнгөвчилдөг байна. Энэ жагсаалт нь ялангуяа кластерын бодлогын үүрэг яагаад нэмэгдэж байгааг тайлбарлав. 2003 онд судалсан кластерын 250 санаачилгын гуравны хоёрыг Засгийн газар дэмжсэн байдаг бөгөөд үүний зэрэгцээ нийт тохиолдлын 52 хувьд нь Засгийн газар гол ивээн тэтгэгчээр ажилласан. 2009 онд Европын холбооны нэг хэсэг болох Европын 31 орны 26 нь кластерын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн байна. Тиймээс Европын зарим орны үйлдвэрийн кластерын байдлыг судалгааны ажлын хавсралтын хүснэгт ..-с дэлгэрүүлж харна уу.

Европын кластерын ажиглалтын төв нь ЕХ-ны түвшинд ажиллаж эхэлсэн бөгөөд Ази, Латин Америкийн хэд хэдэн улс кластерын стратегиа боловсруулж байна.

Засгийн газар байгуулсан л бол амжилттай кластер бий болгоход шаардлагатай хүчин зүйлүүд нь:

- Кластерыг хөгжүүлэхэд орон нутгийн иргэдийн сонирхол;
- Кластер үүсгэх тодорхой технологи;

- Олон нийтийн судалгааны лаборатори эсвэл дотоодын компаниудтай хамтран ажиллах боломжтой их сургууль байгаа эсэх;
- Жижиг, дунд үйлдвэр, улсын шинжлэх ухааны лабораториудын хооронд мэдээлэл солилцох сүлжээтэй байх;
- Салбар, байгууллагуудын хэвтээ хөдөлгөөнөөс шалтгаалан мэргэшсэн боловсон хүчин, тэдгээрийн хоорондын нягт уялдаа холбоо;
- Санхүүгийн эх үүсвэрийн олон талт байдал, түүний дотор венчур санхүүжилтийн боломж;
- Бүс нутагтаа тэргүүлэгч компаниуд байгаа эсэх;
- Компаниудын хамтын ажиллагаа, тоног төхөөрөмжийг хамтын ашиглах боломж;
- Бизнес эрхлэх сүнс байгаа эсэх;
- Орон нутгийн засаг захиргааны ойлгомжтой бүтцийн аж үйлдвэрийн бодлого;
- Уламжлал, түүхэн нөхцөл байдал гэх мэт юм.

Үүний үр дүнд кластерыг хэрэгсэл болгон ашиглах нь маш эрсдэлтэй гэж тооцогддог, учир нь кластерын санаачилга урт хугацааны үнэ цэнэтэй байдаг тул дэмжлэг үзүүлэх объектыг сонгоход алдаа гарсан тохиолдолд алдагдал их байх болно. Бараг бүх кластерын санаачилгад төсвийн талаас илүү хувийг төсвийн хөрөнгө эзэлдэг бөгөөд кластеруудыг бие даах тогтолцоонд шилжүүлэх нь ихэнх тохиолдолд асуудалтай байдаг. Үүнтэй холбогдуулан ерөнхийдөө шинэ кластер үүсгэхгүй, харин одоо байгаа кластеруудыг олж тогтоох, хадгалах нь илүү үр дүнтэй гэж үзэв. (Ковров Г.С, Никифорова В.В, Константинов Н.Н 2017)

1.3.5. Олон улсад жижиг, дунд үйлдвэрийн кластерыг урамшуулах арга

Импортыг орлох бодлого, гадаадын өрсөлдөгчдийн худалдааны саад тотгорыг нэмэгдүүлэх, үндэсний инновацын тогтолцоо, дэд бүтцийг бий болгох, бүс хоорондын солилцооны зохицуулалтад суурилсан үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн төвлөрлийг сааруулах, улс орны тодорхой бүс нутгийн хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх бодлого юм. Ийнхүү өөр өөр улс оронд кластеруудын зохион байгуулалтад чухал ач холбогдолтой онцлогууд байдаг.

Дэлхийн улс орнууд ямар жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хөгжүүлэн амжилттай ажиллуулж үр дүнд хүрсэн талаарх тодорхой туршлагыг Хятад, АНУ, ОХУ, Европын

холбоо зэрэг улс орнуудын жишээн дээр судалж үзэв. Улс орнуудын туршлагаас харахад шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааг төрөөс дэмжих, урамшуулахын тулд татвар, санхүү, зээлийн болон хөрөнгө оруулалтын уян хатан бодлогыг хэрэгжүүлж байна.

Шинэ технологи эзэмшиж өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрийн бизнест зориулж төрөөс орлогын, гаалийн болон НӨАТ-ын зарим түрээсийг хөнгөлөх ялгавартай ноогдуулах зэрэг урамшууллын арга хэмжээг авч хэрэгжүүлдэг бөгөөд дэвшилтэт технологи, инновацтай холбоотой шинэ мэдлэг, патент, лиценз, шинэ санаачилгын зардал, төлбөрийн асуудалд төрийн зүгээс хөнгөлөлт үзүүлэх, зарим тохиолдолд зардлыг бүрэн даах замарч дэмждэг. Эдгээр улсын тоонд БНХАУ, Австрали, Малайз зэрэг улс ордог ч эдгээр хөнгөлөлтийг ихэнх тохиолдолд анагаах ухаан болон байгалийн шинжлэх ухааны салбарт хийгдсэн шинэлэг санаа, патент зэрэгт хамаарч байна.

НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын энэхүү бүлэгт кластерын тухай онолын ойлголтыг түүхэн цаг хугацаануудад гадаадын олон эрдэмтэн, судлаачид өөр өөрийн тодорхойлолтыг дэвшүүлэн тавьсан байдлыг судалгаанд хүснэгтээр нэгтгэн харуулсан нь Монгол улсад жижиг, дунд үйлдвэрийн кластер хөгжлийн асуудлыг судлах судлагдахуун, онолын материал болж байгаа юм.

Дэлхийн хөгжсөн улс орнууд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх үйл явц нэлээдгүй цаг хугацааг туулж шинжлэх ухааны үүднээс судлагдсан байдлыг энэхүү бүлэгт онол, практик талаас нь судлан харуулсан нь судалгааны шинэлэг тал болсон гэж харж болно.

Жижиг, дунд үйлдвэрийн кластер загвар, тогтолцоо, цаг хугацааны амьдралын мөчлөг, түүнийг үнэлэх арга зүйг судалснаар төрийн байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, аж ахуй нэгжүүд, бизнес эрхлэгч нар, иргэд, их, дээд сургуулийн оюутан, байгууллагын судлаачдад онолын мэдлэг, практик туршлага олгоход хэрэгцээт материал болсон гэж үзэж байна.

Дэлхийн олон улс орнуудын жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлсэн байдлыг судлаачид судласан байдаг хэдий ч судалгаанд чухал гэж үзсэн Хятад, ОХУ, АНУ, Европын орнуудад жижиг, дунд үйлдвэрийн кластерыг хөгжүүлсэн байдлыг судлахын ач холбогдол нь хөрш 2 орны үйлдвэрийг кластераар хөгжүүлсэн байдалд дүгнэлт хийж төр, шинжлэх ухаан/боловсрол, бизнесийн байгууллагын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт татах, барууны орнуудын үйлдвэр хөгжлийг харьцуулж хөгжүүлэх боломж, судалгааны анхдагч чухал хүчин зүйл, бүтээл, судлагдахуун болоход онол, практикийн хэрэгцээг хангасан гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕРЫГ ҮНЭЛЭХ НЬ (Сүхбаатар аймгийн жишээн дээр)

2.1. Жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа

2.1.1 Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр нь 1921 оноос өмнө Халхын Сэцэн хан аймгийн Чин ван хошуу, Далай ван хошуу, Ёст бэйс хошуу, Эрх гүн хошуу, Хурц засаг хошуу, Егүзэр хутагтын шавь хошуу гэсэн 6 хошууны нутаг. 1931онд Халхын 4 аймгийг 13 аймаг болгон өөрчлөхөд Хэнтий, Дорнод аймагт харьяалагдаж байв. 1940-1942 оны засаг захиргааны өөрчлөлтөөр 1942 онд Жавхлант шарга аймаг шинээр байгуулагдсан (Зураг 9).

Зураг 9. Сүхбаатар аймгийн эдийн засгийн орон зай



(Эх сурвалж: Горилогчийн нэгтгэл)

Улсын бага хурлын 1943 оны 2-р сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Жавхлант шарга аймгийг их жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит болгож “Сүхбаатар аймаг” гэж нэрлэх болсон. Аймгийн төвийг Баруун-Урт голын дэргэд шилжүүлэн суурьшуулж “Баруун-Урт” гэж нэрлэсэн байна. Тус аймаг нь засаг захиргааны 13 сум, 67 багтай, 65 мянга гаруй хүн амтай, аймгийн төв Баруун-Урт хот 22 мянган гаруй хүн амтай. Хүн амын олонх нь Халх, Дарьганга ястан бөгөөд Үзэмчин, Барга, Хуучид, Өөлд, Цахар ястан цөөнх хувийг эзэлдэг. Нутгийн хилийн нийт урт 1340 км бөгөөд урд талаараа БНХАУ-тай 485 км, баруун талаараа Дорноговь аймагтай 165 км, хойд

талаараа Хэнтий аймагтай 260 км, зүүн хойд талаараа Дорнод аймагтай 430 км газраар тус тус хиллэдэг. Эрдэнэцагаан сумын нутаг дахь Бичигт боомт нь 2008 оноос эхлэн байнгын ажиллагаатай болж өргөжсөнөөр ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг, Зүүн Үзэмчин хошуутай гадаад хамтын ажиллагаатай ажиллаж байна. Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй, уул уурхайн салбар бөгөөд нутгийн шилмэл омгийн Баяндэлгэрийн улаан ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хонь, Түмэнцогтын махны хэвшлийн үхэр, хурдан удмын адуун сүрэг, уул уурхайн хувьд цайр, зэс молибден, хүрэн нүүрс, хайлуур жонш, гянтболд зэрэг орд газруудтай. Аймаг, сумдын төв эрчим хүчний систем болон мэдээлэл харилцаа холбооны сүлжээнд бүрэн хамрагдсан байна.

Хүн ам зүй

Сүхбаатар аймаг нь 2022 оны эцэст урьдчилсан дүнгээр 19.1 мянган өрх, 65.9 мянган суурин хүн амтай болж урьд оноос өрх 329, хүн ам 684 хүнээр өслөө. Нийт өрхийн 49.5 % нь аймаг, сумын төвд, хүн амын 50.2 % нь хөдөөд амьдарч байна. Хүн амын 49.9 % нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 59.3 % - ийг 15-59 насныхан, 32.6 % - ийг 0-14 насныхан, 8.1 % - ийг 60 ба түүнээс дээш насныхан эзлэх болсноор хүн ам зүйн ачаалал 60.0 % - тай байна. Сүхбаатар аймагт Монгол улсын нийт хүн амын 1.97 хувь, зүүн бүсийн нийт хүн амын 28.4 хувь нь оршин сууж байна. (Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал” СХ)


Хөдөлмөр эрхлэлт

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 15 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны 44.0 мянган хүн байна. Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амын тоо 27.7 мянга байгаа нь 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 62.9 хувийг эзэлж байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 27.7 мянга буюу 99.3 хувь нь ажиллагчид, 0.8 мянга буюу 0.7 хувь нь ажилгүй иргэд байна. (Сүхбаатар аймаг, СХ)

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Сүхбаатар аймгийн ДНБ нь Монгол улсын ДНБ-ний 1.4 хувь, Зүүн бүсийн 26.9 хувийг эзэлж байгаа нь Дорнод аймгаас 41.0 хувиар, Хэнтий аймгаас 1.6 хувиар тус тус доогуур үзүүлэлттэй байна (Зураг 10).


Зураг 10. ДНБ, аймгаар (сая.төгрөг)



(Эх сурвалж: ҮСХ, Сүхбаатар аймаг, СХ)

Сүхбаатар аймгийн ДНБ 2021 оны жилийн эцсээр 590.1 тэрбум төгрөг, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 9.1 сая.төгрөг, аймгийн төсвийн татварын орлого 10,01 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 8,4 хувиар өссөн байна (Зураг 11).


Зураг 11. Нэг хүнд ногдох ДНБ (мянган төгрөгөөр)



(Эх сурвалж: ҮСХ, Сүхбаатар аймаг, СХ)

Сүхбаатар аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 9.1 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 4157.2 мянган төгрөг, зүүн бүсээс 501.9 мянган төгрөг, Дорнод аймгаас 2785.0 мянган төгрөгөөр тус тус доогуур, харин Хэнтий аймгаас 1515.7 мянган төгрөгөөр өндөр байна (Зураг 12).

Зураг 12. ДНБ-д салбарын эзлэх хувь (сая.төг)



(Эх сурвалж: ҮСХ, Сүхбаатар аймаг, СХ)

Сүхбаатар аймгийн ДНБ 2021 оны жилийн эцсээр салбарын эзлэх хувиар хөдөө аж ахуйн салбарт 47,2 хувь, үйлдвэрлэлийн салбарт 33.3 хувь, үйлчилгээний салбарт 19.5 хувь байна.

2.1.2. Жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдал

Сүхбаатар аймгийн жижиг, дунд үйлдвэрийн түүхэн цаг хугацаанд төр, бизнесийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд түүхэн шийдвэрүүдийг гаргаж байсан байдаг. Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хамтын ажиллагаатай Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, “Сүхбаатар хөгжил” ҮТП, ОНӨААТҮГ, Монголын Худалдаа аж үйлдвэрийн салбар танхим, Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны Сүхбаатар салбар хороо гэсэн төр, хувийн хэвшлийн голлох үүрэгтэй болоод бусад байгууллагууд ажиллаж байна.

2015 онд Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны Сүхбаатар салбар байгуулагдаж 13 сумын баялаг бүтээгчдээ цуглуулан тус оны 07 дугаар сард Анхдугаар хурлаа хийн түүнээс хойш үе шаттай ажлуудыг зохион байгуулснаар сумдын салбаруудыг байгуулж жижиг, дунд, бичил үйлдвэрлэгчдэд тулгарч буй асуудал, санаа, бодлыг нь сонсож, цаашид хийгдэх ажлуудаа нэгтгэж зохион байгуулснаар одоогоор 300 гаруй гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилготойгоор нэлээдгүй үйл ажиллагааг явуулсны үр дүнд Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр 2016 оныг

“Үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлаж үе шаттай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Түүхэн цаг хугацаанд үйлдвэрлэгчид нэгдэж гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага (ГҮТББ) статустайгаар эрх ашгаа хамгаалуулсан маш том нэгдэл, харилцаа, хамтын ажиллагаа бөгөөд аймаг, орон нутаг хөгжихөд хамтран ажиллахад дэмжлэг болсон дараагийн шийдвэр нь Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 36 дугаар тогтоолоор “Шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, дамжуулах, нутагшуулах замаар жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, улмаар үйлдвэрийг бий болгох, өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилготой “Сүхбаатар хөгжил” үйлдвэр технологийн парк, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулагдсан.

Сүхбаатар аймгийн жижиг, дунд үйлдвэрийн салбарын өнөөгийн байдлын талаар зарим тойм судалгааны байдлыг судлан үзье. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжийн тоо 2022 оны байдлаар ХХК 424, ЗБН 31, ББН 20, хоршоо 33, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1017 байна. Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, хиам, эсгий, блок, тоосго, замын хавтан, мухлаг, жигнүүр, том хүн, хүүхдийн дээл, ууж, сандал, хаалга, ширээ, хоолны шүүгээ зэрэг 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна (Хүснэгт 9).


Хүснэгт 9. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжийн тоо

Төрөл, ангилал	2012	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	114	348	370	386	390	409	424	396	383	424
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	34	30	30	30	26	22	24	23	20	20
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	29	35	35	29	33	30	34	33	34	31
Хоршоо	30	34	45	52	63	59	57	28	40	33
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	260	450	520	560	710	740	778	778	1046	1017
Нийт дүн	467	897	1000	1057	1222	1260	1317	1258	1523	1525

(Эх сурвалж: Сүхбаатар аймаг ХХААГ)

Судалгааны байдлаас харахад хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тоо нэмэгдсэн 41, нөхөрлөл, хоршооны тоо буурсан 3, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо буурсан 29 гэсэн үзүүлэлттэй байна (Зураг 13)


Зураг 13. Жижиг, дунд үйлдвэрийн ажлын байр



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

а) ААН-ийн ажиллагсдын тоо: ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь буюу 85% нь 1-9, 12% нь 10-49, 3% нь 50-89 хүртэлх тооны ажиллагсадтай байна.


Зураг 14. Үйл ажиллагаа явуулж буй хугацааны байдал



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

б. Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа: ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар нь авч үзвэл 8% нь 1 жил хүртэлх, 28% нь 1-5 жил, 33% нь 5-10 жил, 31% нь 10-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүд байна (Зураг 14).


Зураг 15. Жижиг, дунд үйлдвэрийн боловсруулах үйлдвэрийн байдал



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Судалгааны байдлаас харахад 2013-2022 онд хүнсний бүтээгдэхүүн, боловсруулах үйлдвэрлэлийн байдал өссөн үзүүлэлттэй байх бөгөөд бусад нэр төрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 16. Жижиг, дунд үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүний байдал




(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Судалгааны байдлаас харахад 2013-2022 онд хүнсний бүтээгдэхүүн болон бусад үйлдвэрлэл, түүний борлуулалтын байдал өссөн үзүүлэлттэй байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын санхүүжилт авсан байдал

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээлэл: Аймгийн хэмжээнд 2009-2022 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс ЖДҮХСанд 5,420 сая төгрөг хуваарилагдсан боловч хөрөнгө оруулалтаар нийт 174 төсөлд 4581,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хийгдсэн байна (Хүснэгт 17)


Зураг 17. ЖДҮ дэмжих зээлийн санхүүжилтийн байдал



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Судалгаанаас харахад 2009-2022 оны байдлаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд хуваарилагдсан санхүүжилтийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна. Харин энэ хугацаанд ЖДҮХСанд хуваарилагдсан төсөв байна.


Зураг 18. Ажлын байрны тоо



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Судалгаанаас харахад 2009-2022 оны байдлаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд хуваарилагдсан санхүүжилтээр шинэ болон хадгалагдсан ажлын байрны тоо эхний жилүүдэд өссөн үзүүлэлттэй харагдаж байгаа ч сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг нийт дүнгээр нь авч үзвэл шинээр бий болсон ажлын байр 435, хадгалагдсан ажлын байр 242,5-аас дээш ажилтантай шинээр бий болсон үйлдвэрийн тоо 26 байна.

Зураг 19. Санхүүжилт авсан байдал




(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Судалгаанаас харахад 2009-2022 оны байдлаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд ирүүлсэн төсөл, санхүүжилтийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. Энэ хугацаанд нийт ирүүлсэн төсөл арга хэмжээ 531 байгаагаас 174 төсөлд санхүүжилт олгогдсон байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн санхүүжилтийн байдал Дэлхий нийтийг хамарсан цар тахлын хөл хорионы улмаас 2021 онд тасалдсан байдаг бөгөөд бусад үед жил бүр харилцан адилгүй байдлаар олгогдсон байна (Зураг 19)

Хүснэгт 10. Санхүүжилт авсан салбарын байдал



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Салбарын хэмжээнд өнгөрсөн хугацаанд санхүүжигдсэн мөнгөн дүн төдийлөн их биш ч цаашид тогтмол нэмэгдүүлэх цаг үеийн шаардлага байна (Хүснэгт 10).

Хүснэгт 11. Сум хөгжүүлэх сангийн зээлийн санхүүжилт

Сумын нэр	Нийт зээл олголт / 2011-2021 оны хооронд /			
	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр
Асгат	57	339,744,000	53	22
Баяндэлгэр	117	637,400,000	98	65
Дарьганга	81	511,200,000	151	91
Мөнххаан	84	476,600,000	116	90
Наран	75	581,400,000	78	30
Онгон	65	570,600,000	44	25
Сүхбаатар	67	504,000,000	86	67
Түвшинширээ	72	500,000,000	94	60
Түмэнцогт	72	513,000,000	81	53
Уулбаян	72	533,000,000	85	74
Халзан	83	562,900,000	76	34
Эрдэнэцагаан	57	916,675,000	63	52
Баруун-Урт	288	3,418,068,000	362	119
Нийт	1,190	10,064,587,000	1,387	782

(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Судалгааны байдлаас харахад аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаа журмын дагуу явагдсан байдаг бөгөөд 2011-2021 онд нийт 1190 төсөл хэрэгжүүлэгчдэд 10 тэрбум төгрөгийн зээлийг давхардсан тоогоор олгож, төслийн хүрээнд 782 ажлын байр хадгалагдаж 1387 шинэ ажлын байр бий болсон байна (Хүснэгт 11).

Хүснэгт 12. 2022 онд хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлт

№	Сумын нэр	Зээл олгосон хүний тоо	Зээлийн хэмжээ	Шинэ ажлын байр
1	Асгат	1	60,000,000	3
2	Дарьганга	6	117,000,000	10
3	Халзан	6	110,000,000	4
4	Онгон	2	30,000,000	2
5	Сүхбаатар	2	112,000,000	2
6	Баруун-Урт	1	40,000,000	2
	Нийт	18	469,000,000	23

(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)


2022 онд зээл олголтын журам шинэчлэн боловсруулагдаж хоршоо хөгжүүлэх сан болон өөрчлөгдсөн. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын хөл хорионы дараах байдал, зээлийн журмын тавигдах шаардлагын хатуу заалтуудаас шалтгаалж төсөл ирүүлсэн аж ахуй нэгж, иргэдийн тоо эрс буурсан байна (Хүснэгт 12).

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарын дунд явуулсан судалгааны байдал

Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн төлөөлөл 100 гаруй иргэн, аж ахуй нэгжээс судалгаа авч боловсруулалт хийв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн дунд явуулсан судалгааны байдлыг дараах харуулав (Зураг 20)


Зураг 20. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн байдал



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Судалгаанд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн насны байдал харилцан адилгүй байдалтай байсан.


Зураг 21. Судалгаанд оролцогчдын салбар, үйл ажиллагааны чиглэл



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Судалгаанд хамрагдсан салбарын байдлаас харахад дийлэнх буюу 64.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгжүүд байна (Зураг 21).


Зураг 22. Үйлдвэрийн салбарт шинэчлэл шаардлагатай эсэх талаар



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Судалгаанд оролцогчдын 60,7 хувь нь шинэчлэл хийх шаардлагатай гэж үзсэн байна (Зураг 22).


Зураг 23. Үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай санхүүжилтийн судалгаа



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Судалгаанд оролцогч иргэн, аж ахуй нэгжүүдийн төлөөлөл жижиг, дунд үйлдвэрийн хөгжилд дэмжлэг, хөнгөлөлттэй зээл шаардлагатай байгаа нь эндээс харагдаж байна (Зураг 23).

Зураг 24. Экспортод бүтээгдэхүүнээ гаргахад тулгарч байгаа асуудлууд



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Жижиг, дунд үйлдвэрлэгч иргэн, аж ахуй нэгжид экспортод бүтээгдэхүүнээ гарагахад тулгарсан олон асуудал байгаа нь дээрх судалгааны үзүүлэлтүүдээс харагдаж байна (Зураг 24).

Судалгааны байдлыг дүгнэхэд Сүхбаатар аймгийн жижиг, дунд үйлдвэрлэгч нарын бизнесийн үйл ажиллагаанд шинэчлэл хийх, тулгамдаж буй асуудлуудад анхаарч үе шаттай арга хэмжээ авах, төсөл, хөтөлбөрт хамруулах, санхүүгийн шинэ эх үүсвэрүүдийг бий болгох цаг үеийн шаардлага байгаа нь судалгаанаас харагдана. Сүхбаатар аймгийн үйлдвэр хөгжлийн өнөөгийн байдал бусад бүс, орон нутгийн жишгийн дагуу байгаа ч нийгэм, эдийн засаг буюу газар зүйн байрлал, уул, уурхай, хөдөө аж ахуйн салбартаа түшиглэн жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэхэд хүн ам, ажиллах хүч, түүхий эдийн нөөцийн боломжид тулгуурлан хөгжүүлэх боломж судалгаанаас харагдаж байна.

2.2. Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоог үнэлсэн нь

Бид энэ бүлэгт Монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоог төрийн удирдлага-шинжлэх ухаан, боловсрол-үйлдвэрийн бүрэлдэхүүн хэсгийн элементүүд, салбарын орчны PESTLE, нөхцөл байдлын SWOT шинжилгээгээр шинжилж, үнэлэхийг зорьсон болно. Судалгааны 1 дүгээр бүлгийн 1.2 дэд бүлэгт тодорхойлсон жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг, элементүүд, түүний хоорондын уялдаа холбоо, дундын холбоост тулгуурлан үнэлгээг хийв.

Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцооны бүрэлдэхүүн элементийн үнэлгээ:

2.2.1. Төрийн удирдлагын байдлын үнэлгээ

Төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт

Монгол улсын төрийн удирдлагын тогтолцоо нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын институцээс бүрдэж байна. Хууль тогтоох байгууллага нь эрх хэмжээнийхээ хүрээнд хууль, тогтоомж батлан, гүйцэтгэх засаглал хуулийг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр хэрэгжиж байгаа ач холбогдолтой төрийн бодлогын баримт бичгийг байдлыг нэгтгэн харуулав (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Холбогдох төрийн бодлогын баримт бичиг

Бодлогын баримт бичиг	Холбогдох заалт
Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг (2020)	3.3.1. Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэгчдийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулж зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно.
	3.3.8.Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
	4.5.6.Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хөгжлийг дэмжих институтийн тогтолцоог бүрдүүлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	3.3.13.Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ.
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020)	58. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, бизнес инкубацын төсөл (141.9 сая)
Гурван тулгуурт хөгжлийн бодлого (2018)	3.4.2.7. зүүн бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх бодлогыг баримтлах;
Шинэ сэргэлтийн бодлого (2020)	3.3.13.Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ.
Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (2023-2037)	2.3.3.1. Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, үйлдвэрлэлийн нөөцийн судалгаа
Сүхбаатар аймгийн хөгжлийн зорилт 2020-2028 хөгжлийн бодлогын баримт бичиг (2019)	Хүний хөгжлийг дэмжих чиглэлээр: Зорилт 1.3 Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний бүх сүлжээнд эрүүл, аюулгүй байдлын стандартыг хэвшүүлж, хяналтын тогтолцоог сайжруулж, хүн амыг шим тэжээллэг, баталгаат хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах
	Нийгмийн тогтвортой хөгжлийн хангах чиглэлээр: Зорилт 3.6 Аймгийн брэнд бүхий соёлын биет бус өв, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх, ажлыг шинэ шатанд гаргах,

	Эдийн засгийн тогтвортой хөгжлийн чиглэлээр: Зорилт 5.4 Технологи, инновацад суурилсан өрсөлдөх чадвартай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн загвар аймаг болох
	Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг дэмжих чиглэлээр: 6.5.7 Бүс нутгийн үйлдвэрлэлд орон нутгийн оролцоог хангах замаар кластерын сүлжээнд нэгдэх, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх
Сүхбаатар аймагт 2021-2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, тэргүүлэх чиглэл (2021)	<ul style="list-style-type: none"> - Малын тэжээл тариалалт, үйлдвэр - Ноос, ноолуур угаах үйлдвэр - Арьс шир, дайвар бүтээгдэхүүн борлуулах - Төмс, хүнсний ногоо, ногоо тариалалт-Хүнсний ногоо хатаах даршлах үйлдвэр - Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр-Эрчимжсэн саалийн үнээний ферм - Барилгын материал үйлдвэрлэл - Орон нутгийн онцлог бүхий дурсгалын зүйлс - Аялал, жуулчлал
Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2020)	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр: 2.5.1 Хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр, эрхлэлтийг дэмжиж, шинэ ажлын байр бий болно.</p> <p>Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр: 3.3.15 Бизнес эрхлэгчдэд бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, бизнес инкубаторын үйлчилгээг нэвтрүүлнэ</p> <p>Тогтвортой, нэгдмэл гадаад харилцааг хангах чиглэлээр: БНХАУ-ын ӨМӨЗО-ны хил орчмын аймаг, хошуутай хамтран бизнес эрхлэгчдийн уулзалт, үзэсгэлэн худалдаа, зохион байгуулах</p>
Сүхбаатар аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	<p>3.3.13 “Сүхбаатар хөгжил” ҮТПарк ОНӨААТҮГ-ын бизнес инкубатор үйлчилгээг хөгжүүлэх</p> <p>3.3.11.1Мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах аж ахуй нэгжийн санаачилгыг төрийн бодлогоор дэмжин ажиллах</p> <p>3.3.18 Бизнес эрхлэгчдэд хүргэх, төсвөөс бусад санхүүгийн эх үүсвэр болох гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, техникийн зөвлөх үйлчилгээг нэмэгдүүлэх</p> <p>4.1.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бэлтгэн нийлүүлгийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулах зэрэг ажил, арга хэмжээг тусгасан байна.</p>

(Эх сурвалж:Горилөгчийн нэгтгэл)

Түүнчлэн, жижиг дунд үйлдвэрийн кластерыг хөгжүүлэх үндсэн нөхцөл нь эрх зүйн орчин байх бөгөөд тэдгээрийг дараах байдлаар тоймлон судлав. Төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтын хүрээнд баримт бичгүүд нэлээдгүй байгаа хэдий ч амьдрал дээр хэрэгжүүлэлтийн тал дээр онолын ойлголт, хүний нөөцийн чадавхи зэрэг асуудлууд байна.

Хууль тогтоох байгууллага нь эрх хэмжээнийхээ хүрээнд хууль, тогтоомж батлан, гүйцэтгэх засаглал хуулийг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр

хэрэгжиж байгаа ач холбогдолтой төрийн зарим хууль, тогтоомжийн байдлыг хураангуйлан харуулав (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Холбогдох хууль, тогтоомжийн байдал


Хууль, тогтоомж	Холбогдох заалт
Засгийн газрын тухай (1993)	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах арга замыг тодорхойлон уул ажлыг нэгтгэн удирдана.
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай (2005)	10.1.3.нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал, үзүүлж байгаа үйлчилгээг хамгийн ихээр ашигласан; энэ хуулийн 10.1.1-д заасан этгээд нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бол түүний ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 15 хувиар,
Хөрөнгө оруулалтын тухай (2013)	5.1.4.төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;
	11.1.1.албан татвараас чөлөөлөх;
	11.2.1.барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;
	11.2.1.барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;
	12.1.3.дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсэн горимоор олгох;
12.1.4.инновацын төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтэд батлан даалт гаргах;	
Татварын ерөнхий хууль (2019)	10.2.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулах бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай (2019)	9.2.5.үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны туршилттай холбоотой мэдээллийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;
	22.5.1.аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь тухайн орон нутагт бүртгэлтэй, орон нутгийн татварын албатай харьцдаг, ажлын байр бий болгож /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан/ байгаа энэ хуулийн 5.3.1-д заасан албан татвар төлөгчийн тухайн аймаг, сумын нутаг дэвсгэр дээр явуулсан үйл ажиллагаанаас олсон энэ хуулийн 7.4.1-д заасан албан татвар ногдох орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол

	алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар;
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай (2020)	5.2.14."төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн хуулийн этгээдийг зохистойгоор оролцуулахыг;
Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам	1.1 Худалдан авах ажиллагааны газар улсын болон бүс нутгийн чанартай худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчид болон аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгж (цаашид "Орон нутгийн нэгж" гэх)-ийн хооронд үүсэх харилцааг зохицуулах
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам (2020)	1.1 Экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацыг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх

(Эх сурвалж:Горилогчийн нэгтгэл)

Эдгээр хуулийн заалтууд, бодлогын баримт бичгүүд нь Монгол улсын "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай" хуулийн дагуу урт, дунд, богино хугацааны гэсэн төлөвлөлтэй байгаа бөгөөд дүн шинжилгээ хийж үзэхэд дийлэнх нь тунхаглалын шинжтэй байх бөгөөд цаашид хэрэгжүүлэх арга замыг нарийвчлан тодорхойлох хэрэгтэй байна. (Зураг 25)

Зураг 25. Хууль, тогтоомжийн хэрэгжилт, биелэлтийн байдал



(Эх сурвалж: Горилогчийн нэгтгэл)

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой бодлогын баримт бичиг, Аймгийн үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой 2019-2022 онд 36 зорилт, 2019-2022 онд 131 ажил арга хэмжээний биелэлт 2019-2022 онд 77.5 хувь, хууль

тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт 2019-2022 онд 82,1 хувьтай байна. Судалгааны тоон үзүүлэлтээс харахад орон нутагт бодлогын баримт бичгийн хэрэгжилт сайн байгааг илтгэж байна.

Монгол улсын хувьд Шинжлэх ухаан, технологийн тухай (2006), Инновацийн тухай (2015), Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай (2019), Хоршооны тухай (2021), Үйлдвэр, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай (2022) хуулиуд, Монгол Улсын “Алсын хараа-2050” эрх зүйн баримт бичиг (2020)-т заасан үйлдвэрлэлийг дэмжих, кластераар хөгжүүлэх бодлого, шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод “Монгол улсын экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн өсөлт, хөгжлийн стратегийг сонгож байна” гэж заасан байх бөгөөд улмаар “Хувийн хэвшилд түшиглэсэн, өндөр технологид суурилсан, экспортын баримжаатай боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийг олон талтай болгож, ашигт малтмалаас харьцангуй бага шалтгаалдаг орон болох” зорилго, зорилт (2008)-уудыг дэвшүүлсэн байдаг.


Бүс, орон нутгийн хэмжээнд Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай (2001), Сүхбаатар аймгийн хөгжлийн зорилт 2020-2028 бодлогын баримт бичиг (2019), Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэгт үйлдвэрийг *газар зүйн хувьд* төвлөрөх, бүсчлэх, хорших, төрөлжих, *хэлбэрийн хувьд* кластер, бизнес инкубатор, шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх, зээл тусламжаар дэмжин хөгжүүлнэ гэж тусгасан байна.

Хэдий тийм ч төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтын хүрээнд зарим бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт дундаж хэмжээнд байгаа хэдий ч үйлдвэрлэл хөгжлийн эрх зүйн орчин амьдрал дээр тусгалаа олж хэрэгжүүлэлтийн тал дээр биелэлээ олоогүй асуудлууд нэлээдгүй байна.

Төрийн дэмжлэг

Төрийн дараагийн нэг чухал үүрэг нь хөдөлмөрийн зах зээлийг нэмэгдүүлэх явдал юм (Зураг 26).

Зураг 26. Хөдөлмөрийн зах зээлийн байдал




(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХҮГ)

Төрийн чиг үүргийн дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас гаргасан мэдээллээр хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 412, бүртгэлтэй ажилгүй 363 иргэн, ажлын байрны 1234 захиалга бүтгэгдэж, ажилд зуучилсан 600 иргэн байна. Статистик тоон мэдээллээс харахад ажил хайгч хөдөлмөрийн насны иргэдийн нөөц хангалттай хэмжээнд байгаа нь харагдана.

Монгол улсын 2022 оны нийт төсвийн хуваарилалтад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт хэдэн хувийг эзэлж байгаа байдлаас төрийн төсвийн бодлогын хэрэгжилтийн байдлыг харж болно. Төсвийн тухай хуулийн дагуу Монгол улсын мөнгөн орлого бүрдэж эрх хэмжээнийхээ хүрээнд Улсын Их Хурал хэлэлцэн баталж байна (Зураг 27)

Зураг 27. МУ-ын 2022 оны нэгдсэн төсөв



(Эх сурвалж: <https://www.1212.mn>)


Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 16,415.1 тэрбум төг, төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн дүн 18,158.7 тэрбум төгрөг, төсвийн алдагдал 2,387.1 тэрбум төгрөг (ДНБ-ийн 5.1%) байхаар баталсан. Тэгвэл улсын төсөвт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор зарцуулалтыг 30,500.0

тэрбум буюу төсвийн 5.8 хувийг эзэлж байна. Энэ нь улсын хувьд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын бодлого маш бага хэмжээнд байгаа нь харагдана.

Судалгааны ажлын дараагийн элемент нь төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тусламж, хөнгөлөлтийн байдал улсын төсөвт батлагдсан хэмжээнд байгаа хэдий ч цаашид дотоод, гадаад, бусад эх үүсвэрээр хөгжүүлэх цаг үеийн шаардлага байна. Сүхбаатар аймгийн хэмжээнд тусламж, хөнгөлөлтийн байдлын үр дүнг тооцож, нэгтгэж байгаа байгууллага, нэгдсэн мэдээлэл одоогоор байхгүй байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл, тусламжийн хүрээнд ХХААХҮЯамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дэргэдэх сангийн эх үүсвэрээр улс төсөвт тусгагдсан хуваарилалтыг хийж байна. Зээл олголтын байдал жил бүр харилцан адилгүй байсан бөгөөд 2023 онд Сүхбаатар аймагт 1 тэрбум төгрөгийн хуваарилалт хийгдсэн байна. Одоогоор журмын дагуу төсөл хүлээн авах, баримт бичиг бүрдүүлэлтийн ажлууд явагдаж байна. Орон нутгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр аймгийн ИТХ-аар 300 сая төгрөг батлагдаж Сангийн яамны зөвшөөрлийг хүлээсэн байдалтай байгаа бөгөөд бусад эх үүсвэрүүд одоогоор байхгүй байна. Үйлдвэрлэлийг дэмжих дараагийн эх үүсвэр нь төрийн худалдан авалт юм. Сүхбаатар аймгийн төрийн захиалга, худалдан авалтаар 2018-2022 онд нийт 332 ажил, арга хэмжээ хэрэгжүүлсэн байх бөгөөд үйлчилгээний төрөл, худалдан авах ажиллагааны мөрдсөн журмын байдлыг Зураг 28-д харуулав.

Зураг 28. Сүхбаатар аймгийн орон нутгийн худалдан авалт



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, Орон нутгийн өмчийн газар)

Судалгаанаас харахад хэрэгжүүлсэн ажил, санхүүгийн хэмжээ он жилүүдэд харилцан адилгүй байх бөгөөд хуулийн дагуу 92.1 тэрбум төгрөгийн ажил

төлөвлөгдсөнөөс 82.1 тэрбумын ажил хийгдэж, он дамнасан зарим ажлууд ч байна. Худалдан авах үндсэн үйл ажиллагаанаас гадна Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тендерийн шалгаруулалтаар орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэгч нарт давуу байдал бий болгосон худалдан авалт одоогоор хийгдээгүй байна.

Төрийн дэд бүтцийн дэмжлэгийн байдал, Аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газраас гаргасан мэдээгээр 2022 онд 7.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хүний хөгжил, эдийн засаг, засаглал, байгаль, ногоон орчны хөгжил, бүс орон нутгийн хөгжил гэсэн чиглэлээр дэд бүтцийн 63 ажил төлөвлөснөөс биелэгдээгүй 9, бусад ажил жигнэсэн нийт дунджаар 62.6 хувийн биелэлттэй байна. Сүхбаатар аймагт мэдээлэл, технологийн сүлжээ, идэвхжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нь мэдээлэл, холбоо сүлжээний газар бөгөөд төв байгууллагынхаа гаргасан техник, технологийн нөхцөлийн дагуу засвар, үйлчилгээ дамжуулалтын үүргийг гүйцэтгэдэг бөгөөд 2013 оноос 1 гага, 2022 оноос 10 гага хурдтай интернэтийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, цаашид нэмэгдүүлэх завсар, өргөтгөлийн ажлууд хийгдэж байна.

Төрийн байгууллагын тогтолцоо, бүтэц

Сүхбаатар аймагт төрийн захиргааны байгууллага, орон нутгийн удирдлагын байгууллагуудаас төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр үйл ажиллагаа явуулж байгаа 49 байгууллага, орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр 39 аж ахуй нэгж ажиллаж байна.

Судалгааны байдлаас харахад төрийн байгууллагын үйл ажиллагааг хэмжсэн элементүүдээр хэрэгжилтийн байдал харилцан адилгүй байх тул үнэлгээ хийж үзье (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Төрийн удирдлагын байгууллагын үнэлгээг нэгтгэсэн байдал

Элемент	Хэмжүүр	Хэрэгжилт (0 оноо 1 бага 2 дундаж 3 их)			
		0	1	2	3
Төрийн бодлого	Урт хугацааны бодлого	+			
	Дунд хугацааны бодлого		+		
	Богино хугацааны бодлого				+
Эрх зүйн зохицуулалт	Хууль тогтоомж			+	
	Дүрэм, журам			+	
Төрийн дэмжлэг	Хөдөлмөр эрхлэлт			+	
	Зуучлал		+		

	Санхүү			+	
	Захиалга, худалдан авалт		+		
	Дэд бүтэц			+	
Төрийн байгууллагын тогтолцоо, бүтэц	Төрийн захиргааны байгууллага			+	
	Орон нутгийн удирдлага			+	
Нийт дүн		1	3	7	1
ЖДҮ		2			

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Үнэлгээнээс харахад төрийн байгууллагын үйл ажиллагааны байдал жигнэсэн дундаж үнэлгээгээр 2 байгаа нь дундаж хэмжээнд байгаа хэдий ч үйл ажиллагааны ажил үүргийн хэрэгжүүлэлтийг сайжруулах шаардлага байна.

2.2.2. Академик (ШУ, боловсрол) байдлыг үнэлсэн нь

Хууль эрх зүйн орчин

Монгол улсын хэмжээнд шинжлэх ухаан, боловсролын салбарыг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж, мөрдөж байгаа ач холбогдол бүхий зарим хууль, тогтоомжийн байдлыг хураангуйлан харуулав (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Салбарын хууль, тогтоомжийн байдал

Он сар	Хууль, тогтоомж	Холбогдох заалт
1993	Засгийн газрын тухай	6.8 Улсын хэмжээнд баримтлах шинжлэх ухаан-техник, технологийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
1998	Технологи дамжуулах тухай (1998)	5.1.1.технологи дамжуулах талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
2006	Шинжлэх ухаан, технологийн тухай (2006)	6.1.1.шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
2009	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай (2006)	6 ¹ .1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо нь зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үнэлгээ, мэдээллийн болон бүсийн арга зүйн төв, сургалтын байгууллагаас бүрдэнэ.
2012	Инновацын тухай (2012)	11.1.1. Орон нутагтаа инновацыг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах, хамтарсан санхүүжилттэй инновацын төсөл хэрэгжүүлэх;
2022	Дээд боловсролын тухай (2022)	12.1.1.дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх төрийн бодлого, дээд боловсролын хөгжлийн дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд нийцүүлэн сургуулиа хөгжүүлэх чиглэл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
2017	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого	4.2.7.шинжлэх ухаан, технологийг инновац, бүсчилсэн хөгжил, аж үйлдвэрийн бодлоготой нягт уялдуулан хөгжүүлэх.

(Эх сурвалж: Горилогчийн нэгтгэл)

Хуулийн холбогдох заалтуудын байдалд дүн шинжилгээ хийхэд тунхаглалын шинж чанартай нь дийлэнх байх бөгөөд зүйл, заалтын ач холбогдол, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Шинжлэх ухааны байгууллага

Судалгаагаар Сүхбаатар аймагт шинжлэх ухаан, судалгааны байгууллага одоогоор байхгүй байна.


Дээд боловсролын сургалтын байгууллага

Судалгаагаар мэргэжилтэн боловсон хүчнийг бэлтгэдэг их, дээд сургууль байхгүй байгаа нь жижиг, дунд үйлдвэрийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг судалгааны тулгуур асуудал болоод байна.

Мэргэжлийн болон технологийн боловсрол, сургалтын байгууллага

Боловсролын салбарын мэргэжлийн болон технологийн боловсрол олгодог сургалтын байгууллагаас төрийн өмчит Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол улсын боловсролын тогтолцооны нэг хэсэг, нийгмийн ажиллах хүчин, мэргэжилтэн бэлтгэх суурь бүрэлдэхүүн нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэгдэн гарч байна. Боловсролын салбарын мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага нь иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан шаардагдах мэргэжлийн ур чадвар, чадамж, мэргэжил эзэмшүүлэх, гарааны компани, салбар дундын дадлагын бааз, бизнес инкубатор төвийн үйл ажиллагаагаар иргэнийг хөгжүүлэх зорилготой ажиллаж байгаа бөгөөд Мэргэжлийн боловсрол олгох чиг баримжаатай тус байгууллага нь нийгэм цаг үеийн эрэлт хэрэгцээгээр бий болж төрийн бодлогоор дэмжигдэж ажиллаж байгаа юм. Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн статистик нэмэлт мэдээллийг хавсралтын хүснэгт....-ээс харна уу. Мэргэжлийн сургалтын үйлдвэрлэлийн төв нь мэргэжлийн боловсролын сургалт олгохоор ажиллаж байгаа бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд 14 мэргэжлээр нийт 447 суралцагч суралцаж, суралцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 49 буюу 9,9 хувиар буурсан байна (Зураг 29).

Зураг 29. Сүүлийн 5 жилээр суралцагчдын тоо (хүйсээр)



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, МСҮТ)

Нийт суралцагчдын 151 буюу 33.7 хувь эмэгтэй суралцагч байна (Зураг 30).

Зураг 30. 2022-2023 онд суралцагчдын тоо (мэргэжлээр)



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, МСҮТ)

Суралцагчид 6 салбарын 14 мэргэжлээр суралцаж байгаа бөгөөд олон суралцагч суралцаж буй мэргэжлийн байдлыг харвал: Нийт суралцагчдын 16.7 хувь нь барилгын засал чимэглэлч, 11.6 хувь нь автомашины засварчин, 8.5 хувь нь барилгын өрөг угсрагч мэргэжлээр тус тус суралцаж байна (Хүснэгт 17).


Хүснэгт 17. Сүүлийн 5 жилээр суралцагчдын мэргэжлийн байдал



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, МСҮТ)

Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл тогооч, автомашины засварчин, гагнуурчин, модон эдлэлийн мужаан, барилгын өрөг угсрагч, барилгын засал чимэглэлч, гоо засалч, барилгын сантехникч, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, бетон армотурчин, барилгын цахилгаанчин гэсэн 10 мэргэжлээр байнга элсэлт авсан бөгөөд улс, аймаг орон нутгийн хөгжлийн хэтийн бодлоготой уялдуулан төмөр замын замчин, ойжуулагч гэсэн мэргэжлээр ажиллах хүчин бэлтгэж байна. (Зураг 31)


Зураг 31. Сүүлийн 5 жилийн байдлаар төгсөгчдийн тоо



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, МСҮТ)

Сүүлийн 5 жилийн хугацаанд 922 суралцагчдыг 20 гаруй мэргэжлээр мэргэжил эзэмшүүлэн төгсгөсөн бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд 2.5 жилд 104 суралцагч төгссөн байна (Зураг 32).

Зураг 32. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт




(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, МСҮТ)

Судалгааны тоон үзүүлэлтээс харахад төгсөгчдийн хөдөлмөрт эрхлэлтийн байдал өссөн дүнтэй байна.

Хүний нөөцийн мэдээлэл

2022-2023 оны хичээлийн жилд нийт 51 багш, ажилчидтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ хичээлийн жилд үндсэн нийт 21 багш ажиллаж байгаагийн 14 буюу 66.6 хувь нь мэргэжлийн багш, 7 буюу 33.4 хувь нь ерөнхий эрдмийн багш байна (Зураг 33).

Зураг 33. Сүүлийн 5 жилээр багшийн тоо



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, МСҮТ)

Багшлах боловсон хүчний 42.8 хувь нь бакалавр, 47.6 хувь нь магистр зэрэгтэй багш нар байгаа бөгөөд нийт үндсэн багш нарын 13 буюу 61.9 хувь нь мэргэжлийн зэрэгтэй байгаагийн дотор 11 буюу 52.3 хувь нь заах аргач, 2 буюу 9.5 хувь нь тэргүүлэх, 1 буюу 4.7 хувь нь зөвлөх зэрэгтэй багш байна.

Тус байгууллагад салбар дундын дадлагын бааз гэхээс илүүтэй сургалтын дадлагын бааз дутмаг байгаа бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр улс төсөвт зураг, төсвийн мөнгө нь батлагдсан байна. Тухай байгууллагад гарааны компани, бизнес инкубатор төвийн үйл ажиллагаа одоогоор явагдаагүй байна.

Судалгааны статистик тоон мэдээ, эмпирик судалгааны байдлаас дүгнэхэд 2022-2023 оны хичээлийн жилд суралцагчид 49 буюу 9,9 хувиар буурсан, мэргэжлийн сургалтын дадлагын тоног, төхөөрөмж хүрэлцэхгүй, шинэчлэл хийх шаардлагатай, мэргэжлийн багшлах боловсон хүчин барилга, сантехникийн багш дутагдалтай зураг асуудлууд тулгарсан байна. Тухайн салбарт тулгарч байгаа асуудалтай холбогдуулж бэлтгэгдсэн мэргэжилтэй боловсон хүчний нөөцийг улс орны хөгжлийн бүтээлч үйлдвэрлэлтэй хослуулах бодлогын арга хэмжээнд чиглүүлэх нь нэн тэргүүний асуудал болсон байна. Улс орны хөгжилд үнэтэй хүний капитал, мэргэжилтэн бэлтгэх асуудалд шинжлэх ухаан, их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага гэсэн тогтолцоонд тулгуурлан орчин цагт боловсрол, судалгааны байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд оюун санааны бүтээлч мэдлэг, шинэ технологийн нээлт, инновац бий болгох буюу онолын мэдлэгийг хэрэглээнд нэвтрүүлэхэд цаашид анхаарч хөгжлийн бодлогыг тодорхойлох хэрэгтэй юм.

Судалгааны байдлаас харахад шинжлэх ухаан/боловсролын байгууллагын үйл ажиллагааг хэмжсэн элементүүдээр хэрэгжилтийн байдал харилцан адилгүй байх тул үнэлгээ хийж үзье (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Шинжлэх ухаан/боловсролын байгууллагын үнэлгээг нэгтгэсэн байдал

Бүрэлдэхүүн хэсэг	Хэмжүүр	Хэрэгжилт (0 оноо 1 бага 2 дундаж 3 их)			
		0	1	2	3
Эрдэм шинжилгээ, судалгаа	Хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах	+			
	Эрдэм шинжилгээний ажил	+			
	Эрдэм шинжилгээний туршилт	+			
	Зохион бүтээх	+			
	ШУ-ны салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх	+			
	ОУ байгууллагатай хамтын ажиллагаа		+		
	Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар			+	
Технологи дамжуулалт	Технологийн горим, үйл ажиллагааны нөхцөл		+		
	Технологийн шат дамжлагын дэс дараалал, горим, бүрдэл хэмийн талаарх зөвлөгөө, үйлчилгээ		+		
	Технологи нэвтрүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж		+		
	Шинжлэх ухаан технологийн судалгаа, шинжилгээний үр дүн	+			
	Патент, лиценз, бүтээгдэхүүний загвар		+		
	Ноу-хау		+		
Дээд боловсролын сургалтын байгууллага	Сургалт: Мэргэжилтэн бэлтгэх	+			
	Эрдэм шинжилгээ, судалгаа	+			
	Технологийн судалгаа	+			
	Сургалт-судалгааны бизнес-инкубатор		+		
	Технологи дамжуулах төв		+		
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага	Иргэнд хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, чадамж, мэргэжил			+	
	Гарааны компани		+		
	Салбар дундын дадлагын бааз		+		
	Бизнес инкубатор төв		+		
Нийт дүн		9	11	2	
ЖДҮ		1			

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Үнэлгээнээс харахад шинжлэх ухаан/боловсролын байгууллагын үйл ажиллагааны байдал жигнэсэн дундаж үнэлгээгээр 1 байгаа нь дунджаас бага байна.

2.2.3. Жижиг, дунд үйлдвэр (бизнес)-ийн байдлыг үнэлсэн нь

Хууль, эрх зүйн орчин

Монгол улсын хэмжээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, аж ахуй нэгж, байгууллагын эрх ашгийг хамгаалах, дэмжих, хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж,

мөрдөж байгаа ач холбогдол бүхий зарим хууль, тогтоомжийн байдлыг хураангуйлан харуулав (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Салбарын хууль, тогтоомжийн байдал

Он	Хууль, тогтоомж	Холбогдох заалт
2010	Өрсөлдөөний тухай	6.1.1.зах зээлд нийлүүлж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтийн талаар хүчин чадалтай нь уялдуулан хянан зохицуулах;
2011	Компанийн тухай	3.4.Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.
2019	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай	18.1.1.тухайн шатны жил бүрийн төсөвт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх зориулалтаар хөрөнгө тусгаж батлах
2022	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай	4.1.1."үйлдвэрлэл, технологийн парк" /цаашид "парк" гэх/ гэж үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх тусгайлсан нутаг дэвсгэр, бизнесийн таатай орчин, дэд бүтцийн хангамж бүхий, тодорхой салбарт үйл ажиллагаагаар харилцан уялдсан үйлдвэрлэл, технологийн цогцолборыг;
2019	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр	4.4.8. их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын оролцоо бүхий кластерыг хөгжүүлэх.

(Эх сурвалж: Горилогчийн нэгтгэл)

Эдгээр хуулийн холбогдох заалтуудын байдлыг дүгнэхэд зарим заалтууд тунхаглалын шинж чанартай байх бөгөөд зүйл, заалтын ач холбогдол, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Өрсөлдөөн, инновацын өнөөгийн байдал

Салбарын хэмжээнд ижил, чиглэлийн үйл ажиллагаатай байгууллагуудын чадавх, хүн ба бүтээлч капитал, техник, технологийн хөгжлийн байдлаас шалтгаалж өрсөлдөөн, инновац бий болох нөхцөл байдал одоогоор бий болоогүй байна.

Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) эрхлэгч, аж ахуй нэгжийн байдал

Бизнесийн салбар нь улс орнуудын эдийн засагт тэр дундаа хөгжиж буй орнуудын нийгэм, эдийн засгийн байдлыг сэргээхэд онцгой үүргийг гүйцэтгэдэг юм.

Бизнесийн байгууллага буюу хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүд нь чөлөөт зах зээлийн зарчмаар ажиллахын тулд хөгжлийн стратеги төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, удирдлага, менежментийн үе шаттай арга хэмжээнүүдийг авч ажлын бүтээмж, ашиг орлогоо нэмэгдүүлэх маркетинг хийх үйл явцад онцгойлон анхаарч байна. Бизнесийн ашиг орлого олох, хөрөнгө оруулалт татах, ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх үйл явц нь одоо цаг үед байгууллагын хөгжлийн амин сүнс нь юм. Аж ахуй нэгжүүд удирдлагын болон үйл ажиллагааны менежментийг чадавхжуулах арга хэмжээг авсны дараах гол тулгуур асуудал нь дотоод, гадаад

санхүүгийн хөрөнгө оруулалт татах, сургалт, судалгаа хөгжлийн байгууллагуудаар өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх явдал юм. Бизнесийн өрсөлдөөнт байдлын чухал элемент нь хүн ба капитал мөн боловч шинэ мэдлэг бий болгох, техник, технологийн шинэчлэлийн байдал харьцангуй сул байна. Монголын үйлдвэрлэлийн салбарын аж ахуй нэгжүүдийн удирдлага, менежментийн бие даасан байдал, гүйцэтгэл, чадамжийн хувьд дэлхий нийтийг жишигтэй харьцуулахад харьцангуй сул түвшинд байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрийн салбарт бенчмаркетинг хийх, хамтын ажиллагааг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, олон нийтийг сүлжээг бүрэн ашиглах цаг үеийн шаардлага байсаар байгаа юм. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд бид өнөөгийн байгаа нөхцөл байдлаа үнэлж, нөөц боломжуудыг судалж хэрэгцээгээ тодорхойлох шаардлагатай (Зураг 34)

Зураг 34. Сүхбаатар аймгийн ЖДҮ



(Эх сурвалж: Сүхбаатар аймаг, ХХААГ)

Судалгааны хязгаарлалтын хүрээнд Сүхбаатар аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн байдлыг судлан харуулахад тоон мэдээллээс жижиг, дунд үйлдвэрлэгчдийн тоо өссөн үзүүлэлтэй, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ихтэй байгаа нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны Сүхбаатар салбарын явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой байна.

Нөхөрлөл, хоршооны тоон үзүүлэлт буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд Сүхбаатар аймагт өнгөрсөн он жилүүдэд жижиг, дунд үйлдвэрлэгч, өрхийн үйлдвэр эрхлэгчдийн байдлыг тоон аргаар харахад нөөц боломж байгаа хэдий ч чанарын

үнэлгээгээр эдийн засгийн болоод хүний нөөцийн чадамжаар хязгаарлагдмал хүрээнд байгаа нь судалгааны ажлын 2.1 бүлгийн мэдээллээс тодорхой харагдана.

Санхүү хөрөнгө, оруулалтын байдал

Сүхбаатар аймгийн хэмжээнд санхүү, хөрөнгө оруулалтын байдлын хувьд санхүүгийн салбарт 4 банк, 5 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Хүнс хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны жижиг дунд үйлдвэрийн газрын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2009-2022 оны хугацаанд 174 төсөлд 4,5 тэрбум төгрөгийг 5 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй зээл олгосон байна. Орон нутгийн төсөвт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилготой 300 сая төгрөгийн эх үүсвэрийг 2023 онд анх удаа батлагдсан байна. Улсын төсвийн хуваарилалтаас гадна бусад эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах арга замыг эрэлхийлэх цаг үеийн шаардлага байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд санхүүгийн өөр нэг эх үүсвэр нь хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Залуучуудын хөгжлийг дэмжих зорилготой гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт 2019 онд 15, 2020 онд 6, 2021 онд 1, 2022 онд 1 төсөл шалгаруулж нийт 230 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Энэхүү зээлийн нөхцөл 3 жилийн хугацаатай барьцаа хөрөнгө шаардахгүй, хүү төлөхгүй байдал давуу талтай юм. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд зээл олголт, мөнгөн дүн буурсан үзүүлэлттэй байна.

Хамтын ажиллагааны байдал

Жижиг, дунд үйлдвэрийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд Төр, хувийн хэвшлийн байгууллага, Худалдаа аж үйлдвэрийн салбар танхим, Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны Сүхбаатар салбар болоод бусад иргэд, ТББ-уудтай үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнүүдэд байнгын хамтын ажиллагаатай байдаг бөгөөд олон нийтийг хамарсан социал медиа байгууллагууд ч мөн уялдаа холбоотой ажиллаж байна. Үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтцийн чиглэлээр аймаг орон нутгаас УИХ-ын гишүүд, үйлдвэрлэл технологийн паркийн удирдлагын хүчин чармайлтын үр дүнд 2023 оны төсөвт үйлдвэрлэлийн 1 дүгээр бүсийн дэд бүтцийн ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.9 тэрбум төгрөгийн ажил хийгдэж байгаа бөгөөд цаашид 2024 онд 1 тэрбум төгрөгийн ажил хийгдэхээр он дамнасан ажилд тусгагдсан байна.

Улс орны хэмжээнд жижиг, дунд үйлдвэр хөгжөөгүй өнөөгийн байдал нь төр засгийн цаг хугацааны түүхэн шийдвэрүүдээс шалтгаалж сүүлийн 30 жилд энэхүү байдалд хүрсэн байна. Тиймээс цаашид төр, шинжлэх ухаан (боловсрол), жижиг, бизнесийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Судалгааны байдлаас харахад жижиг, дунд үйлдвэрийн байгууллагын үйл ажиллагааг хэмжсэн элементүүдээр хэрэгжилтийн байдал харилцан адилгүй байх тул үнэлгээ хийж үзье (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Бизнес, үйлдвэрийн үнэлгээг нэгтгэсэн байдал

Бүрэлдэхүүн хэсэг	Хэмжүүр	Хэрэгжилт (0 оноо 1 бага 2 дундаж 3 их)			
		0	1	2	3
Өрсөлдөөн, инновац	Хүн, бүтээлч капитал		+		
	Сургалт		+		
	Судалгаа хөгжүүлэлт	+			
	Техник, технологи		+		
ЖДҮ, Аж ахуй нэгж байгууллага	Компани		+		
	Санхүү, хөрөнгө оруулалт		+		
	Хамтын ажиллагаа		+		
Нийт дүн		1	6		
ЖДҮ		1			

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Үнэлгээнээс харахад жижиг, дунд үйлдвэрийн байгууллагын үйл ажиллагааны байдал жигнэсэн дундаж үнэлгээгээр 1 байгаа нь дунджаас бага байна.

2.2.4 Институци хоорондын хамтын ажиллагаа

Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсэг, хэсгүүдийн хоорондын харилцаа, шинж чанар, бусад хүчин зүйлийг хангах чухал элемент нь уялдаа холбоо, хамтын ажиллагаа юм. Тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бүрийн институци бүрд холбоо харилцаа, хамтын ажиллагаанаас шинэ мэдлэг /инновац/, технологи, бүтээмж, гурвалсан холбоо, дундын холбоос хөрөнгө оруулалтын капиталыг бий болгоно. Тиймээс кластер тогтолцооны институци хооронд болон оролцогчид, бусад хүчин зүйлийн хооронд хэвтээ болон босоо холбоосыг хангах гүйцэтгэл нь хамтын ажиллагааны сүлжээ болно.

Төр-ШУ, боловсролын байгууллагын хамтын ажиллагаа

Монгол улсын төр хөгжлийн бодлогын алс хараагаа тодорхойлохдоо хууль эрх зүйн баримт бичгүүд, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулахдаа болон

хэрэгжүүлэхдээ шинжлэх ухаанд тулгуурлах нь төр-шинжлэх ухааны байгууллагуудын бодлого, уялдаа холбоо, хамтын ажиллагаанд хамгаас чухал юм. Институциудын хамтын ажиллагаагаар ШУ, дээд боловсролын байгууллагын талаарх төрийн бодлогыг тодорхойлох, захиалагч хэрэгжүүлэгчийн хүрээнд хамтарсан судалгааг эхлүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, босгоход хүчин чармайлт гаргах, инкубатор төвийг байгуулах зэрэг ажлууд нь институтын дундын холбоос бий болох үр дүн юм. Сүхбаатар аймагт энэхүү дундын холбоост ШУ, боловсролын байгууллага байхгүй байгаа байдлаас судалгаа хөгжүүлэлтийн ажил явагдах сул боломжтой байна. Хөрөнгө оруулалтын чиглэлээр Төрийн байгууллага санаачилга гаргаж хөрөнгө оруулалтын чуулган гэх мэт ажлуудыг зохион байгуулж байгаа нь үр дүнгээ өгч байна.

ШУ, боловсрол- үйлдвэрийн хамтын ажиллагаа

Жижиг, дунд үйлдвэрийн байгууллагын хөгжилд нэлээдгүй хувь нэмэр оруулдаг байгууллага нь шинжлэх ухаан боловсролын салбар бөгөөд хамтын ажиллагааны үр дүнд мэдлэг хуваалцах, дадлагажуулах хөтөлбөр, бизнесийг хөгжүүлж, бойжуулах, байгууллагуудтай хамтран шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлдэг. Институциуд нь салшгүй хамтын ажиллагааны хүрээнд мэдлэг хуваалцах үйл арга ажиллагаанд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжийн хүний нөөцийг дадлагжуулах үйл явцыг төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлдэг бөгөөд үр дүнд нь инноваци үүсдэг. Гэтэл Сүхбаатар аймагт ШУ, боловсролын нэгж байхгүйн улмаас энэ үйл явц хэрэгжих боломжоор дулимаг байна.

Бизнесийн байгууллагууд мэндлэх, үйл ажиллагааны эхлэлийн үе шатанд институцын хамтын ажиллагааны хүрээнд бизнес инкубатор төвөөр бойжуулах, шинэ мэдлэг, технологи нэвтрүүлэх үйл явцад боловсролын байгууллага байхгүйн улмаас дундын холбоос дутмаг ажиллана.

Үйлдвэр-Төрийн байгууллагын хамтын ажиллагаа

Бизнесийн байгууллагын хөгжилд төр, үйлдвэрийн байгууллагын хамтын ажиллагаа чухал бөгөөд дэмжлэгийн бодлого хэрэгждэг. Сүхбаатар аймагт тухайн 2 институцын байгууллага, нэгжүүд байгаа тул хөдөлмөрийн зах зээлийг бий болгох боломжтой. Өнөөгийн нөхцөлд төр нь үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих талаар бусад байгууллагуудтай хамтран сургалт, зөвлөгөөн, төсвийн дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч жижиг, дунд үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн удирдлагын менежмент,

хүний нөөцийн чадавх шаардлагын хэмжээнд байж чадахгүй байна. Тиймээс сургалт, хөгжүүлэлт, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул бүсчлэн хөгжүүлэх төлөвлөлтийн хүрээнд 2023 оны улсын төсвийн 1.9 тэрбумын хөрөнгө оруулалтаар 1 дүгээр бүсийн дэд бүтцийн ажил, орон нутгийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай 2 дугаар бүсийн дэд бүтцийн зураг, төсвийн ажлууд хийгдэж байна. Мөн орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх зорилготой “Сүхбаатар хөгжил” үйлдвэр технологийн парк 2017 онд байгуулагдаж аймгийн хөгжлийн төлөвлөлтөд хувь нэмрээ оруулж үйл ажиллагаагаа нь тогтвортой байна.

Хамтрагч, дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагаа, сайн түншийн харилцаагаар салбаруудын хөгжлийн тулгуур элементүүд, салбарын уялдаа холбоо, чухал үүргийг гүйцэтгэдэг.

Судалгааны ажлын 1 дүгээр бүлэгт өгүүлснээр институциудын хоорондын уялдаа холбооноос гадна гадаад орны зах зээлтэй холбох, туршлага судлах, харьцуулан хөгжүүлэх хамгийн чухал алхам юм. Засгийн газар, Их дээд сургууль, үйлдвэр /компани/-ийн байгууллагууд хууль эрх зүй, төсөв, санхүү, технологийн шинэчлэл, хүний нөөц талаасаа илүү хүчтэй зохицуулалт, ажил явуулж далайцтай арга хэмжээ авах шаардлага байгаа нь судалгааны ажлын 1.3 дугаар бүлэгтэй харьцуулсан байдлаар харагдаж байна.

Судалгаанд үнэлсэн жижиг, дунд үйлдвэрийн тогтолцоо, түүний загварын институциудын байдал, бүрэлдэхүүн хэсэг, элементүүдийн хоорондын уялдаа холбоо, бизнесийн гадаад, дотоод орчны байдлыг PESTLE, SWOT шинжилгээний аргаар үнэлэн тодорхойлов.

Монгол улс, бүс нутгийн жижиг, дунд үйлдвэрийн кластерыг салбарын PESTLE шинжилгээний аргаар үнэлж авч үзвэл:

2.2.5. Салбарын PESTLE шинжилгээ

Жижиг, дунд үйлдвэрийн салбарын гадаад орчны өнөөгийн төлөвийг үнэлэхэд PESTLE шинжилгээний аргыг ашиглан олон улсын хүчин зүйлсээр өргөтгөж (G) 7 үндсэн хүчин зүйл, түүнд харгалзах 39 дэд үзүүлэлт тэдгээрийн илрэл, хамаарлыг нөлөөллийн хугацаа, орчны төлөвийг судалсан. Салбарын орчны төлөвийг жигнэгдсэн дунджийн аргаар тооцоолов (Хүснэгт 21).

Хүснэгт 21. Салбарын гадаад орчны PESTLE+G шинжилгээ


№	Дэд үзүүлэлт	Хувийн жин	Орчны төлөв					ЖД оноо	
			1	2	3	4	5		
Төрийн бодлого	1.1	“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	0.035		2				0.07
	1.2	Шинэ сэргэлтийн бодлого	0.025		2				0.05
	1.3	Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	0.025		2				0.05
	1.4	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр	0.02	1					0.02
	1.5	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого	0.025			3			0.075
	1.6	Гурван тулгуурт хөгжлийн бодлого	0.03			3			0.09
	1.7	Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	0.01	1					0.01
	1.8	Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллагын баримталж буй бодлого	0.04			3			0.12
	1.9	Одоогийн улс төрийн нөхцөл байдал, үйл явц	0.03			3			0.09
	1.1	Кластерыг дэмжих бодит байдал	0.02	1					0.02
1.1	Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028 хөгжлийн бодлогын баримт бичиг	0.02		2				0.04	
1.1	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	0.04			3			0.12	
Эдийн засаг	2.1	ЭЗ (ДНБ)-ийн өсөлтийн хандлага	0.04	1					0.04
	2.2	ХҮИ-ийн хандлага	0.035		2				0.07
	2.4	Улсын төсөв	0.035			3			0.105
	2.5	Хүү	0.04			3			0.12
	2.6	Хөрөнгө оруулалт	0.04	1					0.04
	2.7	Ажиллах хүч	0.035			3			0.105
	2.8	Цалин	0.04			3			0.12
	3.1	Боловсрол	0.03		2				0.06
Нийгэм	3.2	Хүн ам	0.03			3			0.09
	3.3	Нийгмийн хандлага ба гарч байгаа өөрчлөлт	0.03		2				0.06
	4.1	Шинжлэх ухаан	0.03	1					0.03
Технолог	4.2	Технологийн төлөв байдал	0.025		2				0.05
	4.3	Технологийн дэвшлийн хурд	0.023		2				0.046
	4.4	Инновац	0.02		2				0.04
	5.1	Үндсэн хууль, 1992	0.001	1					0.001
Эрх зүй	5.2	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, 2019	0.025			3			0.075
	5.3	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, 2022	0.04			3			0.12
	5.4	Инновацын тухай, 2012	0.02	1					0.02
	6.1	Ногоон хөгжлийн бодлого	0.015		2				0.03
Экологи	6.2	Уур амьсгалын өөрчлөлт	0.03		2				0.06
	6.3	Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 2023	0.015			3			0.045
	7.1	Даян дэлхийн тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр	0.015		2				0.03
Глобал	7.2	Дэлхийн төлөв	0.02			3			0.06
	7.3	Бүс нутгийн төлөв	0.02		2				0.04
	7.4	Цар тахал Ковид-19	0.005		2				0.01
	7.5	Олон улс болон бүс нутгийн эдийн засгийн байдал	0.02		2				0.04

7.6	Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц	0.001	2	0.002
Нийт ЖД оноо				2.264

Жич: Орчны төлөвийг 1-5 оноогоор үнэлсэн бөгөөд 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-муу, 1-маш муу (Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Тус салбарын гадаад орчны төлөв жигнэгдсэн дундаж оноогоор 2.26 буюу муу үнэлгээ үзүүлсэн. Үүнийг хүчин зүйл тус бүрээр нэгтгэн дараах зурагт харуулав (Зураг 36). Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу.

Зураг 35. Салбарын гадаад орчны үнэлгээ



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулснаар)

2.2.6. Салбарын SWOT шинжилгээ

Жижиг, дунд үйлдвэрийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг салбарын түвшинд “SWOT” шинжилгээгээр үнэлэхийг зорив. Жижиг, дунд үйлдвэрийн салбарын нөхцөл байдлыг давуу, сул тал, боломж, эрсдэлээр шинжлэн харуулав (Хүснэгт 22).

Хүснэгт 22. ЖДҮ-ийн салбарын нөхцөл байдлын SWOT шинжилгээ

Хөгжлийн дотоод хүчин зүйлс	
ДАВУУ ТАЛ /Strengths/	СУЛ ТАЛ /Weakness/
<p>S1 Байгалийн бүс бүслүүрийн өвөрмөц тогтоцтой олон хэв шинж бүхий ландшафт, өргөн уудам нутаг дэвсгэр</p> <p>S2 Байгалийн цэвэр болон саарал усны нөөц, хангамж</p> <p>S3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрийн генийн өөрчлөлтгүй, экологийн цэвэр орчны үйлдвэрийн кластер хөгжлийн нөөц</p> <p>S4 ҮТП-ын бүсчилсэн хөгжлийн дэд бүтцийн хангамж</p> <p>S5 Жижиг, дунд үйлдвэрийн кластер хөгжлийн судалгааны ажил</p> <p>S6 Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулагдсан байдал</p> <p>S7 Хилийн боомтын үйл ажиллагааг өргөжүүлэх, гадаад худалдааг нэмэгдүүлэх арга хэмжээнд ЗГ зүгээс ач холбогдол өгч хүчин чармайлт гаргаж байгаа байдал</p>	<p>W1 Төв, орон нутгийн удирдлагын манлайлал, мэдлэг, ойлголт</p> <p>W2 Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай санал боловсруулж, дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх /ЖДҮҮ дэмжих тухай хууль 18.3/</p> <p>W3 Төр, хувийн хэвшил, ШУ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээ</p> <p>W4 Орон нутагт ШУ, судалгааны байгууллага байхгүй байдал</p> <p>W5 Хязгаарлагдмал хэмжээний улсын болон орон нутгийн санхүүгийн нөөц</p> <p>W6 Үйлдвэрийн менежмент, маркетинг, технологи, инновацийн бодлого /гарааны бизнес хөгжүүлэлт/</p> <p>W7 Мэргэшсэн хүний нөөцийн ур чадваргүй байдал</p> <p>W8 Хууль эрх зүйн орчин /хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хөнгөлөлт, чөлөөлөлт/</p> <p>W9 Бизнес, олон нийтийн нэгдсэн сүлжээ</p> <p>W10 ЖДҮ-ийн кластер хөгжил /Боловсруулах томоохон үйлдвэр байхгүй байгаа байдал/</p> <p>W11 Том нэгжүүд асуудал шийдвэрлэхэд давамгайлах, аж ахуй нэгжүүд ашиг сонирхолын зөрчлөө давж, нэгдэн ажиллаж чадахгүй байгаа байдал</p> <p>W12 Экспортод бүтээгдэхүүн борлуулалтын стандарт, өрсөлдөх чадвар</p> <p>W13 Төв суурин газрын ойролцоох үйлдвэрлэлийн бүсэд газар эзэмшин ЖДҮ эрхлэн орлогоо нэмэгдүүлэн иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх</p> <p>W14 Үйлдвэрийн төвлөрөл бий болсноор дулаан, цахилгааны хэрэгцээ нэмэгдэж, шугам сүлжээний ачаалал ихсэх</p> <p>W15 Улс төрийн намуудын бодлогын хэрэгжилт</p>
Хөгжлийн гадаад хүчин зүйлс	
БОЛОМЖ /Opportunities/	АЮУЛ, ЭРСДЭЛ /Threats/
<p>O1 Үндэстэн дамнасан эдийн засгийн том зах зээл /Үйлдвэр хөгжсөн хөрш зэргэлдээх том гүрнүүдийн түншлэл, хамтын ажиллагаа/</p> <p>O2 Үйлдвэрийг кластераар хөгжүүлсэн улс орнуудын эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллагууд, ҮТП-уудын хамтын ажиллагааны туршлага</p>	<p>T1 Байгалийн /уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, ган, зуд/ болон давагдашгүй хүчин зүйлс</p> <p>T2 Дэлхий нийтийг хамарсан хөл хорио, гоц халдварт өвчлөл</p> <p>T3 Дэлхийн болоод хил зэргэлдээ улсын дайн, байлдаан, самуун</p> <p>T4 Эдийн засгийн хямрал</p>

<p>О3 Уул, уурхай, хөдөө аж ахуйн түүхий эд материалын баялаг нөөц</p> <p>О4 Гадаад хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа, бүтээгдэхүүн танилцуулалт, үзэсгэлэн худалдаа</p> <p>О5 Гадаад зах зээлд гарах гарц ойрхон, хилийн боомттой, экспортыг нэмэгдүүлэх</p> <p>О6 Агаар, төмөр болон хатуу хучилттай замын транзит тээвэр</p> <p>О7 Үйлдвэрлэл хөгжсөнөөр нийгэм, эдийн засаг сэргэж, ажилгүйдэл, ядуурал буурах</p> <p>О8 Хууль эрх зүйн орчны нөлөөлөл /төрийн бодлого, шийдвэр/</p> <p>О9 Уул, уурхай, ХАА бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийн баялаг нөөц, дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй гадаад зах зээлд гаргах</p> <p>О10 ХАА-н гаралтай бүтээгдэхүүний зах зээл тэлэх, эргэлтэд орох боломж нэмэгдсэнээр малын сүргийн бүтцийг зөв зохион байгуулах, малын тоо, толгойг бууруулан газрын доройтолоос ангижрах</p> <p>О11 Хүн ам, хөдөлмөрийн насны ажиллах хүчний нөөц</p> <p>О12 Барилгын материалын түүхий эдийн нөөц</p> <p>О13 Хөрш зэргэлдээ аймаг, орон нутаг, гадаадын бусад орнуудтай бүсчилсэн хөгжлийн кластер хөгжүүлэх</p> <p>О14 Инновацийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх гурвалсан холбоост загварын гадаад, дотоод хамтын ажиллагаа</p>	<p>T5 Хилийн хязгаарлалт</p> <p>T6 Агаар, хөрсний бохирдол</p> <p>T7Хатуу хог хаягдлын бөөгнөрөл бий болсноор иргэдийн эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл бий болох</p>
---	--

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Салбарын орчны төлөвийг PESTLE шинжилгээгээр үнэлэхэд жигнэсэн дунджаас доогуур байгаа нь цаашид хөгжүүлэх арга замуудыг эрэлхийлэх, зохион байгуулалтын ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Байгууллагын гадаад, дотоод орчны нөхцөл байдлыг SWOT шинжилгээгээр шинжлэхэд сул талаа давуу тал болгох, боломжуудаа нэмэгдүүлэх гадаад хүчин зүйлд анхаарч хөрөнгө оруулалт татаж хөгжүүлэх, гадаад нөөц боломжоо бүрэн ашиглаж давуу тал болгох шийдлүүд харагдаж байна.

Тиймээс жижиг, дунд үйлдвэрийн кластераар хөгжүүлэхэд гол шинж чанар нь кластеруудыг урамшуулах, зохион байгуулах, удирдах арга замууд нь нөлөөлдөг болох нь судалгааны явцад ажиглагдав. Хууль эрх зүйн хүрээнд одоо цаг үед институци /төр, академик, үйлдвэр/ хоорондын хамтын ажиллагаагаар хөгжүүлэх тохиромжтой бөгөөд үндэс суурь нь болж байна.

Судалгаанд жижиг, дунд үйлдвэрийн кластер хөгжлийн гурвалсан холбоос (Triple helix) загварын дагуу элементүүд (институци, өрсөлдөөн ба инновац, бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагаа, чадамж, боломж, хүчин зүйлийн нөлөө)-ийн санаачилга, хоорондын холбоос, хөгжүүлэлт хийх хэрэгтэй байгаа нь харагдав.

ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын энэхүү бүлэгт Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдлыг Жижиг, дунд үйлдвэрийн өнөөгийн байдал, Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцооны үнэлгээг Төрийн удирдлагын байдлын үнэлгээ, Академик (ШУ, боловсрол) байдлын үнэлгээ, Жижиг, дунд үйлдвэр (бизнес)-ийн байдлын үнэлгээ, Институци (төр, академик, үйлдвэр)-ийн хамтын ажиллагаанд гурвалсан холбоост байгууллагуудын ажлын уялдаа холбоо, шинэ мэдлэг, технологи, инновац нэвтрүүлэлтийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт татах боломж сул байгааг судалгаагаар илрүүлсэн нь бүлгийн зорилго юм.

Кластерт төрийн оролцоог Монгол улсын төрийн удирдлагын байгууллагад хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд болон төрийн гүйцэтгэх үүрэг, бодлого, дэмжлэг, хэрэгжүүлэлтийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон. Төрийн удирдлагын байгууллага жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэхэд улсын төсвийн 5.8 хувийг хуваарилж буй байдал, Академик оролцоог (шинжлэх ухаан/боловсрол) байгууллагад боловсролын салбарын хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд болон түүний хэрэгжилт, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, технологийн дамжуулалт, дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэлтийн шатны ажил, арга хэмжээнүүдийг тодорхойлох, боловсролын байгууллагын 64 буюу 92,8 хувь нь төв суурин УБ, 5 буюу 7.2 хувь хөдөө орон нутагт байршиж байгаа нь боловсролын чанар, хүртээмжийн ялгавартай байдлыг арилгах шаардлагатай, Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үеийн үүд хаалгаа барьсан 2000 гаруй аж ахуй нэгж, жижиг, дунд үйлдвэрийн нэмэгдсэн өртгийн 23.8 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 65.2 хувь нь үйлчилгээний салбарт ноогдож байгаа нь тулгамдсан асуудал үүсэхэд нөлөөлж байгаа судалгаагаар харуулав. Үйлдвэрлэгч талын оролцоог Сүхбаатар аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжид салбарын хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд болон түүний хэрэгжилт, өрсөлдөөн, инновац, бизнес эрхлэгчид, санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны элементүүдээр хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний байдлыг тодорхойлсноор давуу талтай юм.

Жижиг, дунд үйлдвэрийн салбарын гадаад орчны төлөв байдлыг “PESTLE” шижилгээгээр шинжлэхэд жигнэсэн дундаж үнэлгээгээр 2.26 хувь байгаа нь

хангалтгүй үзүүлэлт бөгөөд сайжруулалт хийх, нөхцөл байдлын “SWOT” шинжилгээгээр байгууллагуудыг чадавхжуулах, санхүү, хөрөнгө оруулалт татах, гадаад харилцаа зэргийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Эдгээр үнэлгээ, шинжилгээний үр дүн нь судалгаанд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, санал, зөвлөмжийг дараагийн бүлэгт боловсруулахад ач холбогдолтой гэж дүгнэж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

3.1. Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоонд тулгамдаж буй асуудал

Монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн салбар нь өнгөрсөн хугацаанд Монгол орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд нэлээдгүй онцгой үүргийг гүйцэтгэсэн байдаг бөгөөд Дэлхийд өрсөлдөхүйц хэмжээнд төрийн бодлогын түвшинд хүргэх үйл явц дутагдалтай байсаар ирсэн. Тиймээс жижиг, дунд үйлдвэрийн кластерын тогтолцоо, төв, орон нутаг, эрдэм, шинжилгээ, судалгаа, бизнесийн байгууллагуудын стратеги, өрсөлдөөн, хамтын ажиллагаа, *хөгжлийн хүчин зүйл*, гүйцэтгэх үүрэг, дотоод, гадаадын санхүүжилт, хүн ам, ажиллах хүчин буюу мэргэшсэн мэргэжилтний нөөцийг бэлтгэх болон бусад уялдаа холбоог хангах асуудал хамгийн чухал байгаа нь судалгааны байдлаас харагдаж байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн мэдлэг, ур чадвар, санхүүгийн боломж сул байгаагаас байнгын ашиг орлоготой бизнесийг тогтвортой эрхлэх боломж хангалтгүй байгааг гадаад, дотоодын судлаач, шинжээчид, “Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал-2018” (Монгол банк), “Ковид-19 Цар тахлын дараах бизнесийн орчин: сорилт ба боломж-2020” (МҮХАҮТ, Эдийн засгийн шинжээчдийн клуб), “Цар тахал-Бичил бизнес эрлэгчдэд үзүүлж буй нөлөө-2020” (ХБНГУ-ын Фридрих Эбертийн сан), “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн Үндэсний хэмжээний санал-2020” (Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо), “Монголын бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөний үнэлгээ-2021” (Азийн сан, Хараат бус Судалгааны Хүрээлэн), “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санал-2022” (НҮБ-ын Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх стратегийн төсөл) зэрэг эдгээр судалгааны ажлын тайлан, санал, дүгнэлтээс харж болохоор байна.


Төр, олон нийтийн байгууллагууд, Сүхбаатар аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдээс авсан судалгааны байдлаас харахад ЖДҮ эрхлэгч нарт ажлын байраа хадгалах, цалин тавих (53.4%), зээлийн эргэн төлөлт (59.6%), түрээсийн төлбөр (38.6%), эргэлтийн хөрөнгөгүй байх (28.4%), түүхий эд, бараа материалын хомсдол (22.4%) зэрэг хүндрэл бэрхшээлүүд хамгийн ихээр

тулгарч байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын 64.5% нь зээлийн эргэн төлөлт хамгийн том сорилт, бэрхшээл болж байна хэмээн хариулжээ.

Тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэвэл цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой гэсэн үүднээс үйл ажиллагаа нь түр зогссон жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдээс судалгаа авахад үйл ажиллагаа нь түр зогсох болсон шалтгааныг түүхий эдийн хомсдол, эргэлтийн хөрөнгийн дутагдал, ажиллах хүчний чадвар, улирлын чанар, техник технологийн хоцрогдол, зах зээлийн эрэлт, татвар зэргийг нэрлэж байлаа. Бизнес эрхлэгчдийн нэрлээгүй боловч ТБ, ТББ-ийн төлөөллийн дүгнэлтээр бизнес эрхлэгчдийн ур чадварын асуудал мөн нөлөөлж байгаа нь эмпирик судалгаанаас харагдана.

Сүхбаатар аймгийн жижиг, дунд үйлдвэрлэгч иргэн, аж нэгж, байгууллагуудын дунд явуулсан судалгааны үр дүнг Зураг 36-д харуулав.

Зураг 36. ЖДҮ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал (хувиар)



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Монгол улсын төрөөс жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын зарим асуудал, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгч нарт үйл ажиллагааны зөвшөөрөл авах болон бусад төрийн байгууллагаас шаардлагатай үйлчилгээ авах үйл явц, тендер, сонгон шалгаруулалтад материал бүрдүүлэх, банкны баталгаа гаргуулах гэх мэт бичиг баримтын талаарх үйлдвэрлэл эрхлэгч нарын мэдлэг, ур чадвар дутмаг байдал, зарим эдийн засгийн хүндрэлийн хахир хатуу заалтууд гэх мэт тулгардаг бэрхшээлүүд тулгамдсан асуудал болж байна. Мөн түрээсний төлбөр,

эргэлтийн хөрөнгөгүй байх, түүхий эд, бараа материалын хомсдол, ур чадвартай хүний нөөц, ажилчдын идэвх санаачилга зэрэг нь хамгийн их тулгарч буй хүндрэл болж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Эдгээр судалгаануудын болоод уг судалгааны ажлын 2 дугаар бүлгийн 2.1-н иргэн, аж ахуй нэгжүүдийн дунд явуулсан судалгааны үр дүн, 2.2 дэд бүлэгт жижиг, дунд үйлдвэрийг кластер тогтолцооны гурвалсан холбоост загварын институциудыг үнэлсэн үнэлгээний жигнэсэн дундаж үнэлгээнээс доогуур байгаа байдлаас харьцуулан харж тулгамдсан асуудлуудыг тодорхойлов.

Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоонд:

Монгол улсын төрийн удирдлагын байгууллагад:

- ▶ Монгол улсын Засгийн газрын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрийн захиргааны төв байгууллагын баримталж буй бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлого, Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028 хөгжлийн бодлогын баримт бичиг, Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх тухай тусгасан байна. Хэдий тийм ч батлагдсан хууль, бодлогын зарим баримт бичгүүдэд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх талаар үзэл баримтлалын хэмжээнд тусгасан байгаа байдал нь хангалтгүй байсан бөгөөд эдгээр бодлогын баримт бичгүүдэд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх зарим заалтууд хуулбарласан, тунхаглалын шинжтэй, өөр хоорондоо уялдаа холбоогүй, хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй байна.
- ▶ Төрийн бүх шатны байгууллагын удирдлага жижиг, дунд үйлдвэрийг кластер тогтолцооны мэдлэг, нэгдсэн ойлголттой болж байж шийдвэр гаргалтад нөлөөлж хөгжүүлэх шаардлага байна.
- ▶ Улс орны хөгжлийн тулгуур болсон мэдлэг, шинэ технологи, инновац нэвтрүүлэх, ажлын байр нэмэгдүүлдэг, нэмүү өртөг шингээж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрлэлийн салбарт зээл, санхүү, мөнгөн эх үүсвэр, зарцуулах байдал хангалтгүй байна.

- ▶ Улсын төсөвт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр 2023 оны нийт төсвийн 5,8 хувь, сангийн хөрөнгөөр 2018 онд 96 тэрбум, 2021 онд 800 сая төгрөг харьцангуй байдлаар тусгаж байгаа байдлыг харгалзан тогтвортой өсөн нэмэгдэх байдлаар дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.
- ▶ Төр зуучлагчийн үүргийн хүрээнд гадаад харилцааг сайжруулж шинжлэх ухааны харилцан туршлага солилцох, хөрөнгө оруулалт татах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.
- ▶ Төрийн бодлогын хүрээнд ажлын байрны дэмжлэг түрээснээс чөлөөлөх, зээлийн эргэн төлөлтийн хөнгөлөлт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хил, гаалийн дэмжлэг, дотоодын болон гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж олголтын байдал хангалтгүй байна.
- ▶ Төрийн санаачилга, хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Академик (боловсрол, ШУ) байгууллагад:

- ▶ Шинжлэх ухаан, технологийн тухай, Технологи дамжуулах тухай, Дээд боловсролын байгууллагын тухай, Инновацийн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх арга зам, хэрэгжилт, ажлын гүйцэтгэл, хяналт хангалтгүй байна.
- ▶ Шинжлэх ухаан, боловсролын байгууллагын зөвлөх үйлчилгээ, шинэ мэдлэг, технологи, инновацыг түгээх судалгаа, шинжилгээ, туршилтын нэгж, мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагын статусыг өөрчлөх, үйл ажиллагааг өргөтгөх шаардлага байна.
- ▶ Шинжлэх ухааны байгууллагад судалгаа, туршилт, инновац нэвтрүүлэх, мэдлэг, дадлага, ур чадвартай эрдэмтэн, судлаачдын эрэлт хэрэгцээ шаардлагатай байна.
- ▶ Боловсролын байгууллагын 64 буюу 92,8 хувь нь төв суурин УБ, 5 буюу 7.2 хувь хөдөө орон нутагт байршиж байгаа нь боловсролын чанар, хүртээмжийн ялгавартай байдлыг арилгах шаардлагатай байна.
- ▶ Боловсролын салбарын их, дээд сургуульд 2023 оны байдлаар суралцагч, мэргэжил эзэмшилт эрэгтэй 56,444 буюу 38.9 хувь, эмэгтэйчүүд 88,823 буюу

61.1 хувийн хүйсийн ялгаатай байдлыг салбарын яам бодлогын хэрэгжилтэд анхаарах хэрэгтэй байна.

- ▶ Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагад 2021-2022 оны хичээлийн жилд нийт 22251 төгсөгчдийн 9614 буюу 43.2 хувь нь ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байгаа байдлаас дүгнэлт хийн ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр боловсрол, бизнесийн салбарын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.
- ▶ Орон нутагт мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, шинжлэх ухаан, судалгаа, шинжилгээ, туршилт, технологи нэвтрүүлэлт хийх, гарааны бизнесийг хөгжүүлэх хэрэгцээ байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид:

- ▶ Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, Үйлдвэр, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Өрсөлдөөний тухай, Компанийн тухай, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр зэрэг хууль, эрх зүйн баримт бичигт үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх тухай тусгасан байна. Хэдий тийм ч батлагдсан хууль, бодлогын зарим баримт бичгүүдэд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх талаар үзэл баримтлал тунхаглалын шинжтэй өөр хоорондоо уялдаа холбоогүй, хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй байна.
- ▶ Салбарын нөхцөл байдлын SWOT, орчны PESTLE шинжилгээгээр жигнэсэн дундаж үнэлгээний дунджаас доогуур буюу 2,26 байгаа нь улсын нийгэм, эдийн засгийн байдал хангалтгүй байгаа нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авах хэрэгтэй байна.
- ▶ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдэд үйлдвэрийн кластер хөгжлийн талаар онолын болоод практик мэдлэг, нэгдсэн ойлголттой болох шаардлага байна.
- ▶ Бизнесийн байгууллагууд бэнчмаркетинг хийх, чадавхжуулах, хүний нөөцийг сургаж бэлтгэх, шинэ технологи, инновац нэвтрүүлэх байдал хангалтгүй байна.
- ▶ Жижиг, дунд үйлдвэрийн нэмэгдсэн өртгийн 23.8 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 65.2 хувь нь үйлчилгээний салбар ноогдож Монгол улс

үйлдвэрлэлийн орон зайд хэрэглээний эдийн засагтай болсон байдал нь харамсалтай нөхцөл байдлыг бий болгосон байна.

- ▶ Уул уурхай, ХАА-н салбарт тулгуурлаж бусад үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ▶ Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үеийн үүд хаалгаа барьсан 2000 гаруй аж ахуй нэгжийг дэмжих бодлогын нэн шаардлагатай ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Институци (төр, академик, үйлдвэр)-ийн хамтын ажиллагаанд:

- ▶ Хууль, тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, МУ-ын Засгийн газар, эрдэм шинжилгээ, боловсролын байгууллага, үйлдвэр хөгжлийн салбарын гурвалсан уялдаа холбоо хангалтгүй байна.
- ▶ Төр, ШУ, ЖДҮ-ийн санаачилга, хамтын ажиллагаагаар хамтарсан сургалт, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ажил, үүрэг гүйцэтгүүлэх байдал хангалтгүй байна.
- ▶ Институциудын гурвалсан холбоост тогтолцоо, хамтын ажиллагаагаар жижиг, дунд үйлдвэрийн кластер буюу бөөгнөрлөөр эдийн засгийн төвлөрөл бий болж, ажлын байр нэмэгдүүлэх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ▶ Институциудын хамтын ажиллагаагаар бизнес инкубатор төвүүдийг байгуулах, бизнесүүдийг бойжуулж хөгжүүлэх байдал хангалтгүй байна.
- ▶ Институциудын хамтын ажиллагаагаар инновац нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах орчныг бүрдүүлэх, худалдаа арилжааны нэгдсэн сүлжээ бий болгох шаардлагатай байна.
- ▶ Институциудын хамтын ажиллагааны хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, мэдээлэл, технологи нэвтрүүлэлтийн нэгдсэн систем шаардлагатай байна.

Тулгамдаж байгаа эдгээр асуудлуудаас гадна жижиг, дунд үйлдвэрлэгч нарын суурь бүрэлдэхүүн тодорхой хэмжээнд үйл ажиллагаа явуулах хэмжээнд байгаа хэдий ч цаг үеийн шаардлагаар бизнес сэтгэлгээний хөгжил, технологийн шинэчлэл хийх асуудал тулгарсаар байна. Бодлогын алдаа орон нутгийн хууль эрх зүйн болоод санхүү, бусад төрлийн хөнгөлөлтийн дэмжлэг сул байгаагаас жижиг, дунд


үйлдвэрлэл эрхлэгч буюу иргэдийн хөдөлмөр эрхлэлт эрсдэл үүсэхээс эмээж урам зориг эрс багассан бөгөөд цар тахал, “Ковид-19” нөхцөл байдал маш их давагдашгүй нөхцөл байдал бий болсон. Дэлхийн хөгжингүй орнууд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлсэн учраас эдийн засгийн хямрал, цар тахал гэх мэт нийтийг хамарсан давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд бага өртдөг бөгөөд үйлдвэрлэлийг хөгжүүлээгүй, хөгжиж байгаа орнууд хохирол их амсаж байгаа нь Олон улсын судалгаануудаас харагдана. Улс орны бодлого ч мөн аж ахуй эрхлэгч нарт ирэх ачаалал буюу татвар, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас бизнес эрхлэгчид шантарч байгаа нь алхам тутамд судалгаа бүрээс харагдана. Иргэдийн бизнес сэтгэлгээ, гарааны бизнесүүдийг хөгжүүлэхэд төр, бизнесийн байгууллага, банк, санхүү, иргэдийн хамтын ажиллагаа багийн ажиллагаа, нэгдэл, үйлдвэрлэлийн кластер хөгжлийг хослуулах зэрэг асуудлуудтай тулгарч байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын шийдвэр гаргалт, эрсдэл үүрэх, арга замыг тодорхойлох, нэгдсэн байр суурьтай байх зэрэг хүчин зүйлүүд зайлшгүй дутагдана.

Төр, эрдэм шинжилгээний байгууллага /боловсрол/, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, иргэд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хэрхэн хөгжүүлэх онолын болоод практик ойлголт, мэдлэг дутмаг байгаа нь хөгжлийн саад, бидний том дутагдал юм. Ойлголтгүй аль ч субъект жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх дэмжлэг, хөрөнгө оруулалт, бусад хүчин зүйлүүдэд анхаарал хандуулах гэдэг бол бэрхшээлтэй, тулгамдсан асуудал болоод байна.

3.2. Жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх загвар, санал, зөвлөмж

Бид жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх гурвалсан холбоост загварын өргөтгөсөн хувилбарыг үндэсний онцлогт нийцүүлэн боловсруулсан бөгөөд тус загварыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төрийн санаачилга, үйлдвэр эрхлэгч, шинжлэх ухаан, дээд боловсролын байгууллагын идэвхтэй оролцоо, тэдний нэг зорилгын төлөөх хамтын ажиллагаа, харилцаан дор кластер бүрэлдэж, ажиллах боломжтой юм (Зураг 38).

Зураг 37. Жижиг, дунд үйлдвэрийн гурвалсан холбоост загварын өргөтгөсөн хувилбар



(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Жижиг, дунд үйлдвэрийн кластерын тогтолцоог сонгодог байдлаар ажиллуулахад тус системийн дараах элементүүдийг нэг цэг дээр авч үзэх нь зүйтэй (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Жижиг, дунд үйлдвэрийн гурвалсан холбоост загварын элемент

Бүрэлдэхүүн хэсэг	Элемент
1 ТӨР (институци)	<p>Төрийн бодлого</p> <ul style="list-style-type: none"> • Урт хугацаа • Дунд хугацааны • Богино хугацааны <p>Эрх зүйн зохицуулалт</p> <ul style="list-style-type: none"> • Хууль, тогтоомж • Дүрэм, журам <p>Төрийн дэмжлэг</p> <ul style="list-style-type: none"> • Төлөвлөлт • Хөдөлмөр эрхлэлт • Зуучлагч • Санхүү ○ Туламж, хөнгөлөлт

		<ul style="list-style-type: none"> ○ Зээлийн хүү ○ Зээл, санхүүжилт ○ Татвар • Захиалга, худалдан авалт • Дэд бүтэц <p>Мэдээлэл, технологийн нэгдсэн сүлжээ Төрийн байгууллагын тогтолцоо, бүтэц</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн захиргааны байгууллага • Орон нутгийн удирдлага
2	<p>АКАДЕМИК (ШУ, боловсрол)</p>	<p>ШУ-ны байгууллага</p> <ul style="list-style-type: none"> • Эрдэм шинжилгээ, судалгаа <ul style="list-style-type: none"> ○ Хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх ○ Эрдэм шинжилгээний ажил ○ Эрдэм шинжилгээний туршилт ○ Зохион бүтээх ○ ШУ-ны салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх ○ ОУ-ын байгууллагатай хамтын ажиллагаа ○ Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар • Технологи дамжуулалт <ul style="list-style-type: none"> ○ Технологийн горим, үйл ажиллагааны нөхцөл ○ Технологийн шат дамжлагын дэс дараалал, горим, бүрдэл хэмийн талаарх зөвлөгөө, үйлчилгээ ○ Технологи нэвтрүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж ○ Шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээний үр дүн ○ Патент, лиценз, бүтээгдэхүүний загвар ○ Ноу-хау <p>Дээд боловсролын сургалтын байгууллага</p> <ul style="list-style-type: none"> • Их, дээд сургууль <ul style="list-style-type: none"> ○ Сургалт: Мэргэжилтэн бэлтгэх ○ Эрдэм шинжилгээ, судалгаа ○ Технологийн судалгаа ○ Сургалт-судалгааны бизнес-инкубатор ○ Технологи дамжуулах төв • Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага <ul style="list-style-type: none"> ○ Иргэнд хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, чадамж, мэргэжил эзэмшүүлэх ○ Гарааны компани

		<ul style="list-style-type: none"> ○ Салбар дундын дадлагын бааз ○ Бизнес инкубатор төв
3	ҮЙЛДВЭР (бизнес)	<p>Компани</p> <ul style="list-style-type: none"> • ЖДҮ, Аж ахуй нэгж байгууллага ○ Өрсөлдөөн, инноваци - Сургалт - Судалгаа хөгжүүлэлт - Хүн, бүтээлч капитал - Техник, технологи ○ Удирдлага, менежмент ○ Мэргэшсэн хүний хөөц ○ Маркетинг ○ Бүтээгдэхүүн, үйлчилгээ • Санхүү, хөрөнгө оруулалт ○ Санхүүгийн байгууллага ○ Хандивлагч • Байгалийн нөөц • Хамтын ажиллагаа ○ Дэмжигч, хамтрагч байгууллага ○ Ханган нийлүүлэлтийн сүлжээ ○ Дэд бүтэц ○ Мэдээллийн сүлжээ, идэвхжүүлэлтийн суваг
4	Институци хоорондын хамтын ажиллагаа	<p>Төр-ШУ, боловсрол</p> <ul style="list-style-type: none"> • ШУ, дээд боловсролын талаарх төрийн бодлого • Судалгаа хөгжүүлэлт • Хөрөнгө • Инкубатор төв <p>ШУ, боловсрол-Үйлдвэр</p> <ul style="list-style-type: none"> • Мэдлэг хуваалцах • Дадлагажуулах хөтөлбөр • Инноваци • Бизнес инкубатор • Шинэ мэдлэг, технологи нэврүүлэлт <p>Үйлдвэр-Төр</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэл, ЖДҮ-ийг дэмжих төрийн бодлого • Хөдөлмөрийн зах зээл • Сургалт, хөгжүүлэлт • Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэлт • Хөрөнгө оруулалт • Хандив • Орон нутгийн эдийн засгийн нэгж

	<p>Инноваци, хөрөнгө оруулалтын капитал</p> <ul style="list-style-type: none"> • Институцийн хамтын ажиллагааны сүлжээ • Судалгаа, арилжааны нэгдсэн сүлжээ • ШУ, технологийн парк • Технологи дэмжих хөтөлбөр • Үндэстэн дамнасан хөрөнгө оруулалт
--	--

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Энэхүү нэг сэдэвт бүтээлийн 2 дугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн нөхцөл байдалд SWOT шинжилгээ хийж кластер тогтолцоонд тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Тулгамдсан асуудлын хүрээнд SWOT шинжилгээний үр дүнд тулгуурлан салбарын кластерын хөгжлийн стратегийг TOWS матрицаар тодорхойлов. (Хүснэгт 24).

Хүснэгт 24. Стратегийн чиглэл (TOWS матриц)

SO- Давуу талдаа тулгуурлан + гадаад орчны шинэ боломжийг ашиглах БОГИНО ХУГАЦААНЫ СТРАТЕГИ	WO- сул талыг бууруулан + гадаад орчны шинэ боломжийг ашиглах ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ
<p>S1O10 Байгалийн өвөрмөц тогтоцтой олон хэв шинж бүхий ландшафт, өргөн уудам нутаг дэвсгэрт ХАА-н гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, эргэлтэд орох боломж нэмэгдсэнээр малын сүргийн бүтцийг зөв зохион байгуулах, малын тоо, толгойг бууруулан газрын доройтолоос ангижруулах</p> <p>S1O12 Байгалийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материал үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх</p> <p>S3O10 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрийн генийн өөрчлөлтгүй, экологийн цэвэр орчны үйлдвэрийн кластер хөгжлийн нөөцөд тулгуурлан зах зээлийг тэлэх</p> <p>S4O4 ҮТП-ын бүсчилсэн хөгжлийн дэд бүтцийн хангамжид тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга замыг хайх</p> <p>S5O2 Жижиг, дунд үйлдвэрийн кластер хөгжлийн судалгааны ажилд тулгуурлан хөгжсөн улс орнуудын эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллагууд, ҮТП-уудын хамтын ажиллагаа, туршлага судлах</p> <p>S7O13</p>	<p>W1O5 Төр, засгийн удирдлагын манлайлал, мэдлэг, ойлголт нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн гадаад зах зээлд гарах гарц ойрхон, хилийн боомтын экспортыг нэмэгдүүлэх</p> <p>W1O7 Төв засаг, орон нутгийн удирдлагын манлайлал, мэдлэг, ойлголт нь үйлдвэрлэлийг дэмжсэнээр нийгэм, эдийн засаг сэргээж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах</p> <p>W2O13 Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай санал боловсруулснаар хөрш зэргэлдээ аймаг, орон нутаг, гадаадын бусад орнуудтай бүсчилсэн хөгжлийн кластерыг хөгжүүлэх</p> <p>W2O14 Төв засаг, тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай санал боловсруулснаар инновацийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх гурвалсан холбоост загварын гадаад, дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэх</p> <p>W3O2 Төр, хувийн хэвшил, ШУ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагаа</p>

<p>Хөрш зэргэлдээ аймаг, орон нутаг, гадаадын бусад улс орнуудтай бүсчилсэн хөгжлийн кластер хөгжлийг бий болгох, хилийн боомтын үйл ажиллагааг өргөжүүлэх, гадаад худалдааг нэмэгдүүлэх арга хэмжээнд ЗГ зүгээс ач холбогдол өгч хүчин чармайлт гаргах</p>	<p>сайжирснаар үйлдвэрийг кластераар хөгжүүлэх боломж нэмэгдэх</p> <p>W3014 Төр, хувийн хэвшил, ШУ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирснаар инновацийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжыг бүрдүүлэх</p> <p>W4014 Орон нутгуудад ШУ, судалгааны байгууллагуудыг байгуулснаар инновацийн үйлдвэрлэл хөгжинө.</p> <p>W508 Хууль эрх зүйн орчны нөлөөлөл /төрийн бодлого, шийдвэр/ сайжирснаар хязгаарлагдмал хэмжээний улсын болон орон нутгийн санхүүгийн нөөц нэмэгдэнэ.</p> <p>W6014 Инновацийн үйлдвэрлэлийг хөгжүүлснээр үйлдвэрийн менежмент, маркетинг, технологи, инновацийн бодлого /гарааны бизнес хөгжүүлэлт/ сайжирна.</p> <p>W702 Мэргэшсэн хүний нөөцийн ур чадварт тулгуурлан үйлдвэрийг кластераар хөгжүүлэх</p> <p>W901 Үндэстэн дамнасан эдийн засгийн том зах зээл /Үйлдвэр хөгжсөн хөрш зэргэлдээх том гүрнүүдийн түншлэл, хамтын ажиллагаа/ нэмэгдсэнээр бизнес, олон нийтийн нэгдсэн сүлжээ бий болно.</p> <p>W902 Үйлдвэрийг кластераар хөгжүүлснээр улс орнуудын эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллагууд, бизнес, олон нийтийн нэгдсэн сүлжээ сайжирна.</p> <p>W1001 ЖДҮ-ийг кластераар хөгжүүлээгүй /Боловсруулах томоохон үйлдвэр байхгүй байгаа байдал/-гээс үндэстэн дамнасан эдийн засгийн том зах зээл /Үйлдвэр хөгжсөн хөрш зэргэлдээх том гүрнүүдийн түншлэл, хамтын ажиллагаа/-ийг татахгүй байх</p> <p>W10014 ЖДҮ-ийн кластер хөгжлөөр инновацийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх</p> <p>W1307 Төв суурин газрын ойролцоох үйлдвэрлэлийн бүсэд газар эзэмшин ЖДҮ эрхлэн орлогоо нэмэгдүүлэн иргэдийн амьжиргааны түвшин дээшилснээр улс,</p>
---	--

	<p>орон нутгийн нийгэм, эдийн засаг сэргэж, ажилгүйдэл, ядуурал буурах</p> <p>W14O9</p> <p>Уул, уурхай, ХАА бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийн баялаг нөөцийг үйлдвэрлэлийн эргэлтэнд оруулснаар байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх, үйлдвэрийн төвлөрөл хэт их бий болсноор дулаан, цахилгааны хэрэгцээ нэмэгдэж, шугам сүлжээний ачаалал ихсэх байдлыг тооцоолох</p>
ST- Давуу талдаа тулгуурлан + гадаад орчны аюулын нөлөөг арилгах ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ	WT- Гадаад орчны аюулын нөхцөлд сул талаа бууруулах УРТ ХУГАЦААНЫ СТРАТЕГИ
<p>S1T1</p> <p>Байгалийн бүс бүслүүрийн өвөрмөц тогтоцтой олон хэв шинж бүхий ландшафт, өргөн уудам нутаг дэвсгэрийг судалгаа төлөвлөлтгүй ашигласнаар байгалийн /уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, ган, зуд/ давагдашгүй хүчин зүйлс бий болох</p> <p>S1T3</p> <p>Байгалийн баялагт шунасан дэлхийн болоод хөрш зэргэлдээ орны гадаад бодлогын нөлөөгөөр эмх замбараагүй байдал, дайн самуун үүсэх</p> <p>S2T1</p> <p>Байгалийн цэвэр болон саарал усны нөөц, хангамж багассанаар цөлжилт бий болох эрсдэл</p> <p>S3T2</p> <p>ХАА бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангахгүй бол гоц халдварт өвчлөл, хорио цээр, хилийн хязгаарлалт бий болох</p>	<p>W14T6</p> <p>Үйлдвэрийн төвлөрөл бий болсноор дулаан, цахилгааны хэрэгцээ нэмэгдэж, шугам сүлжээний ачаалал ихэссэнээр агаар, хөрсний бохирдол бий болох</p> <p>W12T4</p> <p>Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлгүйн улмаас эдийн засгийн хямралд өртөх</p> <p>W15T7</p> <p>Үйлдвэрийн хэт төвлөрөл бий болсноор хатуу хог хаягдлын бөөгнөрөл бий болж иргэдийн эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх</p> <p>T2W12 Дэлхий нийтийг хамарсан хөл хорио, гоц халдварт өвчлөл, хилийн хязгаарлалтын улмаас экспортын бүтээгдэхүүн борлуулалт удааширах, зогсох</p>

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

Салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох TOWS матрицын үр дүн, уг судалгааны ажлын 3.1-д тодорхойлсон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дараах санал, зөвлөмжийг боловсруулав.

1. Төрийн чиг үүргийн хүрээнд:

а) *Монгол Улсын Их хуралд:*

- Шинжлэх ухаан, технологи, Инновац, Өрсөлдөөн, Гааль, Татвар, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэн даруй нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлт оруулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих,

- Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заагдсан урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд шинэчлэл хийх, боловсронгуй болгох,

b) Монгол Улсын Засгийн газарт:

Монгол улсын Засгийн газар, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, Өрсөлдөөн, Гааль, Татвар, Компани, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Шинэ сэргэлт, Гурван тулгуурт хөгжил, “Алсын хараа-2050 “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх тухай тусгагдсан холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангах хэрэгтэй байна.

- Засгийн газрын бүтцийн байгууллагууд, хэрэгжүүлэгч агентлагууд, түүний албан тушаалтнуудад жижиг, дунд үйлдвэрийн кластерын тухай онол, практикийн талаарх мэдлэгийг хурал, зөвлөгөөн, сургалтаар өгч нэгдсэн ойлголттой болсны үндсэн дээр бодлого боловсруулах, шийдвэрийг гаргах,
- Жижиг, дунд үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих хууль, бодлогын баримт бичигт тусгагдсан заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд бизнес эрхлэгчдийг дэмжих, зээлийн хүү, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, ажлын байрны түрээсийн зардлыг хөнгөлөх зэрэг үе шаттай арга хэмжээнүүдийг авч цар тахлын дараах эдийн засаг, аж ахуй нэгжийн сэргэлтийг бий болгох,
- Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, салбарын орчны PESTLE, нөхцөл байдлын SWOT шинжилгээгээр жигнэсэн дунджаас доогуур 2.26 буюу хангалтгүй байдлын үнэлгээнд дүгнэлт хийж олон талаас нөхцөл байдлыг олж харах,
- Улс, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн байдлыг сэргээх, шинэ ажлын байр бий болгох тулгуур асуудал нь үйлдвэрийн хөгжил гэдгийг судалж ойлгосны үндсэн дээр бодлогын шийдвэрүүдийг уялдуулж гаргах,
- Төр зуучлагчийн үүргийн дагуу гадаад харилцаагаа сайжруулж эдийн засгийг сэргээх тулгуур асуудал болсон ХАА гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт, уул уурхайгаас илүүтэй жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх улс дамнасан хөрөнгө оруулалтыг татах боломжийг нээх, эрэлхийлэх,

- Төр, бизнес, шинжлэх ухаан/боловсролын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хөгжсөн орнуудын шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн байгууллагуудтай харилцан туршлага солилцох, түншлэлийн гэрээ байгуулж улс орны хөгжлийг хурдасгах,
 - Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын оролцоо бүхий кластерыг хөгжүүлэх,
 - Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилготой шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлэх грант олгох арга хэмжээг түлхий зохион байгуулах, иргэдийн бүтээлч, зохион бүтээх сэтгэлгээг дэмжин хөгжүүлэх,
 - Жижиг, дунд үйлдвэрийн салбарын мэргэшсэн ажиллах хүчний нөөц, дэд бүтэц дээр тулгуурлан ҮТП-н хэлбэрээр үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх,
 - Уул уурхай, ХАА гаралтай бүтээгдэхүүний түүхий эдийн баялаг нөөц дээр тулгуурлаж гадаад зах зээлийн эргэлтэнд оруулах, тэлэх бодлого баримталж газар /хөрс/-ын доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах,
 - ХАА гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийн экспортын эрх /квот/-ийг орон нутагт шилжүүлж хөдөөгийн хөгжлийг дэмжих, бие даан хөгжих боломж, бололцоог нэмэгдүүлэх,
 - Хилийн боомтын үйл ажиллагааг өргөжүүлэх, гадаад худалдааг нэмэгдүүлэх арга хэмжээнд Засгийн газрын зүгээс онцгой ач холбогдол хүчин чармайлт гаргаж гадаад хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа, бүтээгдэхүүн танилцуулалт, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах,
 - Хөрш зэргэлдээ орнуудын үндэстэн дамнасан корпорациудын сонирхолыг татах, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, том зах зээлд нэвтрэх
 - Сүхбаатар аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, статусыг дээд боловсролын нийгмийн болон үйлдвэрийн хэрэгцээт мэргэжилтэн бэлтгэдэг, судалгаа, шинжилгээний байгууллага болгон өөрчлөх
- с) *Боловсрол, шинжлэх ухааны яаманд:*
- Жижиг, дунд үйлдвэрийн боловсон хүчнийг бэлтгэх, сургаж дадлагажуулах, шинжлэх ухаан судалгаа, шинжилгээ, туршилтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах,

- Боловсролын байгууллага /их, дээд сургууль/-ын 92.8 хувь нь төв суурин УБ, 7.2 хувь нь хөдөө орон нутагт байршиж байгаа нь боловсролын чанар, хүртээмжийн ялгавартай байдлыг арилгах арга хэмжээг авах,
- Боловсролын салбарын их, дээд сургуульд 2023 онд суралцагч, мэргэжлийн боловсрол эзэмшилт эмэгтэй 88,823 буюу 61.1 хувь, эрэгтэй 56,444 буюу 38.9 хувь байгаа хүйсийн ялгавартай байдалд дүгнэлт хийх, үр дагаврыг тооцох
- Улс орны хэрэгцээнд байгалийн шинжлэх ухааны мэргэжилтэн бэлтгэх бодлогын асуудалд анхаарах
- Төр, Үйлдвэр, ШУ байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээг бий болгох, үйлдвэрлэлийн менежмент, маркетинг, технологи, инновацийн бодлого хэрэгжүүлэх,

d) Сангийн яаманд:

- Монгол улсын эдийн засгийн хөгжилд зориулагдсан арилжааны банк, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй нөхцөлөөр олгодог зээл, тусламжийг ил тод, нээлттэй хуваарилах, шалгуур үзүүлэлтүүдийг уян хатан болгох,
- Улсын шинжлэх ухаан, шинэ технологи, инновацын үйл ажиллагааг дэмжих төсвийн хуваарилалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
- Хуулийн дагуу улсын төсвийн дэмжлэгээр гааль, татвар, зээлийн хөнгөлөлт, урамшууллын дүрэм, журмыг шинэчлэн батлах, худалдан авах үйл ажиллагааг боловсронгуй болгох
- Төсвийн хуваарилалтад үйлдвэрлэл хөгжлийн зарим эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн зорилгод нийцүүлэн хэсэгчлэн шилжүүлэх,

e) Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд:

- Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, төсвийн тооцоо, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, санхүүгийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг оновчлох,
- Үйлдвэрлэгчдийг гадаад зах зээлтэй холбох, хамтын ажиллагааг сэргээх, шинэ технологийг нэвтрүүлэх, шинэ ажлын байруудыг нэмэгдүүлж эдийн засгаа сэргээх, ажилгүйдлийг бууруулах,
- Улс орны бодлогын болон хуулийн хэрэгжилтийг хангах ажил, арга хэмжээний хүрээнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын уулзалтуудыг зохион байгуулж, боломж, гарцуудыг нээх,

- Улс орны хэрэгцээт үйлдвэрийг шинээр бий болгоход зоригтой шийдэл, шийдвэрүүдийг гаргаж, Төр-ШУ-Үйлдвэрийг кластераар хөгжүүлэх,
- Уул, уурхай, Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортод гаргах, зах зээлийн эргэлтэд оруулах, бэлчээрийн далхлалт, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах,

f) Жижиг, дунд үйлдвэрийн газарт:

- Засгийн газрын бүтцийн хэрэгжүүлэгч агентлагууд, түүний албан тушаалтнуудад жижиг, дунд үйлдвэрийн кластерын тухай онол, практикийн талаарх мэдлэгийг хурал, зөвлөгөөн, сургалтаар өгч нэгдсэн ойлголтой болсны үндсэн дээр хэрэгжүүлэлтэд үр дүн гаргах,
- Монгол улсын тулгуур хөгжлийн асуудалд Үндэсний хэмжээний нэгдсэн судалгаатай болох хэрэгцээ боломжуудыг олж харах, эрдэмтэн судлаачдын судалгаа, шинжилгээний бүтээлийг ажил хэрэгтээ ашиглах,

g) Нутгийн удирдлагын байгууллагад:

- Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028 хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, түүний биелэлтийг хангах,
- Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай санал боловсруулж дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх /ЖДҮҮ дэмжих тухай хуулийн 18.3 дахь заалт/
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, дэмжих заалтуудыг үе шаттай хэрэгжүүлэх,
- Нутгийн удирдлагын байгууллага жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх журам баталж, санхүүгийн шинэ эх үүсвэрүүдийг бий болгох,
- Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих, хөгжүүлэх, бойжуулах зорилгын хүрээнд “БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВ”-ийг байгуулах
- Нутгийн иргэдийн аж амьдралд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд иргэдийн оролцоог хангах, шинэ мэдлэг /инноваци/, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, төслийн уралдаануудыг зохион байгуулж идэвхжүүлэх, хөгжүүлэх
- Аймгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн статус, үйл ажиллагааг өргөжүүлж, салбарын шинжлэх ухааны мэдлэг, дадлага, ур чадвартай, дээд

боловсролын мэргэжилтэн бэлтгэдэг, мэргэшүүлдэг, хүний хөгжлийн орчин, мэдлэг урсах нөхцөлийг бүрдүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх,

- Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагад суралцан төгсөгчид, мэргэжилтэй боловсон хүчний 43.2 хувь нь ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байгаа байдалд дүгнэлт хийх, шалтгааныг тогтоож ажлын байрыг нэмэгдүүлэх, зуучлалын арга хэмжээ авах

2. Академик (ШУ, боловсрол) байгууллагын чиглэлээр:

Шинжлэх ухаан, технологийн тухай, Инновацын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого зэрэг хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан төрөөс шинжлэх ухаан, технологи хөгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх, бизнесийг дэмжин хөгжүүлэхтэй холбоотой заалтын хэрэгжилтийг хангах хэрэгцээ байна.

а) Шинжлэх ухааны академид

- Шинжлэх ухаан, боловсролын байгууллагын зөвлөх үйлчилгээ, шинэ мэдлэг, технологи, инновацыг нэвтрүүлэх судалгаа, шинжилгээ, туршилтын нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулах,
- Судлаач, эрдэмтдийн бүтээл, шинжлэх ухааны нээлтүүдийг бүтээлч үйлдвэрлэлд нэвтрүүлэх,
- Эрдэмтэн, судлаачид бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, хөгжүүлэхэд сургалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах,
- Бодлогын судалгааны ТИНК ТАНК, бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагаагаар хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Дэлхийн хөгжингүй орнуудын шинжлэх ухааны байгууллагуудтай гадаад харилцаагаа өргөжүүлж харилцан туршлага судлах, хамтын ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж туршилт, судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлж мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

б) Дээд боловсролын байгууллагуудад:

- Боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэх сургалтын агуулгад өөрчлөлт оруулах, онол, практикийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх хослолыг бий болгох,

- Их, дээд сургуулиуд, жижиг, дунд үйлдвэрийн байгууллагуудтай, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах

3. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн чиглэлээр:

- Шинэ мэдлэг, технологи, инновацыг нэвтрүүлснээр аж ахуй нэгж, хүний нөөцийн өрсөлдөөн бий болгох нөхцөлийг бүрдүүлэх,
- Салбарын байгууллагуудыг чадавхжуулах сургалт, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, бизнесийн туршлага солилцох бэнчмаркетинг арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Гарааны бизнесийн “START UP”-аар хөгжүүлэх, бүтээлч үйлдвэрлэл рүү хөгжлийг чиглүүлэх
- Хөрш орнуудын жижиг, дунд үйлдвэрийн байгууллагуудтай түншийн харилцаа, хамтын ажиллагаа тогтоож эрэлтэд зах зээлд нийлүүлэлт хийх арга замыг хайх, эрэлхийлэх,
- Жижиг, дунд үйлдвэрийн кластераар хөгжүүлж хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх ,
- Экспортын хөрөнгө оруулалтаар бусад үйлдвэрийг кластераар хөгжүүлж, эдийн засгийн төвлөрөл бий болгож, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах,
- Бизнес эрхлэгчдийг чадавхжуулах арга хэмжээ, бизнес инкубатор төвөөр гарааны бизнесийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх,
- Бизнесийн үйл ажиллагаа нь бойжих хүртэлх удаан хугацааны бага хүүтэй зээл олгох, зээлийн чөлөөлөлт, түрээсийн байрны хөнгөлөлттэй нөхцөлүүдийг сайжруулах

4. Институци (төр, академик, үйлдвэр)-ийн хамтын ажиллагааны чиглэлээр

а. Институциудын дундын холбоос:

- Төр, боловсрол, шинжлэх ухаан, үйлдвэрийн салбарын хөгжлийн гурвалсан холбоост тогтолцооны уялдаа холбоо, хууль, тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах,
- Төр-Үйлдвэрийн байгууллагын хамтын ажиллагаагаар шинэ ажлын байр бий болгож хөдөлмөрийн зах зээлийг нэмэгдүүлэх,

- Академик-Үйлдвэрийн байгууллагын хамтын ажиллагаагаар бизнес инкубатор төвүүдийг байгуулах, мэдлэг хуваалцах, гарааны бизнесүүдийг бойжуулах, хөгжүүлэх,
 - ШУ, боловсрол-Үйлдвэрийн хамтын ажиллагаагаар шинэ мэдлэг хуваалцах, технологи нэвтрүүлэлт хийх,
 - Төр-шинжлэх ухааны байгууллагын дундын холбоосоор судалгаануудыг эхлүүлэх, хөгжүүлэх, дээд боловсролыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төрийн бодлого боловсруулах,
 - Төр-шинжлэх ухаан, боловсрол- үйлдвэрийн байгууллагын дундын холбоосоор шинэ мэдлэг, технологи нэвтрүүлэх, арилжаа, мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх,
 - Төр-Үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцооны хөгжлийн бодлого боловсруулж, үндэстэн дамнасан хөрөнгө оруулалтыг татах нөхцөл, боломжийг бүрдүүлэх,
 - Гурвалсан холбоост тогтолцооны институциудын санаачилга, хамтын ажиллагаагаар сургалт, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ажил, үүргийн холбоосыг хангах,
 - Шинжлэх ухаан-Үйлдвэр технологийн парк байгуулж шинэ технологи, инноваци, мэргэшсэн хүний нөөц, эдийн засгийн төвлөрлийг бий болгох
- b. Шинжлэх ухаан-Үйлдвэр технологийн парк:*
- Шинжлэх ухааны парк байгуулагдсанаар шинэ мэдлэг, өндөр технологи, шинжлэх ухааны нээлт, инновацыг бүтээлч үйлдвэрлэлд нэвтрүүлэх
 - Үйлдвэр технологийн паркийн гадаад хамтын ажиллагаа, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг хөгжүүлэх, паркуудын хамтарсан нийгэмлэг, холбоо, нэгдлийг бий болгох,
 - Улс, орон нутгийн төсөв, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн сүлжээг бүтээн байгуулах, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн төвлөрлийг бий болгож бүсчлэн хөгжүүлэх,
 - Шинжлэх ухаан-үйлдвэр технологийн паркийг хөгжүүлж, үйл ажиллагааг өргөжүүлснээр улс орны нийгэм, эдийн засгийн байдлыг сэргээж шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх,

- “Сүхбаатар хөгжил” үйлдвэрлэл, технологийн паркийн бааз суурин дээр тулгуурлаж жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, бизнес инкубатор төвийн үйл ажиллагаагаар аж ахуй нэгжүүдийг бойжуулах, чадавхжуулах, бизнес эрхлэгчдийг сургаж хөгжүүлэх,
- Улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн дэд бүтцийн ажлын одоогийн боломжийг түшиглэн жижиг, дунд үйлдвэрүүд, бусад бизнес эрхлэгч нартай хамтын ажиллагааны гэрээний ашигтай нөхцөлийн саналуудыг боловсруулан хөгжүүлэх гэх мэт асуудлууд байна.

Эдгээр санал, зөвлөмжийг хэрэгжүүлснээр жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлэгт жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, кластер тогтолцооны өргөтгөсөн хувилбарыг боловсруулж, санал зөвлөмж боловсруулан тодорхойлсон болно.

Жижиг, дунд үйлдвэрийн кластер тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг гурвалсан холбоост загварын институциуд /Төр, ШУ/боловсрол, үйлдвэр/-ын хоорондын уялдаа холбоогоор тусган харуулснаараа нэг сэдэвт судалгааны ажилтай уялдаж байна.

Судалгааны энэхүү бүлэгт 2 дугаар бүлгийн шинжилгээ, судалгаанд тулгуурлан гурвалсан холбоост загварын институциудын үүрэг тус бүрээр тулгамдсан асуудлыг тодорхойлж, жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэхэд гурвалсан холбоост загварын өргөтгөсөн хувилбарыг боловсруулж түүний элементүүдийг тодорхойлж гаргаж ирсэн нь Монгол улсын болон орон нутгийн үйлдвэрийг хөгжүүлэх арга зам юм.

Гурвалсан холбоост загвараар жижиг, дунд үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх чиглэлд “SWOT” шижилгээнд тулгуурлан “TOWS” матриц байгуулж хөгжлийн богино, дунд, урт хугацааны стратегийн чиглэлийг тогтоож цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох оролдлого хийж институцын уялдаа холбоог хангах, дундын холбоосыг хөгжүүлж шинэ мэдлэг, технологи, инновацыг хөгжүүлэх эдийн засгийн нэгж буюу шинжлэх ухаан-үйлдвэр технологийн паркийг хөгжүүлэх хэрэгцээ байгаа тул кластер тогтолцоонд Монгол улсын Төрийн удирдлагын байгууллагын чиглэлээр /УИХ, ЗГ, БШУЯ, Сангийн яам, ХХААХҮЯ, ЖДҮГ, Нутгийн удирдлагын байгууллага/, Шинжлэх ухаан/боловсролын байгууллагын чиглэлээр /Шинжлэх ухааны академи, Дээд боловсролын байгууллагууд/, ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн чиглэл, институциудын хамтын ажиллагааны чиглэлээр санал, зөвлөмж боловсруулсан нь цаашид жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэхэд ажил, мэргэжлийн чиглэл, улс орон нутгийн хөгжлийн чиг баримжаа болно гэж судлаач дүгнэж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажил нь Монгол улсын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, зорилгодоо хүрсэн гэж үзэж байна. Тиймээс жижиг, дунд үйлдвэрийг кластерын тогтолцоогоор хөгжүүлэх асуудал нь эрх зүйн хувьд өнөөгийн бодит байдлын судалгаа, үнэлгээ, дүгнэлтийн үр дүн харуулж байна.

Бид энэхүү судалгааны ажлын үр дүнд дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

- Монгол улс нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, Засгийн газар, Шинжлэх ухаан, технологи, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих, Үйлдвэрлэл, технологийн эрх зүйн байдал, Хөрөнгө оруулалт, Гааль, Татвар, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хуулиудад жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх тухай заалтууд тусгагдсан байгаа хэдий ч ажлын хэрэгжилт хангалтгүй байна.
- “Алсын хараа-2050” урт хугацаа, Шинэ сэргэлт, Гурван тулгуурт хөгжил, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (2023-2037), Сүхбаатар аймгийн хөгжлийн зорилт 2020-2028 оны хөгжлийн бодлого, Сүхбаатар аймагт 2021-2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, тэргүүлэх чиглэл, Засгийн газрын 2020-2024 үйл ажиллагаа, Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдийн дагуу төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх суурь орчин байна гэж үзлээ.
- Хэдий тийм ч жижиг, дунд үйлдвэрийг кластер тогтолцоогоор хөгжүүлэх асуудал хууль эрх зүйн хувьд өнөөгийн бодит байдлын судалгаа, үнэлгээ, дүгнэлтээр хуулбарласан тунхаглалын шинж чанартай хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, түүний биелэлтэд анхаарах хэрэгтэй байна.

Жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэхийн тулд дараах алхамуудыг хийж хэрэгжүүлэх цаг үеийн шаардлага байна. Гурвалсан холбоост тогтолцооны институцын хамтын ажиллагааны хүрээнд шинжлэх ухаан, технологийн инноваци бий болгож хөгжүүлэх, дотоод нөөц бололцоонд тулгуурласан санхүүгийн шинэ эх үүсвэр, гадаад улс орнуудын болон үндэстэн дамнасан корпорацийн хөрөнгө

оруулалтыг татах нөхцлийг бүрдүүлэх; Монгол улсын хөгжлийн бодлогод тулгуурлан уул уурхайн экспортын орлогоор бусад үйлдвэрийг кластераар хөгжүүлэх боломж байна. Тухайлбал, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлийн эргэлтэд оруулах, боловсруулах, шинжлэх ухаан-технологийн парк, бүс нутгийн кластераар хөгжүүлэх боломж; Бүс нутагт бүрдсэн дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн түвшин, үйлдвэржилтийн бүтэц болон эдийн засгийн салбаруудын хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан жижиг, дунд үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх нь нэн чухал алхам гэж судалгааны ажлыг дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. Байгууллага судлал: онол-үзэл баримтлал, боть I. УБ., 2021.
2. Батбаяр Б. Үйлдвэрийн эдийн засгийн онол. УБ., 2007.
3. Батбаяр Б. Жижиг дунд бизнесийн менежмент. УБ., 2009.
4. Ганбат Б. Монгол улсад аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх чиглэлээр ҮХШХ-ноос хэрэгжүүлж буй ажлууд, УБ, 2012.
5. Даваабаяр Ц. Бөгтөр ЖДҮ жижиг, дунд үйлдвэрлэл. УБ., 2019.
6. Сэржав Б. Япон улсын жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, цаашдын хандлага. УБ., 2010.
7. Уртнасан Ц. Бүсчилсэн хөгжил: Онол практикийн судалгаа. УБ., 2014.

Нэг сэдэвт бүтээл:

8. Даваабаяр Ч. Монгол Улсын Жижиг, дунд үйлдвэрийг төрөөс дэмжих бодлогын хэрэгжилтийг судласан нь. УБ., 2016.
9. Мөнхөө Н. Монгол улсад инновацын кластерыг хөгжүүлэх боломжийн судалгаа. УБ., 2016.
10. Ундаргаа Л. Монгол улсын жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн эрсдэлийг үнэлэх аргачлал. УБ., 2019.
11. Цэдэндамба Л. Монгол Улсад хөнгөн хүнсний үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх нөхцөл байдлын үнэлгээ. УБ., 2012.

Орос хэлээр:

12. Анатольевна Б.С. Кластерная форма организации экономики: определение потенциала и направлений развития в регионах россии. 2016.
13. Васильевна К.И. Формирование и развитие кластеров малых и средних предприятий в экономическом пространстве региона /на примере кемеровской области/, 2017.
14. Делгадо М., Портер М., Стерн С., Defining clusters of related industries. Journal of Economic Geography. 2016.
15. Ефремов Э.И., Ковров Г.С., Никифорова В.В., Константинов Н.Н., Егоров. Е.Г. Издательский дом СВФУ, Кластерный подход к развитию базовых отраслей недропользования Якутии. 2017.
16. Куркудинова Е.В., Теоретические подходы к формированию региональных кластеров. 2013.
17. Станиславовна Р.А. Совершенствование механизма управления развитием экономических кластеров в регионах российской федераций. 20226
18. Юрьевия К.Т. Теория, методология и инструментарий формирования кластерной промышленной политики. 2017.

Англи хэлээр:

19. Admore Tutsirayi Nyamaka, Mario Alphonso Marais, Adele Botha, Judy Van Biljon (2020). The components of an innovation ecosystem framework for Botswana's mobile applications.
20. Afonso de Carvalho, Costa Lopes Eduardo, Magalhães Neiane Andreato, Vanessa Araújo Pessoa (2021). Triple Helix, Innovation and Technology Transfer from The Initiative of The Interested Company: Case Study of The Drug VONAU-FLASH and Its Partnership Between USP and BIOLAB SANUS PHARMACÊUTICA LTDA.
21. Akamatsu Takashi, Mori Tomoya, Osawa Minoru, Takayama Yuki, Spatial Scale of Agglomeration and Dispersion: Theoretical foundations and empirical implications.
22. Akvile Cibinskiene, Daiva Dumciuviene, Viktorija Bobinaite, Egidijus Dragašius (2021). Competitiveness of Industrial Companies Forming the Value Chain of Wind Energy Components: The Case of Lithuania.
23. Alessandro Maffioli, Rodolfo Stucchi, Carlo Pietrobelli, Victoria Castillo (1999). The Impact Evaluation of Cluster Development Programs: Methods and Practices.
24. Alexandru Manus. The Dynamic Structure of Clusters: Characteristics and Dimensions.
25. Anke Kutschke, Alexandra Rese, Daniel Baier (2016). The Effects of Locational Factors on the Performance of Innovation Networks in the German Energy Sector.
26. Bjørn T. Asheim, Lars Coenen (2004). The Role of Regional Innovation Systems in a Globalising Economy: Comparing Knowledge Bases and Institutional Frameworks of Nordic Clusters.
27. Boekholt and Thuriaux, Bogusław Bembenek., Katarzyna Kowalska. SMEs Development within Industrial Clusters – Strategic Challenge for Cluster management
28. Bogustawa Skulska, Jankowiak, A. H (2012). Innovation Sources of Economies in Eastern Asia.
29. Catalin Boja. Clusters Models, Factors and Characteristics
30. Christopher Kerry (2021). Open Innovation, Triple-Helix, Innovation Intermediaries and National Systems of Innovation.
31. Clemente Hernandez, Raul Montalvo (2012). “Entrepreneurial Clusters in China and Mexico –implications for Competitiveness.
32. Cluster development e-guide. (2019)
33. Edward M. Bergman, Edward J. Feser (2020). Industrial and Regional Clusters: Concepts and Comparative Applications.
34. Enright, M. (2000). The globalization of competition and the localization of competitive advantage: Policies towards regional clustering, in N. Hood and S Young, The globalization of multinational enterprise activity and economic development.

35. Etzkowitz H, Leydesdorff L (1995). The Triple Helix: University– Industry – Government Relations A Laboratory for Knowledge Based Economic Development.
36. Fleisher B, Hu D, McGuire W, Zhang X (2019). The Evolution of an Industrial Cluster in China, Development Strategy and Government Division, IFPRI Discussion.
37. Gashawbeza W. Bekele, Randall W. Jackson (2006). Theoretical Perspectives on Industry Clusters.
38. Gashawbeza, W., Bekele and Randall, W (2006). Theoretical Perspectives on Industry Clusters.
39. Gilles Duranton, William R. K. (2015). The Logic of Agglomeration.
40. Haifeng Qian (2014). The Evolution of Clusters and Implications for the Revival of Old Industrial Cities.
41. Igor Calzada (2020). Democratizing Smart Cities? Penta-Helix Multistakeholder Social Innovation Framework.
42. Industrial clusters as an important factor for development of micro, small and medium-sized enterprises (MSMES)
43. Jan Stejskal, Petr Hajek (2011). Competitive advantage analysis: a novel method for industrial clusters identification.
44. Jan Stejskal, Petr Hajek (2011). Competitive advantage analysis: a novel method for industrial clusters identification..
45. Joynal Abdin, MMizanur Rahman (2015). Cluster Development Models: Challenges and Opportunities.
46. Kerry Brown, John Burgess, Marion Festing, Susanne Royer, Charlotte Steffen, Jennifer Waterhouse. Towards a New Conceptualization of Clusters.
47. Kuhlman and Arnold (2008). The cluster policies whitebook.
48. Li&Fung (2010). Research Centre, Industrial Clusters Series.
49. Line Säll (2012). Clusters as Theory and Politics.
50. Local partnership, clusters and SME globalisation, Conference for Ministers responsible for SMEs and Industry Ministers Bologna. 2000.
51. Luis Farinha, João J. Ferreira. Triangulation of the triple helix: a conceptual framework.
52. Maskell Peter, Kebir Leïla (2005). What Qualifies as a Cluster Theory.
53. Melodena Stephens. Competitive Industry Clusters Analysis: A Strategy Development Toolkit.
54. Menzel M.P, Fornahl D (2010). Cluster Life Cycles – Dimensions and Rationales of Cluster Evolution.
55. Michele Bernini, Michele Barbera, Simon Adderley (2016). Industrial Clusters in England.
56. Mingchang Wu, Ibnu Siswanto, Zainal Arifin (2017). Fostering telecommunication industry development through collaboration among university, industry, and government, Elevating triple helix model of collaboration in Indonesia.

57. Naniek Utami Handayani, Andi Cakravastia, Lucia Diawati (2012). Senator Nur Bahagia. A conceptual assessment model to identify phase of industrial cluster life cycle in Indonesia.
58. Oleksandr Telizhenko, Olena Pavlenko, Viktoriya Martynets, Svitlana Rybalchenko (2019). Modeling the Influence of Cluster Components on the Economic Development of a Territory.
59. Paul Belleflamme, Pierre Picard, Jacques-François Thisse (1999). An Economic Theory of Regional Clusters.
60. Paul Krugman (1998). Development, Geography and Economic Theory.
61. Porter, E.M. (1998). Clusters and the New Economics of Competition.
62. Porter, M. (1998). Clusters and the new economics of competition, in Harvard Business Review.
63. Porter, M. (1998). The Competitive Advantage of Nations.
64. Raouf Boucekkine, Giorgio Fabbri, Salvatore Federico, Fausto Gozzi (2022). A dynamic theory of spatial externalities.
65. Rasa Viederyte, Rimantas Didziokas (2014). Cluster models, factors and characteristics for the competitive advantage of lithuanian maritime sector.
66. Ren Lu , Jing Huang, Torger Reve, Ze Jian, Mei Chen (2018). A Literature review of cluster theory: are relations among clusters important?.
67. Ron Kenett, Eitan Adres, Gilead Fortuna (2020). Regional Development in the Era of Industry 4.0 DRMJ.
68. Rosenfeld in OECD (1996).
69. Saglar B. Boldyreva, Atabek K, Alimov Rustem T, Adilchaev Danara V, Idzhilova Natalya, Chadlaeva E (2020). On the development of cluster theory.
70. Sergey Sosnovskikh, (2017). Industrial clusters in Russia: The development of special economic zones and industrial parks.
71. Sergey V. Kireev, Inna L. Litvinenko, Maria V. Zelinskaya, Asya E. Arutyunova, Svetlana V. Fateva, Victor N. Shcherbakov (2017). Economic Clusters: Concepts and Characteristic Features.
72. Sri Muljaningsih Multifiah, Ajeng Kartika Galuh (2018). Synergicity of Triple Helix Creative Economy Model in Malang.
73. Stuart D Cunningham, Mark Ryan, Greg Heam, Michael A Keane (2003). Research and Innovation Systems in the Production of Digital Content and Applications. Content and Applications, Creative Industries Cluster Study Volume III.
74. Stuart D. Cunningham, Greg Hearn, Mark Ryan, Michael A (2003). Research and Innovation Systems in the Production of Digital Content and Applications, Content and Applications, Creative Industries Cluster Study.
75. Theo J.A. Roelandt, Pim den Hertog (1998). Cluster analysis & cluster-based policy in OECD-countries.
76. Tim Kastelle, Jason Potts, Mark Dodgson (2009). The Evolution of innovation systems.

77. Timothy Finbarr Murphy (2017). Striving for innovation – A Triple Helix exploration of how one Irish college is pursuing this goal.
78. Timothy L. Faley (2016). Future Industry Cluster Design Methodology.
79. Tuomo Kinnunen, Satu Rinkinen, Jukka Majava, Jay Gillette (2016). Innovative Regional Development through Triple Helix Collaboration: A Comparative Case Study of Strategic Structures and Implementation.
80. Wanjiru Gachie (2019). Higher education institutions, private sector and government collaboration for innovation within the framework of the Triple Helix Model.
81. Y. Lilik Rudianto (2009). Competitiveness theory.
82. Zeng D. Z (2011). How Do Special Economic Zones and Industrial Clusters Drive China's Rapid Development?.
83. Ziyu Jia, Yan Jiao, Wei Zhang, Zheng Chen (2022). Rural Tourism Competitiveness and Development Mode, a Case Study from Chinese Township Scale Using Integrated Multi-Source Data.
84. Zuhui H, Jifei Y, Yu S. Stay Factors in the Industrial Transfer of Cluster: A Case Study of Children Wear Cluster of Zhili, Zhejiang, China, Systems of Innovation for Inclusive Development, International Development Research Council, Canada.

Эрх зүйн баримт бичиг:

1. Алсын хараа-2050 “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, УБ., 2020.
2. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, УБ., 2020.
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, УБ., 1995.
4. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, УБ., 2003.
5. Гурван тулгуурт хөгжлийн бодлого, УБ., 2018.
6. Даян дэлхийн тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр, УБ., 2016.
7. Дээд боловсролын тухай хууль, УБ., 2022.
8. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн гарын авлага, УБ., 2020.
9. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, УБ., 2019.
10. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр, УБ., 2019.
11. Инновацын тухай хууль, УБ., 2012.
12. Компанийн тухай хууль, УБ., 2011.
13. Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, УБ., 2001.
14. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УБ., 2020.
15. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030. УБ., 2016.
16. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ., 2010.
17. Шинэ сэргэлтийн бодлого, УБ., 2021.
18. Ногоон хөгжлийн бодлого, УБ., 2014.

19. Сүхбаатар аймгийн хөгжлийн зорилт 2020-2028 бодлогын баримт бичиг, СҮ., 2019.
20. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, СҮ., 2020.
21. Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ., 2023.
22. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, 2009.
23. Өрсөлдөөний тухай хууль, УБ., 2010.
24. Технологи дамжуулах тухай, УБ., 1998.
25. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, УБ., 1996.
26. Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого, УБ., 2017.
27. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, УБ., 2022.
28. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, УБ., 2015.
29. Үндсэн хууль, УБ., 1992.
30. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, УБ., 2020.
31. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, УБ., 2006.
32. Эдийн засагт жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр танилцуулга, Үндэсний статистикийн хороо, УБ., 2021.

Цахим эх сурвалж:

1. www.legalinfo.mn
2. www.nso.mn
3. www.sukhbaatar.nso.mn
4. www.1212.mn
5. <https://www.mongolbank.mn>
6. <https://mof.gov.mn>
7. <https://ecrc.mn>
8. <https://mas.ac.mn>
9. <https://www.meds.gov.mn>
10. <https://www.namem.gov.mn>
11. <https://www.meds.gov.mn>
12. www.spring.gov.sq
13. www.sba.gov
14. www.1ppa.ru
15. <https://static1.squarespace.com/>
16. <https://hal.archives-ouvertes.fr/>
17. <https://www.startupterrace.com/post/taiwan-s-industrial-clusters>
18. <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol201830.pdf>
19. https://www.isc.hbs.edu/Documents/resources/courses/moc-course-at-harvard/pdf/student-projects/Turkey_Automotive_2011.pdf
20. <https://1ppa.ru/mn/payment-of-taxes/что-такое-кластер-и-кластерная-политика-кластерная-теория/>

21. <https://sciendo.com/pdf/10.1007/BF03183104>
22. <http://www.clusterobservatory.eu/index.html>
23. www.proinno-europe.eu/eca
24. https://www.researchgate.net/publication/312981189_Chinese_industrial_clusters
25. www.thebeijingaxis.com
26. <https://www.vietnam-briefing.com/news/vietnam-industrial-zones-how-to-pick-location-for-your-business.html/>
27. <https://cpliz.com.vn/vietnams-industrial-zones-how-to-pick-a-location-for-your-business/>
28. <https://ifonlaysia.blogspot.com/2018/04/singapores-23-key-industries-to-be.html>
29. https://www.researchgate.net/figure/Japanese-Industrial-Cluster-Zones_fig2_229043156
30. <https://taiwantoday.tw/news.php?unit=8&post=120698>
31. <https://rujec.org/article/27988/>
32. <https://daneshyari.com/article/preview/7388595.pdf>
33. https://www.researchgate.net/publication/301958483_The_Impact_Evaluation_of_Cluster_Development_Programs_Methods_and_Practices
34. https://www.researchgate.net/publication/280005013_Cluster_Development_Models_Challenges_and_Opportunities
35. <https://www.ibm.com/docs/en/sdm/18.0.0?topic=models-building-clustering-model>
36. https://www.researchgate.net/publication/227347209_Cluster_Life_Cycles_-_Dimensions_and_Rationales_of_Cluster_Evolution
37. https://www.researchgate.net/publication/227363792_Clusters_Models_Factors_and_Characteristics
38. https://read.oecd-ilibrary.org/industry-and-services/italy-key-issues-and-policies/local-industrial-clusters-in-italy_9789264213951-11-en#page1
39. <http://web.worldbank.org/archive/website01006/WBI/IMAGES/WBI37186.PDF>
40. https://www.researchgate.net/publication/277637397_Regional_Innovation_Cluster_for_Small_and_Medium_Enterprises_SME_A_Triple_Helix_Concept
41. <http://www.nova.edu/ssss/QR/QR20/7/macia3.pdf>

ХАВСРАЛТ 1. САЛБАРЫН PESTLE+G ШИНЖИЛГЭЭ

№	Гадаад орчны хүчин зүйл	№	Дэд үзүүлэлт	Хувийн жин	Нөлөөлөл			Хамаарал	Нөлөөллийн түвшин (ач/хол) богино болон дунд хугацаанд (1 бага, 3 дундаж, 5 их)					ЖД оноо
					Хугацаа (+/-)				1	2	3	4	5	
					Богино	Дунд	Урт							
1	Улс төрийн орчин ¹	1.1	“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого <i>Монгол улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралт</i>					◆ Зорилт 3.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд, бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. - 3.3.1.Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэгчдийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулж зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно. - 3.3.3.Жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, нийтийн өмчийн хадгалалт борлуулалтын цогцолбор байгуулна. - 3.3.8.Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. - 3.3.10.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.						

¹ Улс төрийн орчны нөлөөллийг засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага болон зарим төрийн захиргааны байгууллагын түвшинд авч үзэв.

								<ul style="list-style-type: none"> - 3.3.20.Бичил, жижиг, дунд бизнест чиглэсэн санхүүгийн урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ - 3.4.2.Бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх замаар эрэлтэд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн (итгэлийн зээл, лизинг санхүүгийн шинэ төрлийн олон хэлбэрийн үйлчилгээ) бий болгоно. - ◆ Зорилт 4.5 Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. - 4.5.1.Бизнес инкубатор төвүүдийг байгуулах, тэдгээрийн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дэмжинэ. - 4.5.6.Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хөгжлийг дэмжих институтийн тогтолцоог бүрдүүлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. - 4.5.7.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэлхийн өртгийн сүлжээнд тавигддаг шаардлагуудыг хангах удирдлагын болон ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлж, технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна. - 4.5.9.Жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгож байгаа төрийн болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн санхүүжилтийг үр ашигтай болгож, оролцогч талуудын уялдааг сайжруулна. - 4.5.11.Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санал, санаачилгыг урамшуулж, дэмжих замаар кластерын хөгжлийг хангана. ◆ Зорилт 8.3 Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, бүтээмж 						
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

							<p>өндөр, тогтвортой үйлдвэртэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ</p> <ul style="list-style-type: none"> - 8.3.1.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах нөхцөлийг бүрдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. - 8.3.7.Хөдөө аж ахуйн эрчимжүүлсэн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулан, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжинэ - 8.3.8.Хөдөө аж ахуйн эрчимжүүлсэн үйлдвэрлэлд техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлнэ. - 8.3.12.Хөдөө аж ахуйн салбарын ажиллагсдын үйлдвэрлэлээ өргөтгөх, хорших санаачилгыг төрийн бодлогоор дэмжиж, ажлын байрыг тогтвортой хадгална. - 8.3.34.Стратегийн хүнс болон гол нэр төрлийн хүнсний хүн амын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс тогтвортой хангаж, мах, сүүний улирлын хамаарлыг бууруулна. - 8.3.36.Боловсруулах салбарын хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлнэ - 8.3.37.Дотоодын үйлдвэрлэлийг тарифын болон тарифын бус зохицуулалтаар хамгаалах, төрийн дэмжлэг, хөрөнгө оруулалтыг сайжруулна. 					
		1.2	Шинэ сэргэлтийн бодлого				<ul style="list-style-type: none"> ◆ 3.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ. 					

			Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралт					<ul style="list-style-type: none"> ◆ 3.5.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. ◆ 3.6.Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ. 						
	1.3		Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр					<ul style="list-style-type: none"> ◆ 3.3.13.Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. 						
	1.4		Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоол					<ul style="list-style-type: none"> ◆ 3.1.1. жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох. ◆ 3.1.2. санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг сайжруулах замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгож буй зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах, санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэх; ◆ 3.1.5. жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийг өргөтгөх, борлуулалтад дэмжлэг үзүүлэх; ◆ 4.3.4. жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд менежмент, стратеги, мэдээллийн технологи, маркетинг, хүний нөөц, компанийн засаглал, санхүү, бүртгэл, татвар, аудит, байгаль орчин, чанарын удирдлагын тогтолцоо, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, инженерийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх; 						

							<ul style="list-style-type: none"> ◆ 4.4.8. их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын оролцоо бүхий кластерыг хөгжүүлэх. ◆ 4.5.8. жижиг, дунд үйлдвэрийн кластер байгуулах, нэгдэх санал санаачилгыг дэмжиж, кластерт бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэнд нэн тэргүүнд хөнгөлөлт олгох. 						
	1.5	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого <i>Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоол</i>					<ul style="list-style-type: none"> ◆ 4.2.3.үндэсний аж үйлдвэрийн технологийг хөгжүүлэх судалгаа боловсруулалтын ажлыг дэмжих; ◆ 4.2.7.шинжлэх ухаан, технологийг инновац, бүсчилсэн хөгжил, аж үйлдвэрийн бодлоготой нягт уялдуулан хөгжүүлэх. 						
	1.6	Гурван тулгуурт хөгжлийн бодлого <i>Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолын хавсралт</i>					<ul style="list-style-type: none"> ◆ 3.2.2.16.томоохон үйлдвэр дагасан жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластер бий болгоход дэмжлэг үзүүлэх ◆ 3.4.2.7. зүүн бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх бодлогыг баримтлах; ◆ 3.9.3.7. бизнесийн кластер буюу өөр хоорондоо холбоо бүхий бизнесийн нэгжүүд, бэлтгэн нийлүүлэгчийн хамтын ажиллагааг санхүүгийн бодлогоор дэмжих; ◆ 3.9.3.8. бизнес, аж үйлдвэр, өндөр технологийн кластерууд болон бүс нутгийн ялгааг багасгах зорилгоор шинжлэх ухаан технологийн парк байгуулах; 						
	1.7	Монгол улсын					<ul style="list-style-type: none"> ◆ 3.2.1.5.Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд 						

			үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт					өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ					
		1.8	Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллагын баримтлаж буй бодлого					<ul style="list-style-type: none"> ◆ Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, дотоод худалдаа, маркетингийн бодлого боловсруулах, тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох; ◆ Мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, малын тэжээл, түүний нэмэлтийн хорио цээр, экспорт, импортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах; ◆ Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, тариалангийн эдэлбэр газрыг эргэлтэд оруулах, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх; ◆ Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах; ◆ Салбарын үйлдвэрлэлд шинэ, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах, техникийн шинэчлэлийг хийх; ◆ Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, ноос, ноолуур, арьс, ширийг гүн боловсруулах, импортыг 					

							<p>орлох, экспортын баримжаатай сүлжмэл, нэхмэл, оёмол хувцас, арьс, ширэн бүтээгдэхүүн, хэрэгслийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;</p> <p>◆ Өндөр технологийн шинэ салбаруудыг хөгжүүлэн мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих, мэдээллийн технологийн хөгжилд нийцүүлэн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан, шуурхай, ил тод байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой бодлого, зохицуулалтыг бий болгох, хэрэгжүүлэх;</p> <p>◆ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, төсвийн тооцоо, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, санхүү, төсвийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах.</p> <p>◆ Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангуулах, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр хангагдах, чанартай үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх.</p>							
		1.9	Одоогийн улс төрийн нөхцөл байдал, үйл явц				Одоогоор улс төрийн нөхцөл байдал тогтвортой байна.							
		1.10	Кластерийг дэмжих бодит байдал				<p>Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль</p> <p>◆ 18.3.Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай саналаа боловсруулж, дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр</p>							

							<ul style="list-style-type: none"> ◆ 4.4.8. их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын оролцоо бүхий кластерыг хөгжүүлэх ◆ 4.5.8. жижиг, дунд үйлдвэрийн кластер байгуулах, нэгдэх санал санаачилгыг дэмжиж, кластерт бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэнд нэн тэргүүнд хөнгөлөлт олгох. 						
	1.11	Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028 хөгжлийн бодлогын баримт бичиг					<ul style="list-style-type: none"> ◆ 1.2 Бизнес эрхлэх таатай орчин, дэд бүтцийг бүрдүүлж, нэмүү өртгийн сүлжээ бүхий технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх ◆ 1.3 Технологи, инновацид суурилсан өрсөлдөх чадвартай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн загвар аймаг болох 						
	1.12	<i>Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр</i>					<ul style="list-style-type: none"> ◆ 3.3.10 Шинэ технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлнэ. ◆ 3.3.13 Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд олгосон санхүүжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. ◆ 3.3.15 Бизнес эрхлэгчдэд бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх бизнес инкубаторын үйлчилгээг нэвтрүүлнэ. ◆ 3.3.15.2 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ◆ 3.3.16 Орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, хоршоодын бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог кластерын системээр хөгжүүлнэ. ◆ 3.3.18 Бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ 						

							шийдвэрлэж, 2024 он гэхэд Монгол Улсын ДНБ-ий 25 хувийг хангах төлөвтэй байна.						
		2.7	Ажиллах хүч				<ul style="list-style-type: none"> ◆ 2022 оны 2 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны 2128.8 мянган хүн байгаагийн 1007.7 (47.3%) мянга нь эрэгтэй, 1121.1 (52.7%) мянга нь эмэгтэйчүүд байна. ◆ Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 1263.4 (59.3%) мянга нь ажиллах хүч, 865.4 (40.7%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 56.5 (4.7%) мянгаар өсөж, өргөтгөсөн ажиллах хүчнээс гадуурх хүн ам 23.5 (2.9%) мянгаар буурсан байна. ◆ Сүхбаатар аймгийн хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 15 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны 44.0 мянган хүн байна. Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амын тоо 27.7 мянга байгаа нь 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 62.9 хувийг эзэлж байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 27.7 мянга буюу 99.3 хувь нь ажиллагчид, 0.8 мянга буюу 0.7 хувь нь ажилгүй иргэд байна. 						
		2.8	Цалин				◆ Монгол улсад дундаж цалингийн хэмжээ 2022 онд 1.4 сая төгрөгт хүрсэн нь 504.7 ам.доллартой тэнцэж байна. (ҮСХ)						
3	Нийгэм соёлын орчин	3.1	Боловсрол				◆ Монгол улсын боловсролын салбарын үндсэн үзүүлэлт 2022 оны байдлаар улсын хэмжээнд 2389 байгууллага сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 1,052.3 мянган оюутан, суралцагч суралцаж, 99.4 мянган багш, ажилчид ажиллаж байна.						
		3.2	Хүн ам				<ul style="list-style-type: none"> ◆ Монгол улсын хүн ам 3,4 сая ◆ Сүхбаатар аймгийн хүн ам 65.2 мянга 						
		3.3	Нийгмийн хандлага ба				◆ Хүн амын дийлэнх хэсэг эд материалын асуудлыг нэн тэргүүнд тавьдаг байсан бол эрүүл мэнд, эко орчин,						

			гарч байгаа өөрчлөлт					амар тайван амьдралыг чухалчилах нь нэлээдгүй болж байна.						
4	Техник, технологийн орчин	4.1	Шинжлэх ухаан					<p>Засгийн газрын бүрэн эрх</p> <ul style="list-style-type: none"> ◆ 6.1.1.шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг нь зохион байгуулах; ◆ 6.1.2.шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлон батлах; ◆ 6.1.3.шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг батлах; ◆ 6.1.4.үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх; ◆ 6.1.5.шинжлэх ухаан, технологийн салбарт мөрдөх нийтлэг дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах; ◆ 6.1.6.Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл, судалгааны ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тооцож, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; ◆ 6.1.7.төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах; <p>“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого</p> <ul style="list-style-type: none"> ◆ Зорилт 2.4.Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ. <p>“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> ◆ 2.4.15.Шинжлэх ухаан, технологийн санг олон улсын адил төстэй сангуудын жишиг, хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна. 						

							<p>“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого</p> <ul style="list-style-type: none"> ◆ 1. Нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэнэ. ◆ 2.Өндөр технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжин, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шинжлэх ухаан технологийн хувийн жинг нэмэгдүүлсэн байна. <p>“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> ◆ 2.4.2 Хувийн хэвшлийн технологийн хөгжүүлэлтийг дэмжих тогтолцоо, бүтцийг оновчтой бүрдүүлж, хөтөлбөр хэрэгжүүлнэ. ◆ 2.4.10.Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ. 								
		4.2	Технологийн төлөв байдал												
		4.3	Технологийн дэвшлийн хурд												
		4.4					<p>Засгийн газрын бүрэн эрх</p> <ul style="list-style-type: none"> ◆ 6.1.1.төрөөс инновацын талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; ◆ 6.1.2.инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах; ◆ 6.1.3.инновацын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 								

			Инноваци				<ul style="list-style-type: none"> ◆ 6.1.5.төрөөс инновацыг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах; ◆ 6.1.6.инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах; <p>“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого</p> <ul style="list-style-type: none"> ◆ 1. Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна. ◆ 2. Шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна. ◆ 5.Инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангадаг болно. <p>“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> ◆ 2.4.17.Аж ахуйн нэгж, олон нийтэд инновац, гарааны бизнес эхлүүлэх боловсрол олгох, инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, танин мэдэхүйн төрөл бүрийн агуулга бүтээх ажлыг дэмжинэ. <p>Ногоон хөгжлийн бодлого эрх зүйн баримт бичиг</p> <ul style="list-style-type: none"> ◆ 3.5.4.ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацыг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2020 онд 					
--	--	--	----------	--	--	--	---	--	--	--	--	--

								дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, 2030 онд 3 хувьд хүргэн, ногоон хөгжлийн хурдасгуур болгох; <ul style="list-style-type: none"> ◆ 3.5.5.инновац, биотехнологи, нано технологи дамжуулах, бойжуулах, нутагшуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, чанар, онцлогоороо тэргүүлсэн ногоон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх. 						
5	Хууль эрх зүйн орчин	5.1	Үндсэн хууль, 1992					<ul style="list-style-type: none"> ◆ 4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. 						
		5.2	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, 2019					<p>18 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх</p> <ul style="list-style-type: none"> ◆ 18.1.1.тухайн шатны жил бүрийн төсөвт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх зориулалтаар хөрөнгө тусгаж батлах ◆ 18.1.2.тухайн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих орон нутгийн дэд хөтөлбөрийг энэ хуулийн 10.1, 10.2, 15.1.2-т заасан бодлогын баримт бичигт нийцүүлэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих ◆ 18.3.Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай саналаа боловсруулж, дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ. ◆ 						
		5.3	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, 2022					<ul style="list-style-type: none"> ◆ 4.1.1."үйлдвэрлэл, технологийн парк" /цаашид "парк" гэх/ гэж үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх тусгайлсан нутаг дэвсгэр, бизнесийн таатай орчин, дэд бүтцийн хангамж бүхий, тодорхой салбарт үйл ажиллагаагаар харилцан уялдсан үйлдвэрлэл, технологийн цогцолборыг; ◆ 5.1.5. жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох; 						

								<p>Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <ul style="list-style-type: none"> ◆ 10.1.4.харьяалах нутаг дэвсгэртээ үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад дэмжлэг үзүүлэх; ◆ 10.1.5.харьяалах нутаг дэвсгэртээ үйлдвэрлэл, технологийн паркийн асуудлаар гарсан шийдвэр, хэрэгжүүлж байгаа төслийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлэх; 						
		5.4	Инновацийн тухай, 2012					<p>Аймаг, Нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</p> <ul style="list-style-type: none"> ◆ 11.1.1. Орон нутагтаа инновацыг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах, хамтарсан санхүүжилттэй инновацын төсөл хэрэгжүүлэх; ◆ 11.1.2. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгуулагдсан паркийн хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах нийгмийн дэд бүтэц байгуулах, суурь үйлчилгээ үзүүлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр шийдвэрлэх, паркийн захиргаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах; ◆ 11.1.3. Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацын төслийн нээлттэй шалгаруулалт зохион байгуулах, инновацын грант олгох; ◆ 11.1.4.энэ хуулийн 11.1.3-т заасныг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах; ◆ 11.1.5.инновацын үйл ажиллагааг дагнан эрхлэх үүрэгтэй орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулж ажиллуулах; 						
6	Хүрээлэн буй орчин	6.1	Ногоон хөгжлийн бодлого Монгол Улсын Их					<ul style="list-style-type: none"> ◆ 3.1.1.эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн үрэлгэн хэрэглээ, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох замаар эрчим хүчний үр ашгийг 2030 он гэхэд 20 хувь нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх 						

			Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт				<p>эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэж, тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах;</p> <ul style="list-style-type: none"> ◆ 3.1.4.хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, ногоон технологид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 2020 онд 60 хувь, 2030 онд 80 хувьд хүргэх; ◆ 3.2.10.үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх цэнгэг усны ашиглалтыг хязгаарлан, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих; 					
	6.2		Уур амьсгалын өөрчлөлт				<ul style="list-style-type: none"> ◆ Цаг агаарын эрс тэс уур амьсгал, хэт халалтаас шалтгаалан газрын доройтол, цөлжилт нэмэгджээ. Тодруулбал, Монгол орны газар нутгийн хэмжээ 76,8 хувь нь дунд болон хүчтэй цөлжилтөд өртжээ. ◆ Манай орны агаарын дундаж температур сүүлийн 80 гаруй жилд 2.25 хэмээр буюу дэлхийн дунджаас даруй 2.5 дахин нэмэгдэж, хур тунадасны хэмжээ жил бүр 8 хувиар багассан байна. ◆ Аадар бороо, хүчтэй салхи, их цас, үер, ой хээрийн түймэр гэх мэт гамшигт үзэгдэл сүүлийн 20 жилд 2 дахин нэмэгдсэн. ◆ Сүүлийн 28 жилд (1992-2020) хүлэмжийн хийн бүрэлдэхүүнд багтдаг нүүрсхүчлийн хийн агууламж 16.5 хувиар, метаны агууламж 8.8 хувиар тус тус нэмэгджээ. (судлаач Б.Саруул 2022) 					
			Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий				<p>Сүхбаатар аймгийн ГЗБЕТ-ний стратегийн зорилт</p> <ul style="list-style-type: none"> ◆ 1. Байгаль орчинд ээлтэй бус, нэгдсэн бодлого төлөвлөлтгүй хөгжлийн өнөөгийн байдлаас байгаль орчиндоо зохицсон, уламжлалт ахуй, соёлын үнэт зүйлсэд суурилсан нэгдмэл зорилго, уялдаатай, иргэдийн оролцоотой, хүний хөгжил, амьдралын чанарыг 					

			төлөвлөгөө, 2023				<p>дээшлүүлэх хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоонд шилжинэ.</p> <ul style="list-style-type: none"> ◆ 5. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг нутаг дэвсгэрийн маркетингийг хөгжүүлж, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ. ◆ 7. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг үр дагавар, аюул эрсдэлийг бууруулах арга хэмжээг бүс нутгийн онцлогт нийцүүлэн төлөвлөж газар, бэлчээр нутгийн доройтлыг бууруулж, эко системийн тэнцвэрт байдлыг удаан хугацаанд тогтвортой хангана. ◆ 8. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулна. ◆ 9. Биологийн төрөл зүйлийн амьдрах чухал орчин холбоос нутаг дахь газар ашиглалтыг зохицуулах, хамгаалах арга хэмжээг төлөвлөж, сөрөг нөлөөллийг бууруулна. 						
7	Глобал орчин	7.1	Даян дэлхийн тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр				<p>Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацад суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> ◆ I үе шат (2016-2020): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх. ◆ II үе шат (2021-2025): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг 						

							<p>нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх.</p> <p>◆ III үе шат (2026-2030): Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх.</p>						
		7.2	Дэлхийн төлөв				<p>1.Геополитик: Шүүгчгүй тоглоом</p> <p>Өрнөдийн хүч, нөлөө суларч, шинэ хүчирхэг гүрнүүд гарч ирснээр дэлхийн геополитикийн газрын зураг “шинэчлэгдэж” шүүгчгүй тоглоомын талбар мэт болно. Тоглогчдын улс төрийн үзэл бодлын ялгаа, олон талт байдал болон тэдгээрийн цэрэг, эдийн засгийн хүчин чадал нөхцөл байдлыг хүндрүүлнэ. Улмаар үйлдвэр, компаниудад сөрөг нөлөө үзүүлнэ.</p> <p>2. Дэлхийн эдийн засаг: Номхон далайн бүс рүү чиглэсэн шинэ тэнцвэрт байдал</p> <p>Эдийн засгийн хүчин чадал, нөлөө шинэ улс орнууд руу шилжиж, Ази-Номхон далайн бүс рүү чиглэсэн шинэ, даяар тэнцвэр бий болно. Европ, Япон хоёр эдийн засаг, санхүүгийн байдлаа сайжруулж, тогтвортой болгосноор АНУ болон шинээр хүч түрэн орж буй эдийн засгуудад сайнаар нөлөөлнө. Асар том хэмжээтэй, үндэстэн дамнасан үйлдвэр, корпорацууд нэмэгдэхийн хэрээх ирээдүйд хямрал гарах магадлал, эрсдэл нэмэгдэнэ. Санхүүгийн даяар засаг захиргааны загвар гол үүрэг гүйцэтгэх болно.</p> <p>3.Технологийн шинэчлэл бүхний үндэс суурь</p> <p>Техник, технологийн нээлт, шинэчлэл ирэх арав, хорин жилд бүхний үндэс суурь байх болно. Үр дүнд нь, авьяастай, чадварлаг ажилтнуудын үнэ цэнэ “тэнгэрт хадна”. Үйлдвэрлэлийн чадал, хурд асар ихээр нэмэгдсэнээр энгийн ажилчдын хувьд шударга бус</p>						

							<p>байдал гарах магадлалтай. Улмаар нийгэмд урьдчилан таамаглашгүй хүндрэл гарч болно.</p> <p>4.Нийгмийн бүтэц: Илүү их эрх мэдэлтэй, хараат бус хувь хүн</p> <p>Хувь хүний эрх чөлөө, хараат бус байдал улам бүр нэмэгдэнэ. Эдийн засаг хөгжиж, дундаж ангийнхан улам их жин дарж, мэдээллийн технологи бидний нийгмийн бүтцийг тодорхойлох болно. Иргэд, хүмүүсийн шийдвэр гаргах чадал төр, улсын эрх барих хүчнээс ч илүү нөлөөтэй болох магадлалтай.</p> <p>5.Хүн ам зүй: Өндөр настнууд, хот, хөдөлгөөн</p> <p>Наслалт, амьдралын чанар улам нэмэгдэж, төрөлт багасна. Хот дахь төвлөрөл, бөөгнөрөл түгшүүр төрүүлэхүйц хэмжээнд очиж, цагаачлал, шилжилт хөдөлгөөн дэлхийн, хүн ам зүйн томоохон асуудал болно. Эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурьт томоохон, гайхан дуу алдмаар дэвшил гарна.</p> <p>6.Нөхөн сэргээгдэх баялаг: Улам бага нөөц баялаг, илүү их өртөг</p> <p>Дэлхийн хүн ам улам нэмэгдэж, дундаж ангийнхны нэр, нөлөө өссөнөөр ойрын 20 жилд байгалийн нөөц, баялгийг улам их ухаж, ашиглах болно. Төр улс, үйлдвэр компаниудын хооронд байгалийн баялаг, нөөц, түүхий эд эзэмших тэмцэл ширүүн өрнөнө. Улмаар ердийн бус эрчим хүчний хэрэглээ нь геополитик, дэлхийн эдийн засгийн нэг хөшүүрэг, зэвсэг болно. (Стратеги судалгааны PwC фирм 2033 он хүртэлх дэлхийн хөгжил, чиг хандлага)</p>					
		7.3	Бүс нутгийн төлөв				<p>Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлсон Баруун болон Зүүн бүсийн тулгуур төв хот болон бусад аймгийн төв хотуудаар Монгол-Орос- Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт туссан төмөр зам, авто замын коридорууд дайран өнгөрч байна. Энэ нь Бүсчилсэн</p>					

							<p>хөгжлийн үзэл баримтлалтай нийцэж байгаа бөгөөд бүсийн түвшинд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд Төр, засгаас бодлогын түвшинд гурван улсын төмөр зам, авто замын төслүүдийн бүтээн байгуулалтыг цааш явуулахад түлхүү анхаарах шаардлагатай. Учир нь бүлэг 4.2-д дурдсанчлан дотоод хүчин зүйлээс улбаатай сөрөг нөлөөлийн улмаас гадаад хүчин зүйлсийг нөхцөлдүүлж, улмаар хөрөнгө оруулалт зогсонги байдал орох эсрдэлтэй юм. Нөгөө талаас Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт төмөр замын баруун болон зүүн коридорыг “судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх” гэж тусгасан. Бүсийн тулгуур 8 төв хотыг, одоогийн Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулиар 21 аймгийн төв Улсын зэрэглэлтэй хот байгаа бөгөөд 21 хотыг зэрэг хөгжүүлэх эдийн засгийн боломж хомс юм. Иймд эхний ээлжинд нийгэм, эдийн засаг, соёлын үйлчилгээгээр Улаанбаатар хоттой тэнцэхүйц буюу өрсөлдөхүйц 3-4 томоохон хотыг байршлын хувьд аль болох зангилаа цэг, нөгөө талаас гурван эдийн засгийн коридорын дагуу оновчтой сонгож, улмаар Улсын зэрэглэлтэй хот болгон түлхүү хөгжүүлэх шаардлагатай байна. Ингэснээр бүс нутгийн түвшинд гадаад болон дотоодод өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлнэ. Ингэхдээ эрх зүйн болон эдийн засагийн дараахь арга хэрэгслэлүүдийг ашиглах нь зүйтэй. Үүнд,</p> <ul style="list-style-type: none">- <i>Санхүүгийн дэмжлэг үзүүлэх.</i> Тухайлбал, Төрөөс бодлогын түвшинд сонгосон 3-4 томоохон хотод Улсын хөрөнгө оруулалтыг түлхүү хийх, татварын хөнгөлөлт үзүүлэх, ажлын байр шинээр бий болгосны урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх, тээврийн хөнгөлөлт үзүүлэх г.м.- <i>Бизнесийн орчинг сайжруулах.</i> Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллага дээрх 3-4 томоохон хотод төв ажлын байраа					
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

							<p>байгуулж, ажлын байр нэмэгдүүлсэн тохиодолд хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх.</p> <ul style="list-style-type: none">- <i>Удирдлага, зохион байгуулалтын бүтцийг сайжруулах.</i> Удирдлага, зохион байгуулалтын хувьд хуулиар олгогдох эрхзүйн хэм хэмжээг нэмэгдүүлэх, Улаанбаатар хоттой ижил эрхзүйн хэм хэмжээтэй болгох.- <i>Дэд бүтцийн үйлчилгээг сайжруулах.</i> Интернэт, эрчим хүч, зам тээвэр, агаарын тээвэр, олон улсын шууд нислэг зэрэг дэд бүтцийн үйлчилгээг түлхүү хөгжүүлэх. <p>Монгол Улс газарзүйн байршлийн давуу талаа ашиглан олон улсын түвшинд бүс нутгийн эдийн засгийн интеграци, санаачилгад идэвхтэй нэгдэх шаардлагатай байна. Тодруулбал, Монголын баруун болон төвийн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хувьд харилцан ашигтай, идэвхтэй харилцааг бий болгох бололцоотой Төв Азийн эдийн засгийн интеграци (11 улс, CAREC), мөн Монголын зүүн болон төвийн бүс нутгийн харилцан ашигтай идэвхитэй харилцааг бий болгох бололцоотой Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграци (6 улс)-д нэгдэхэд “Монгол-Орос-Хятад”-ын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хөшүүрэг болгож, одоо боловсруулж байгаа Хүн амын нутагшилт, суурьшлийн ерөнхий төсөл болон Бүсчилсэн хөгжлийн бодлого, тэдгээрийн үзэл санаатай нягт уялдуулах шаардлагатай байна. Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөрт Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх зорилт тавьсан боловч бодит байдал дээр дотоодын хөгжлийн орон зайн төлөвлөлтийн хувьд, хүн амын нутагшилт, суурьшлийн хувьд, аль бүс нутаг ямар аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар нэгдэх зэрэг стратеги тодорхой бус байгааг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох шаардлагатай байна. (М.Алтанбагана, Д.Баттогтох, Б.Хэрлэнбаяр, Г.Урантамир, “Монгол Улсын бүсчилсэн</p>					
--	--	--	--	--	--	--	---	--	--	--	--	--

							хөгжлийн бодлого боловсруулахад “Монгол-Орос-Хятад”-ын эдийн засгийн коридорын дагуух хүн амын нутагшилт, суурьшлын гео-орон зайн анализ”)						
	7.4	Цар тахал Ковид-19					<p>ЖДҮ эрхлэгчдийн бизнест ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлж буйг үнэлэх ерөнхий үнэлэмж</p> <p>◆ Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарын бизнест Ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлж, тус вирусын халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээ тэдний бизнест хэрхэн нөлөөлсөн байдлыг үнэлэхэд хатуу хөл хорионоос өмнөх үед (2020 оны 1 сараас - 11 сарын 12-ны өдрийг хүртэлх) 96.4% нь ямар нэгэн байдлаар нөлөөлсөн гэж хариулсан бол хатуу хөл хорионы үед (2020 оны 11 сарын 8-ны өдрөөс 2020 оны 12 сарын 28–ны өдрийг хүртэлх) 98.6% нь ямар нэгэн байдлаар нөлөөлсөн гэж хариулсан байдаг. Судалгаанаас хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын 69.9% маш их нөлөөлсөн, 16.2% их нөлөөлсөн, 9.3% их дунд зэрэг нөлөөлсөн гэж хариулсан байна. (Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үндэсний хэмжээний санал, асуулгын судалгааны тайлан-2020, ББДХ)</p>						
	7.5	Олон улс болон бүс нутгийн эдийн засгийн байдал					<p>◆ Орос Украины зэвсэгт мөргөлдөөн, БНХАУ-ын “Тэг ковид” бодлого, Европын эрчим хүчний түүхий эдийн хямрал, инфляцын огцом өсөлт зэрэг таамаглаагүй олон шалтгааны улмаас дэлхийн эдийн засаг хямрах эрсдэл үүссэн. Дэлхийн банк, ОУВС өнгөрсөн оны аравдугаар сард дэлхийн эдийн засгийг 2023 онд өөдрөг байхаар төсөөлсөн ч удалгүй хүлээлтээс доогуур үнэлсэн. Тухайлбал, өнгөрсөн оны аравдугаар сард ОУВС 2023 онд дэлхийн эдийн засаг 0.9 хувиар агших хамгийн муу хувилбарыг танилцуулсан. Үүнд инфляцын өсөлт, Орос Украины зэвсэгт мөргөлдөөн зэрэг хүчин зүйлс нөлөөлж буй билээ. (Д.Эрдэнэтуяа 2023)</p>						
	7.6	Монгол Улсын					<p>◆ Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар конвенц</p>						

			салбарт нэгдэн орсон гэрээ, конвенциуд					<ul style="list-style-type: none"> ◆ Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийг үүсгэн байгуулах конвенц ◆ Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц 						
ЖД оноо:														

(Эх сурвалж: Горилогчийн боловсруулалт)

A STUDY ON SMALL AND MEDIUM ENTERPRISES CLUSTER

ABSTRACT

Research background

The small and medium enterprises (SMEs) have a very important part to a country's economies and their contribution to economic development is recognized. In the modern economy, a cluster or a group of interrelated enterprises positioned or occurring closely together and a state policy and encouragement designed to it has become one of the most decisive, effective forms of enabling environment for SMEs.

Since the growth of SME clusters are commonly promoted in the traditional, and functional ways worldwide, there is a need to learn the experience of developing strategies and policy documents for the growth of SME clusters within the framework of cooperation between state and local governments, private sector, and research institutions of developed countries.

Developing Mongolia in SME cluster in an effort to restore its regional and local socio-economy results in increasing foreign and domestic cooperation and investment, introducing new technologies and innovations in production sector, and growing value-added production.

Research aim

The research aims to study the current state of the small and medium scale enterprise cluster in Mongolia on the sample of Sukhbaatar province, and develop recommendations for SMEs growth.

Research objectives

To achieve the aim, the following objectives have been set:

- To study the recent theories and concepts of cluster in the modern administrative and business management;
- To study a cluster system of small and medium enterprises, and its evaluation methodology;
- To study the international experience of cluster growth of small and medium enterprises;
- To assess a survey of local small and medium scale enterprises, and cluster system;

- To develop model, proposals and recommendations on solving problems facing in the cluster system of small and medium enterprises.

Research methods

The present research was conducted using the quantitative and qualitative research methods such as fact research, content analysis, data comparison, logical explanation, questionnaire survey, and analysis and synthesis, as well as expert evaluation, mathematical statistics, SWOT, PESTLE analysis, and SWOT matrix.

Research novelty

The novelty in the present research refers to studying the developed countries' experience of SME cluster growth, analyzing the current state of SME clusters in Mongolia, and identifying the possibilities of growing SME cluster in the country based on the classical agglomeration theory, the approaches of new economic geography, special free approaches, regional innovation system, competitiveness, and dynamic externality, and the system theory approach and 10 cluster models.

Theoretical and practical importance of research work

The research work examines the small and medium enterprise cluster as a system at the cross-disciplinary approaches, expanding the Triple-Helix Model and bringing it into scientific circulation.

The research findings and suggestions have been applied in and by the state and local government and administrates, the private sector, and non-governmental organizations, and researchers, and individuals.

Dissertation structure

The dissertation has three main chapters, seven subchapters, conclusion, references and abstract. The first chapter studied the modern theory and concept of cluster, system of SME cluster and its evaluation methodology, and international experience of SME growth. The second chapter analyses the SME cluster system in Mongolia, sampling Sukhbaatar province. Third chapter defines the problems facing to the SME cluster system, and proposes a model, and recommendations on growing the system.

Conclusion

The aim of the present research work has been deemed as achieved by studying the current growth of small and medium enterprise clusters in Mongolia and developing

suggestions and recommendations aimed at the growth of regional and local clusters. Developing SMEs in clusters will improve the regional socio-economy, reduce unemployment, increase the gross domestic product, promote the government's industrialization policy, and support SMEs in entering into the markets of developed countries and attracting their investment.

The research suggests that growing small and medium scale enterprises in Mongolia through the Triple-Helix Model meets the national properties. Growing SMEs in Mongolia using the model strongly requires the state initiative and intervention, and a clustered system is built with and by the active cooperation of scientific, educational institutions, enterprises and all the stakeholders, and the system's dynamic growth is the fundamental socio-economic basis of the country.